



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТҮҮНД
ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

АГУУЛГЫН ТОВЬЁГ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	19
ХОЁРДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН	21
ГУРАВДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ.....	31
ТАВДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРАЛ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ	76
ЗУРГАДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ	77
ДОЛДУГААР БҮЛЭГ: ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА, ТӨСӨВ, ХАВСРАН ГҮЙЦЭТГЭЖ БОЛОХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХОРИГЛОХ ЗҮЙЛ.....	80
НАЙМДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ	83

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Парламентын стратеги төлөвлөгөө баталсан улсууд.....	19
Хүснэгт 2. Гадаадын зарим орны парламентын дэгийн хуульд тусгасан хариуцлагын төрлүүд	24
Хүснэгт 3. Нэг танхимтай парламенттай улс орнуудын аж үйлдвэржилтийн бодлого эрхэлсэн байнгын хороодын эрхлэх асуудал	51
Хүснэгт 4. Улс орнуудын парламентын ажлын албаны чиг үүрэг.....	84
Хүснэгт 5. Улс орнуудын парламентын судалгааны нэгжийн зохион байгуулалтын хэлбэр....	88

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Парламентын нийт гишүүдийн тоонд байнгын хорооны гишүүдийн эзлэх хувь.....	55
Зураг 2. Байнгын хороодын эрхлэх асуудлын уялдаа	56

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Шигтгэсэн хувилбар 05.13

Bold – шинээр нэмсэн;

Bold underline - өөрчлөлт;

3 дугаар зүйл. Улсын Их Хурлын үндсэн зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, зарчим

3.1. Улсын Их Хурлын үндсэн зорилт нь ард түмний сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оршино.

3.2. Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллагын хувьд хууль тогтоох эрх мэдлийг өөрт дангаар хадгалж, төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэн, түүний үндсийг тодорхойлж, хууль тогтоох, улсын төсөв батлах, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүрэгтэй.

3.3. Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд заасан онцгой болон хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.4. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод, **эргэх холбоотой, хүртээмжтэй** байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бие даасан байдал

~~4.0. Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.~~

8 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх

8.1.9. хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо **хуулийн шаардлагад нийцүүлэн томъёолж**, холбогдох Байнгын хороонд ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хүргүүлэх;

8.1.26. ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлангаа нийтэд ил тод мэдээлэх;

8.1.27. хууль сурталчлан таниулах.

8.3. Гишүүн энэ хуулийн 21.19-д зааснаас бусад тохиолдолд саналаа биечлэн өгнө.

8.4. Хэлэлцүүлгийн явцад хуулийн төслийн үзэл баримтлалыг алдагдуулахгүй байх зорилгоор төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төсөл санаачлагч, хамтран санаачилсан бол төлөөлөх гишүүнийг оролцуулж болно.

8.5. Гишүүн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүний баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр тогтооно.

8.6. Ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон

хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод, тогтмол мэдээлнэ.

8.7.Гишүүн энэ хуулийн 8.1.21-д заасныг зөрчсөн бол:

8.7.1.хуралдааны дэг зөрчсөн үйлдэлд хуралдаан даргалагч дараах хариуцлага хүлээлгэнэ:

8.7.1.а.сануулах;

8.7.1.б.тухайн асуудал, эсхүл тухайн хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрх хасах.

8.7.2.энэ хуулийн 8.5-д заасан гишүүний хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чиглэсэн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн үйлдэлд энэ хуулийн 8.6-д заасан ирц, саналаа биечлэн өгсөн байдлын мэдээллийг үндэслэн Ёс зүйн дэд хороо дараах хариуцлага хүлээлгэнэ:

8.7.2.а.30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрх хасах;

8.7.2.б.уучлалт гуйхыг үүрэг болгох;

8.7.2.в.албан тушаалын цалинг 20 хувиар 3 сар хүртэл хугацаагаар бууруулах;

8.7.2.г.гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад энэ хуулийн 42.1-д заасан гишүүний нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх.

8.8.Хуралдаан даргалагч энэ хуулийн 8.7.1-д заасан хариуцлагыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хүлээлгэнэ. Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 8.7.2-т заасан хариуцлага хүлээлгэх тогтоол гаргана.

8.9.Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 8.7.2-т заасны дагуу хуралдах нөхцөл үүссэн бол ажлын 5 өдөрт багтаан тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

8.10.Гишүүн ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны хуралдаан тасалсан бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу түүнийг ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс хасна.

8.11.Ёс зүйн дэд хороо гишүүнд энэ хуулийн 8.7.2.г-д заасан хариуцлага хүлээлгэсэн бол түүнд хариуцлага хүлээлгэсэн сарын санхүүжилтийг нөхөн олгохгүй.

8.12.Энэ хуулийн 8.7-д заасан хариуцлагыг дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.

8.13.Төрийн байгуулалтын байнгын хороо энэ хуулийн 8.6-д заасан мэдээллийг бүртгэх, мэдээлэх журмыг Ёс зүйн дэд хорооны саналаар батална.

11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох

11.3.Улсын Их Хурлын даргыг хэлэлцүүлэггүйгээр сонгох бөгөөд гишүүн саналаа илээр гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно. Улсын Их Хурлын даргыг сонгохтой холбогдуулан нэгдсэн хуралдаанд гишүүн нэр дэвшигч болон нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгээс асуулт асууж, үг хэлж болно. Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

13 дугаар зүйл. Улсын Их Хурлын даргын бүрэн эрх

13.1.11. хууль тогтоомжийн төсөл, ~~бөдлөгын баримт бичиг~~ боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

13.1.12. ~~холбогдох Байнгын хорооны саналаар~~ Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

14 дүгээр зүйл. Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний чиг үүрэг

14.1. Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, **ийнхүү дэвшүүлснээс хойш 5 хоногийн дотор** илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

14.4. Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.4.1. Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулах;

14.4.2. Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, **нэгдсэн хуралдааны ирцийг бүрдүүлэх**;

14.4.3. Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг;

14.4.4. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

17 дугаар зүйл. Ээлжит чуулган

17.1. Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 9 дүгээр сарын 15-ны өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.

21 дүгээр зүйл. Чуулганы хуралдааны нийтлэг журам

21.20. Нам, эвслийн бүлгээс хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах шаардлагатай гэсэн санал гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд мэтгэлцээн явуулна. **Мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно.**

21.21. **Байнгын хороогоор хуулийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулах үед шаардлагатай гэж үзвэл хуралдааныг мэтгэлцээний горимд шилжүүлнэ.**

21.23. Хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд асуулт асуух нийт хугацааг ~~Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан нам, эвслийн бүлгүүдэд болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилах бөгөөд~~ **хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоохтой** холбогдох журмыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга батална.

21.32. Хуралдаан даргалагч энэ хуулийн 21.31-д заасан парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий этгээдэд албан бичиг илгээнэ. Томилох эрх бүхий этгээд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуралдаан даргалагчид ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснийг хуралдаан даргалагч хуралдаанд уншиж танилцуулна.

22 дугаар зүйл. Байнгын хороо

22.3.Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

~~22.3.6.шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 22.3.4, 22.3.5-д заасан хянан шалгах ажлын мөрөөр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой санал боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх энэ хуулийн 22.3.4, 22.3.5-д заасан хянан шалгах ажлын мөрөөр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах болон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах;~~

22.3.9.хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газраар хийлгэх;

~~22.3.10.иргэд, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;~~

22.4.Энэ хуулийн 22.3.9-д заасан зөвлөмжийг дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн зөвлөмжийг дүгнэлтийг Байнгын хорооныхоо санал, дүгнэлтэд тусгаж нэгдсэн хуралдаанд оруулна.

22.6.Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна:

22.6.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын;

22.6.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн;

22.6.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын;

22.6.4.Өргөдлийн;

22.6.5.Төрийн байгуулалтын;

22.6.6.Төсвийн;

22.6.7.Хууль зүй, хүний эрхийн;

22.6.8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн;

22.6.9.Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын;

22.6.10.Эдийн засгийн;

22.6.11.Эрүүл мэнд, нийгмийн бодлого.

23 дугаар зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ

23.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.1.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;

23.1.2.Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;

23.1.3.улсын хил хамгаалалтын бодлого, хэрэгжилт;

23.1.4.төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;

23.1.5.гадаад бодлого;

23.1.6.гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудал;

23.1.7.Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал;

23.1.8.цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого;

23.1.9.хилийн боомт, чөлөөт бүс байгуулах асуудал.

23.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.2.1.газрын хэвлийн баялгаас бусад байгалийн баялаг;

23.2.2.улсын тусгай хамгаалалттай газар;

23.2.3.геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;

23.2.4.агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;

23.2.5.цаг уур, орчны хяналтын асуудал;

23.2.6.гүний болон гадаргын усны бодлого, нөөц, усны бохирдол;

23.2.7.хог хаягдал, дахин боловсруулалт;

23.2.8.байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал;

23.2.9.байгаль орчны судалгаа, хөгжил;

23.2.10.ан агнуур.

23.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.3.1.боловсрол;

23.3.2.биеийн тамир, спорт;

23.3.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил;

23.3.4.мэргэжлийн боловсрол, сургалт;

23.3.5.соёл, урлаг;

23.3.6.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого;

23.3.7.шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний бодлого;

23.3.8.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого.

23.4.Өргөдлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.4.1.иргэн, байгууллагаас Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах, бусад хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хамаарах Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд хороо, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, түүнчлэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах бодлогын асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх саналыг нэгдсэн хуралдаанд оруулах;

23.4.2.нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар цахим хэлбэрээр гаргасан иргэдийн өргөдлийг холбогдох Байнгын хороотой хамтран хэлэлцэх;

23.4.3.иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах, бусад хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хамаарах эсэхийг хянан үзэж, хамаарахгүй өргөдлийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;

23.4.4.хүний хувийн мэдээлэлд хамаарах асуудлаар иргэнээс гаргасан өргөдлийг судлан шаардлагатай бол Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Засгийн газар, холбогдох бусад байгууллагад албан бичгээр хандах;

23.4.5. өргөдөл, гомдол хүлээн авах, бүртгэх, ангилах, гишүүнд хуваарилах, цахим систем ажиллуулах талаар дотоод зохион байгуулалтын журам батлах.

23.5. Төрийн байгуулалтын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.5.1. Монгол Улсын Үндсэн хуулийн шинэтгэлийн асуудал;

23.5.2. төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;

23.5.3. Монгол Улсын Үндсэн Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүний улс төрийн өндөр мэргэшилтэй эсэх асуудал;

23.5.4. засаг захиргааны шинэтгэл, төвлөрлийг сааруулах бодлого;

23.5.5. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, хот, тосгоны Зөвлөл, Захирагчийн сонгууль;

23.5.6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, хот, тосгоны эрх зүйн үндэс;

23.5.7. нутгийн өөрөө удирдах ёс;

23.5.8. төрийн алба;

23.5.9. төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;

23.5.10. ард нийтийн санал асуулга;

23.5.11. төр, сүм хийдийн харилцаа;

23.5.12. хэвлэл мэдээллийн хараат бус байдал;

23.5.13. төрийн бус байгууллага, улс төрийн нам;

23.5.14. Улсын Их Хурлын хууль тогтоомж;

23.5.15. гишүүний халдашгүй байдал, бүрэн эрх, түүний баталгаа;

23.5.16. бүсчилсэн хөгжлийн бодлого;

23.5.17. гишүүний ёс зүй, сахилга, гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;

23.5.18. Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох асуудал;

23.5.19. чуулганы хуралдааны дэг болон дэг сахиулах асуудал;

23.5.20. төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого.

23.6. Төсвийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.6.1. улсын нэгдсэн төсөв;

23.6.2. улсын төсвийн орлого, зарлага, төсвийн хяналт;

23.6.3. төрийн санхүү, зээл, тусламжийн болон татварын бодлого;

23.6.4. Засгийн газрын тусгай сангийн нэгдсэн бодлого;

23.6.5. Улсын Их Хурлын төсвийн төлөвлөлт;

23.6.6. гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл;

23.6.7. аудитын асуудал;

23.6.8. төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал.

23.7. Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.7.1. Үндсэн хуулийн дэг журам, иргэний үндсэн эрх, эрх чөлөө, эрх зүйн бодлого;

23.7.2.хүний эрх, түүний баталгаа;
23.7.3.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого;
23.7.4.хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;

23.7.5.шүүх эрх мэдлийн эрх зүйн үндэс, хараат бус байдлыг хангах асуудал;

23.7.6.хууль сахиулах, мөрдөн шалгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурорын үйл ажиллагаа;

23.7.7.нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;

23.7.8.эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргаан, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа;

23.7.9.өршөөл үзүүлэх асуудал;

23.7.10.патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг;

23.7.11.цагаачлал, иргэний харьяалал;

23.7.12.архив;

23.7.13.эрх зүйн туслалцаа;

23.7.14.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;

23.7.15.улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах асуудал;

23.7.16.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны журам, гишүүний томилгоо.

23.8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.8.1.бэлчээр, тариалангийн газрын бодлого;

23.8.2.хүнсний хангамж, баталгаат байдал, хүнсний үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт;

23.8.3.жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.8.4.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.8.5.хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн логистик, дэд бүтэц;

23.8.6.үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;

23.8.7.хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;

23.8.8.хөдөөгийн хөгжлийн бодлого;

23.8.9.газар тариалан, мал аж ахуй, үрийн аж ахуйн бодлого;

23.8.10.газар тариалан, малын даатгалын бодлого;

23.8.11.малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах.

23.9.Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.9.1.дижитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;

23.9.2.цахим дэд бүтэц;

23.9.3.мэдээллийн технологийн хөгжил;

23.9.4.шуудан, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;

23.9.5.хиймэл оюуны хөгжил;

23.9.6.хиймэл оюуны бодлого, хяналт, зохицуулалтын асуудал.

23.10.Эдийн засгийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.10.1.эдийн засгийн дотоод, гадаад бодлого;

23.10.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;

23.10.3.төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа;

23.10.4.банк бус санхүүгийн харилцаа, энэ хуулийн 23.6.8-д зааснаас бусад үнэт цаас;

23.10.5.энэ хуулийн 23.8.10-д зааснаас бусад даатгалын бодлого;

23.10.6.төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого;

23.10.7.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;

23.10.8.шударга өрсөлдөөний бодлого;

23.10.9.төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;

23.10.10.стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт;

23.10.11.албан ёсны статистикийн үйл ажиллагаа;

23.10.12.барилга, орон сууц, нийтийн аж ахуй;

23.10.13.аялал жуулчлалын хөгжлийн бодлого;

23.10.14.аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил;

23.10.15.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого;

23.10.16.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

23.10.17.хүнд үйлдвэрлэлийн логистик, дэд бүтэц;

23.10.18.газрын тос, байгалийн хийн асуудал;

23.10.19.ашигт малтмал, түүний суурь судалгаа, хайгуул, ашиглалтын

бодлого;

23.10.20.түлшний хангамж, нөөцийн бодлого;

23.10.21.эрчим хүчний нэгдсэн бодлого;

23.10.22.зам, тээвэр;

23.10.23.газрын сангийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, бүртгэл;

23.10.24.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого.

23.11.Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

23.11.1.эрүүл мэндийн бодлого;

23.11.2.хүн амын хөгжлийн бодлого;

23.11.3.хүн ам зүй, гэр бүлийн бодлого;

23.11.4.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа;

23.11.5.жендэрийн тэгш байдлыг хангах бодлого;

23.11.6.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого.

25 дугаар зүйл.Байнгын хорооны бүрэлдэхүүн

25.1.Байнгын хороо эз 21 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болно. */Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./*

25.2.Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлахдаа Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцаа болон нам, эвслийн Улсын Их Хуралд авсан суудлын хувийг харгалзана.

25.3.Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн зөвхөн нэг Байнгын хороонд харьяалагдана.

~~25.4.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн өөрийн эрхлэх асуудал нь хамаарах Байнгын хорооны бүрэлдэхүүнд оржгүй.~~

25.5.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, ~~бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй~~ байна.

25.7.Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс өөнгөх бөгөөд түүнийг улируулан сонгож болно сонгоно.

25.8.Байнгын хорооны даргыг дахин болон улируулан сонгох бол энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан сонгоно.

~~25.8-25.9.~~

~~25.9-25.10.~~

26 дугаар зүйл.Байнгын хорооны даргын чиг үүрэг

26.1.Байнгын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.1.1.Байнгын хорооны хуралдааны **ирцийг бүрдүүлж**, бэлтгэлийг хангаж, зохион байгуулах;

26.1.2.Байнгын хорооны өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, хуралдааныг удирдах;

26.1.5.Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах **бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад үед нэгдсэн хуралдаанд заавал оролцож Байнгын хорооны эрхлэх асуудалтай холбоотой асуултад хариулах;**

27 дугаар зүйл.Дэд хороо

27.3.Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна:

27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын; ~~27.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бөхирдлийн, Хүнс, хөдөө аж ахуйн;~~

27.3.3.Төрийн байгуулалтын байнгын хороонд ~~Бүтэцлэсэн хөгжлийн~~, Ёс зүйн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын;

27.3.4.Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын;

27.3.5.Хууль зүйн **Хууль зүй, хүний эрхийн** байнгын хороонд Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын, Хүний эрхийн; */Энэ заалтын "Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын" гэснийг 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./*

~~27.3.6.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд Боловсрол, шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын;~~

27.3.7.Эдийн засгийн байнгын хороонд ~~Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын.~~ */Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./*

~~27.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ.~~

27.5.Энэ хуулийн 27.3-т заасан дэд хороо дараах асуудлыг эрхэлнэ:

~~27.5.1.Агаар, орчны бөхирдлийн дэд хороо агаар, хөрс, усны бөхирдлийг бууруулах талаарх бодлогын асуудлыг;~~

~~27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг;~~

~~27.5.3.Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо боловсрол, шинжлэх ухааны нэгдсэн бодлогын асуудлыг;~~

~~27.5.4.Бүсчилсэн хөгжлийн дэд хороо бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг;~~

27.5.5.Ёс зүйн дэд хороо гишүүний ёс зүй, сахилга, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэг сахиулах асуудлыг;

~~27.5.6.Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын асуудлыг;~~

~~27.5.7.Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо ондор технологи, үндэсний инновацыг дэмжих, хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, цахим хөгжлийн бодлогын асуудлыг;~~

~~27.5.8.Соёл, спорт, залуучуудын дэд хороо соёл, урлаг, түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого, нийтийн биеийн тамир, спортын асуудлыг;~~

27.5.9.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг;

27.5.10.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;

27.5.11.Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг;

27.5.12.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;

27.5.13.Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх ажиллагаа болон энэ зорилгоор явуулж байгаа тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад гүйцэтгэх ажил /мөрдөн шалгах нууц ажиллагаа/-ын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг; */Энэ заалтыг 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./*

27.5.14.Хүний эрхийн дэд хороо хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын бодлогын асуудлыг;

~~27.5.15.Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хүнс, хөдөө аж ахуйн бодлого, хөтөлбөр, хөдөө аж ахуйн хөршөөны асуудлыг; /Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./~~

27.6.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулна.

27.7.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын **болон Ёс зүйн** дэд хороодоос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёرنы нэгээс илүүгүй байна.

27.8.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон есөн гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг баримтална. **Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно.**

27.9.Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд төөцнө **чөлөөлөх**

тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд уншиж сонгосноор тогтоол баталсанд тооцно.

27.10. Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно. Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно.

27.11. Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба түүнийг улируулан сонгож болно. Дэд хорооны даргыг улируулан сонгохдоо энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан сонгоно. Дэд хорооны дарга хуралдааны ирцийг бүрдүүлж, бэлтгэлийг хангаж, зохион байгуулах, хуралдаан удирдах болон холбогдох Байнгын хороонд ажлаа хариуцан тайлагнах үндсэн чиг үүрэгтэй.

27.14. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын ~~дэд хорооны дүрмийг Төрийн байгуулалтын хөрөө~~ болон Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар Улсын Их Хурал батална.

27.15. Дэд хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн орохгүй.

27.16. Дэд хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдох Байнгын хорооны үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлнэ.

27.17. Дэд хорооны дарга долоо ба түүнээс дээш хоногоор түр эзгүй байх тохиолдолд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар үүргийг нь дэд хорооны аль нэг гишүүнд орлуулан гүйцэтгүүлнэ. Хэрэв долоогоос доош хоногоор эзгүй байх тохиолдолд дэд хорооны дарга албан үүргээ өөр гишүүнд түр хариуцуулна.

28 дугаар зүйл. Хянан шалгах түр хороо

28.1. Хянан шалгах түр хороог Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу байгуулна.

28.2. Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.

29 дүгээр зүйл. Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ын бүлэг

29.7. ~~Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн бол тухайн бүлгийн дарга нь, гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонгоно.~~ Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн, эсхүл гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухай бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонгоно.

29.15. Бүлгийн даргыг шинээр сонгосон бол энэ талаарх бүлгийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснийг ажлын 5 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонгосноор шинээр сонгогдсон бүлгийн даргын эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.

30 дугаар зүйл. Бүлгийн эрх, үүрэг

30.1. Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

~~30.1.2. нэгдсэн хуралдаанд бүлгийг төлөөлж асуулт асуух, хариулах, үг хэлэх гишүүнийг томилох;~~

~~30.2. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 30.1.2-т заасны дагуу томилогдсонөө бусад тухайн бүлгийн гишүүд нэгдсэн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхгүй.~~

30.3. Бүлгийн ажлын албаны цалин, албан томилолт, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

30.4. Бүлгийн төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.

30.5. Бүлэг Улсын Их Хурлын үйл ажиллагааны хүрээнд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө хариуцахгүй.

30.6. Бүлгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

30.6.1. бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хуралдаан удирдах;

30.6.2. бүлгийг төлөөлж энэ хуулийн 30.1.5-д заасан завсарлага авах бөгөөд түүний эзгүйд бүлгийн аль нэг дэд дарга уг эрхийг хэрэгжүүлэх;

30.6.3. энэ хуулийн 30.1.9-д заасан ажлын хэсэг байгуулах;

30.6.4. энэ хуулийн 30.1.12-т заасан горимын санал гаргах;

30.6.5. Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах хүрээнд хэлэлцэж байгаа аливаа асуудлаар Улсын Их Хурал дахь улс төрийн зөвшилцлийг хангах арга хэмжээ авах;

30.6.6. Байнгын, дэд бүрэлдэхүүнд орохоор гишүүний гаргасан хүсэлтийг энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан энэ хуулийн 30.1.6-д заасны дагуу шийдвэрлэх;

30.6.7. энэ хуулийн 30.1.7-д заасан тайланг жил бүр бүлгийн хуралдаанд танилцуулах;

30.6.8. энэ хуулийн 30.1.8-д заасны дагуу хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах.

37 дугаар зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх

37.1. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх журмыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

38 дугаар зүйл. Улсын Их Хурлын нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлах

38.1. Улсын Их Хурал чуулганы хуралдаан, хэлэлцэх асуудлын тов, дараалал болон үйл ажиллагааныхаа талаарх мэдээ, мэдээллийг нээлттэй, ил тод мэдээлнэ.

38.2.Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хэлэлцүүлгийн явц болон баталсан хууль тогтоомжийн зохицуулалт, ач холбогдлыг хууль санаачлагч гишүүн, ажлын хэсэг, Байнгын хорооны дарга тайлбарлан таниулж мэдээлэл хийнэ.

38.3.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрийнхээ талаарх мэдээллийг нэгтгэн сар бүр нээлттэй мэдээлнэ.

38.4.Улсын Их Хурал ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойш Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг олон нийтэд сурталчлан таниулж, мэдээлэх ажлыг зохион байгуулж болно.

38.5.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байна. Улсын Их Хурал энэ хуулийн 38.1-д заасан мэдээ, мэдээллийг нийтэд дамжуулахдаа дохионы хэл, товч бичгэн тайлбар (титр) зэргийг оруулж тусгай хэрэгцээт иргэдэд мэдээллийг хүргэнэ.

38.6.Энэ хуулийн 38.5-д заасны дагуу хүртээмжийг хангах асуудлыг Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа холбогдох журамд тусган хэрэгжүүлнэ.

38.7.Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх нээлттэй мэдээллийг Улсын Их Хурлын дарга, гишүүн, нам, эвслийн бүлгийг төлөөлөн дарга, дэд дарга, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны дарга, Тамгын газрын холбогдох албан тушаалтан Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг ашиглан хийнэ.

38.8.Энэ хуулийн 38.7-д зааснаас бусад этгээд Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг нийтэд мэдээлэл хийхээр ашиглахыг хориглоно.

38.9.Иргэд, дотоод, гадаадын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжилга хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

39 дүгээр зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авах, хэлэлцэх

39.1.Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг /цаашид “нийтийн өргөдөл” гэх/ цахим системээр хүлээн авч болно.

39.2.Нийтийн өргөдлийг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 болон 8-д заасан Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд гаргана.

39.3.Улсын Их Хурал дараах үндэслэлээр нийтийн өргөдлийг хүлээн авахгүй:

39.3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, дэг журамд илт нийцээгүй;

39.3.2.улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдалд харшилсан;

39.3.3.бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалсан;

39.3.4.өргөдөлд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа;

39.3.5.хувийн асуудлаар гаргасан;

39.3.6.нийтийн өргөдлийн цахим системд байршуулж санал авч байгаа нийтийн өргөдөлтэй агуулга нь давхцсан;

39.3.7.энэ хуулийн 39.5-д заасан тоонд хүрч, Байнгын хороо хэлэлцэж эхэлсэн нийтийн өргөдөлтэй агуулга нь давхцсан;

39.3.8.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан төсвийн орлогын доод, зарлагын дээд хэмжээнд нөлөөлөхүйц нийтийн өргөдөл.

39.5.Нийтийн өргөдлийг цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах ба уг өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал дараах тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ:

39.5.1.хуулийн төсөл санаачлах саналыг 100,000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол;

39.5.2.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах саналыг 70,000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол;

39.5.3.тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах саналыг 33,000 ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн бол. Энэ хэсгийн дугаарт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.

39.7.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал иргэдийн санал Цахим гарын үсгийн тухай хуулийн¹ 4.1.3-т заасан тоон гарын үсгээр баталгаажсан байна. **Нийтийн өргөдөлд иргэний санал авахдаа танилт, нэвтрэлтийн систем ашиглан баталгаажуулна.**

39.8.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл улс орны нийгэм, эдийн засаг, эсхүл цаг үеийн шинжтэй хэлэлцэж байгаа хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, харилцаа холбооны хэрэгслээр иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж болно.

39.9.Нийтийн өргөдлийг цахим системээр хүлээн авахтай холбоотой журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална.

41 дүгээр зүйл.Гишүүний бүрэн эрхийн баталгаа

~~41.9.Хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, гишүүнээр сонгогдохоосоо өмнө оршин сууж байсан газартаа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн гишүүний замын зардал, ачаа, тээшний хөлсийг авто тээврийн тарифаар төөцөж олгоно.~~**Гишүүний бүрэн эрх дуусгавар болсон бол Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1-д заасны дагуу тэтгэмж олгох бөгөөд тэтгэмж олгохтой холбогдсон журмыг энэ хуулийн 47.4-т заасан захирамжаар батална.**

42 дугаар зүйл.Гишүүний төсөвт зардал, цалин, бусад хангамж

~~42.5.Гишүүн батлагдсан төсөвт зардалдаа багтаан зөвлөх, туслах ажиллуулж бөлөх бөгөөд тойргоос сонгогдсон гишүүн, бие төлөөлөгч туслахтай байж болно.~~**бие төлөөлөгч-туслах тус бүр нэгийг ажиллуулж болно.** Гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.

¹ Цахим гарын үсгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

42.9.Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол Засгийн газрын гишүүний цалин хангамжийг авах эсхүл Улсын Их Хурлын гишүүний цалингийн аль нэгийг өөрөө сонгох бөгөөд Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаатай холбоотой төсөвт туссан бусад зардлыг захиран зарцуулах эрхтэй.

42.11.Гишүүн ~~нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол~~ хэлэлцэх асуудлын тов, дараалалд орсон ажлын хэсэг, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, санал хураалтад биечлэн оролцоогүй бол түүнд тасалсан өдрийн цалинг олгохгүй.

44 дүгээр зүйл.Гишүүнд хориглох үйл ажиллагаа

44.2.Гишүүн энэ хуулийн 41.2, 44.1.11-д заасан чуулганы хуралдаанд, эсхүл хуралдаанаас гадуур бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж, доромжилсон бол иргэний маргааны журмаар шүүхэд хандаж болно.

46 дугаар зүйл.Тамгын газар, түүний эрхлэх ажил

46.4.Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж нь газар, хэлтэс, алба, хүрээлэн, парламентын номын сан, музей байна.

46.5.Тамгын газар дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ:

46.5.5.~~хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн зөвлөмж гаргах; Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт гаргах;~~

46.5.6.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх;

46.5.6.дараах үнэлгээ, дүн шинжилгээ хийх:

46.5.6.а.өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэр хянах шатанд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланд үнэн бодит байдлын үнэлгээ хийх;

46.5.6.б.хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн шатанд тухайн төсөлтэй холбогдуулан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Байнгын хорооны хүсэлтээр хийх;

46.5.6.в.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13.2-т заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;

46.5.6.г.хуульд заасан холбогдох байгууллагын тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;

~~46.5.7.Улсын Их Хурлаар тухайн жилийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл хэлэлцэхэд дүн шинжилгээ хийж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;~~

46.5.25.Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд зориулан энгийн, ойлгомжтой, богино хэмжээний дүрс, бичгэн болон зурган зэрэг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх;

46.5.25**46.5.26.**

46.6.Тамгын газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална. Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй, албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

48 дугаар зүйл.Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрх

48.1.14.энэ хуулийн 22.3.9-д заасан зөвлөмж гаргах хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх журам, хууль тогтоомжийн төслийн эхийг барьж ажиллах зөвлөхөд тавих тусгай шаардлагыг батлах;

48.2.Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг Байнгын хороо дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

48¹ дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэргэдэх хүрээлэн

48¹.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааг дэмжих зорилгоор хууль тогтоох болон төрийн бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох баримт мэдээлэл бэлтгэх, парламентат ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг бүхий хүрээлэн Улсын Их Хурлын дэргэд ажиллана.

48¹.2.Хүрээлэнгийн дүрэм, бүтэц, орон тоог Улсын Их Хурлын дарга батлах бөгөөд хүрээлэнгийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэл, цалингийн хэмжээг энэ хуулийн 46.7, 46.8-д заасны дагуу тогтооно.

ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
3.4.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.	3.4.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод, эргэх холбоотой, хүртээмжтэй байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Төлөөлөх бүрэн эрхийн гол норматив шаардлагын нэг нь хариу үйлдэл (responsiveness) болон хариуцлага (accountability)-ын асуудал юм. Хариу үйлдэл гэдэг нь төлөөлөгч төлөөлж буй хүмүүсийнхээ хүсэл зориг, ашиг сонирхолд мэдрэмжтэй хандаж, тэдгээрт нийцүүлэн үйл ажиллагаа явуулах чадварыг илэрхийлдэг. Харин хариуцлага гэдэг нь төлөөлөгчдийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох институцийн механизм бодитоор оршин байхыг хэлнэ. Энэ хоёр хэмжээс нь хоорондоо нягт холбоотой боловч бүрэн давхцахгүй. Жишээлбэл, төлөөлөгч нь албан ёсны хариуцлагын механизмгүй нөхцөлд ч сонгогчдын хүсэл зоригт нийцүүлэн үйл ажиллагаа явуулж болох бол нөгөө талаас төлөөлөгч хэлбэр төдий байдлаар хариуцлага хүлээх боломжтой боловч бодит байдал дээр сонгогчдын бодит ашиг сонирхолд төдийлөн анхаарал хандуулдаггүй байж болно.²

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
4 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бие даасан байдал 4.9.Улсын Их Хурал өөрийн стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.	4 дүгээр зүйл.Улсын Их Хурлын бие даасан байдал

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Дэлхий дахинд нэг ба хоёр танхимтай 188 үндэсний парламент байдгаас парламентын стратеги төлөвлөгөө баталсан улс харьцангуй цөөн байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд, парламентын стратеги төлөвлөгөөтэй Өмнөд Африк, Пакистан, Шотланд, Тринидад ба Тобаго, Монгол Улс зэрэг цөөн тооны улс орнууд байна. Харин парламентын түвшин бус, парламентын тамгын газар буюу ажлын алба нь стратеги төлөвлөгөө батлан хэрэгжүүлдэг мөн цөөн тооны улс байгаа бөгөөд үүнд, Кени, Канад, Тайланд, Австрали, Бангладеш зэрэг улсууд хамаарна.³

Хүснэгт 1. Парламентын стратеги төлөвлөгөө баталсан улсууд

№	Улс	Засаглалын хэлбэр	Стратегийн баримт бичиг	Баримт бичгийн хугацаа	Зорилго/зорилт/ стратегийн тоо
1	Өмнөд Африк	Парламентын БНУ	Парламентын стратеги төлөвлөгөө (7 дахь парламент)[1]	2024-2029	4 стратегийн тэргүүлэх чиглэл, 5 үр дүн
2	Пакистан	Парламентын БНУ	Үндэсний Ассамблейн стратеги[2]	2019-2023	2 үндсэн зорилго, 12 тодорхой стратегийн зорилт

² ПСХХ. (2026). Парламентын гишүүний төлөөлөх бүрэн эрх, түүний хэрэгжилтийн талаарх зарим улс орны харьцуулалт. (СТ-26/214). х.8.

³ ПСХХ. (2026). Парламентын тогтолцоотой, парламентын стратеги төлөвлөгөө баталдаг орнуудын харьцуулалт (СТ-26/204) х.2.

3	Шотланд (Их Британи)	Парламентын хаант засаг (децентрал)	6 дахь чуулганы стратеги[3]	2021-2026	4 стратегийн зорилт
4	Тринидад ба Тобаго	Парламентын БНУ	Парламентын стратеги (түүхэн)[4]	2013-2018	4 стратегийн зорилт
5	Монгол	Парламентын БНУ	Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө[5]	2024-2028	5 стратегийн зорилго

ХОЁРДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН БҮРЭЛДЭХҮҮН

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх 8.1.9.хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо холбогдох Байнгын хороонд ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хүргүүлэх;</p>	<p>8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх 8.1.9.хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоо хуулийн шаардлагад нийцүүлэн томъёолж, холбогдох Байнгын хороонд ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хүргүүлэх;</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Өмнөд Африк⁴: Гишүүдийн гаргах санал нь Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомж болон парламентын дэгд нийцсэн байх ёстой бөгөөд хуулийн төслийг Үндсэн хуулийн болон дэгийн хувьд "журам зөрчсөн" (out of order) байдалд оруулахуйц нэмэлт, өөрчлөлт гаргахыг хориглодог байна.

Шинэ Зеланд⁵: Хуулийн төсөлд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн тухайн хуулийн төслийн сэдэвтэй холбоотой, хуулийн зарчим, объектод нийцсэн байх ёстойгоос гадна парламентын дэг болон танхимын үйл ажиллагааны практикт бүрэн нийцсэн байх шаардлагатай байдаг.

Франц⁶: Үндсэн хуулийн заалттай харшлах буюу Үндсэн хуулийн Зөвлөлөөс хүлээж авах боломжгүй гэж үзсэн санал, нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэгт оруулахаас шууд татгалздаг байна.

Япон⁷: Хуулийн төсөлд оруулах гишүүний санал нь төсөв нэмэгдүүлэх эсхүл төсвийн арга хэмжээ шаардахаар бол уг нэмэлт өөрчлөлтийн улмаас гарах зардлыг тодорхойлсон бичгээрх мэдэгдэл /тооцоолол/-ийг заавал хавсаргаж өгөх шаардлагатай байдаг.

Македон⁸: Хэрэв нэмэлт, өөрчлөлтийн саналд санхүүгийн хэрэгсэл шаардагдах зохицуулалт тусгасан бол санал гаргагч гишүүн нь уг санхүүжилтийг гаргах боломжтой эх үүсвэрийн талаарх тайлбарыг заавал ирүүлэх үүрэг хүлээдэг.

ОХУ⁹: Хуулийн төсөл болон санал санаачлахад тухайн хуулийг баталснаар гарах материаллаг зардлын талаарх санхүү-эдийн засгийн үндэслэлийг заавал хавсаргах шаардлагатай.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх -</p>	<p>8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх 8.1.26.ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн ажлын тайлангаа нийтэд ил тод мэдээлэх; 8.1.27.хууль сурталчлан таниулах.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Орчин үеийн парламентууд (Герман, Япон, Өмнөд Солонгос, Итали г.м) парламентын үйл ажиллагааг иргэдэд илүү нээлттэй болгохын тулд дараах механизмуудыг ашиглаж байна. Үүнд:

⁴ Өмнөд Африк: (2016). “Үндэсний Ассамблейн тухай хууль”, Хандах:

https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf

⁵ Шинэ Зеланд: (2023). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах:

<https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

⁶ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁷ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах:

<https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

⁸ Македон: (2013). “Бүгд Найрамдах Македон Улсын Ассамблейн хуралдааны дэгийн тухай хууль”

Хандах: https://www.sobranie.mk/rules-procedures-of-the-assembly-ns_article-rules-of-procedure-of-the-assembly-of-the-republic-of-macedonia.nspx

⁹ ОХУ: (1998). “Оросын холбооны улсын төрийн думын регламент”. Хандах:

<http://duma.gov.ru/duma/about/regulations/>

- парламентын хуралдааны телевиз болон цахим шууд дамжуулалт;
- парламентын албан ёсны цахим хуудас;
- парламентын боловсролын хөтөлбөр;
- олон нийтийн лекц, уулзалт;
- сошиал медиа харилцаа зэрэг багтдаг.

Эдгээр механизм нь иргэд парламентын үйл ажиллагааг ойлгож, парламентын гишүүдийн үйл ажиллагааг хянах боломжийг нэмэгдүүлдэг бөгөөд төлөөллийн ардчиллын ил тод байдлыг бэхжүүлдэг¹⁰.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх -	8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх 8.3.Гишүүн энэ хуулийн 21.19-д зааснаас бусад тохиолдолд саналаа биечлэн өгнө.
-	8.4.Хэлэлцүүлгийн явцад хуулийн төслийн үзэл баримтлалыг алдагдуулахгүй байх зорилгоор төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд төсөл санаачлагч, хамтран санаачилсан бол төлөөлөх гишүүнийг оролцуулж болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын гишүүн өөрийн санал өгөх эрхээ бусдад шилжүүлэхгүй, заавал биечлэн оролцож саналаа өгөх нь олон улсын парламентуудын нийтлэг бөгөөд хатуу баримталдаг зарчим байна.

ОХУ (Төрийн Дум)¹¹: Төрийн Думын Регламентийн 85 дугаар зүйлийн 2-т "Депутат санал өгөх эрхээ өөрийн биеэр хэрэгжүүлнэ. Депутат санал хураалтад биечлэн оролцох шаардлага нь холбооны хуулийг батлах дэгийн гол элемент бөгөөд заавал дагаж биелүүлнэ" хэмээн маш хатуу хуульчилсан байна.

Эстони¹²: Парламентын дэгийн 80 дугаар зүйлд "Рийгикогу (Парламент)-ын гишүүд биечлэн санал өгнө" (Voting in person) гэж шууд заасан байна.

Швейцар¹³: Үндэсний Зөвлөлийн хуралдааны дэгийн 56 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Төлөөлүүлж санал өгөхийг хориглоно" (Voting by proxy is not permitted) гэж заасан байна.

Франц¹⁴: Үндсэн хуулийн 27 дугаар зүйлд "Парламентын гишүүний санал өгөх эрх нь хувийн чанартай (биечлэн) байна" хэмээн тунхагласан байдаг бөгөөд зөвхөн маш онцгой тохиолдолд л органик хуулиар саналын эрхийг шилжүүлэхийг зөвшөөрдөг байна.

Япон¹⁵ болон БНСУ (Солонгос)¹⁶: Японы дэгийн 135 дугаар зүйлд "Санал хураах үед танхимд байхгүй гишүүн санал өгөх эрхгүй" гэж, харин БНСУ-ын хуулийн 111 дүгээр зүйлийн 1-д "Санал хураах үед хуралдаанд оролцоогүй гишүүн санал хураалтад оролцохгүй" гэж тус тус зааж, биеэр байх шаардлагыг тавьдаг байна.

¹⁰ ПСХХ. (2025). Парламентын гишүүний төлөөлөх бүрэн эрх, түүний хэрэгжилтийн талаарх зарим улс орны харьцуулалт (СТ-26/214). х.13

¹¹ ОХУ: (1998). "Оросын холбооны улсын төрийн думын регламент". Хандах: <http://duma.gov.ru/duma/about/regulations/>

¹² БНЭстУ (2003). "Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль". Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/521032019014/consolide>

¹³ Швейцар (2003) Standing Orders of the National Council. Хандах: <https://www.fedlex.admin.ch/eli/cc/2003/514/en>

¹⁴ Франц: (2025). "Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай" хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

¹⁵ Япон: (1947). "Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль". Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

¹⁶ БНСУ (2020) "Үндэсний Ассамблейн тухай хууль". Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх	8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх
-	8.5.Гишүүн хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн гишүүний баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмээр тогтооно.
-	8.6.Ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, энэ хуульд заасан хариуцлага хүлээсэн эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод, тогтмол мэдээлнэ.
-	8.7.Гишүүн энэ хуулийн 8.1.21-д заасныг зөрчсөн бол: 8.7.1.хуралдааны дэг зөрчсөн үйлдэлд хуралдаан даргалагч дараах хариуцлага хүлээлгэнэ: 8.7.1.а.сануулах; 8.7.1.б.тухайн асуудал, эсхүл тухайн хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрх хасах. 8.7.2.энэ хуулийн 8.5-д заасан гишүүний хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чиглэсэн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн үйлдэлд энэ хуулийн 8.6-д заасан ирц, саналаа биечлэн өгсөн байдлын мэдээллийг үндэслэн Ёс зүйн дэд хороо дараах хариуцлага хүлээлгэнэ: 8.7.2.а.30 хүртэл хоногоор хуралдаанд асуулт асуух, үг хэлэх эрх хасах; 8.7.2.б.уучлалт гуйхыг үүрэг болгох; 8.7.2.в.албан тушаалын цалинг 20 хувиар 3 сар хүртэл хугацаагаар бууруулах; 8.7.2.г.гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын цалингийн зардлаас бусад энэ хуулийн 42.1-д заасан гишүүний нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх.
-	8.8.Хуралдаан даргалагч энэ хуулийн 8.7.1-д заасан хариуцлагыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу хүлээлгэнэ. Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 8.7.2-т заасан хариуцлага хүлээлгэх тогтоол гаргана.
-	8.9.Ёс зүйн дэд хороо энэ хуулийн 8.7.2-т заасны дагуу хуралдах нөхцөл үүссэн бол ажлын 5 өдөрт багтаан тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
-	8.10.Гишүүн ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны хуралдаан тасалсан бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу түүнийг ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнээс хасна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын гишүүний ёс зүй, зан төлөвийн хэм хэмжээг тусгайлсан "Ёс зүйн дүрэм"-ээр батлан мөрдүүлэх нь олон улсад хэдийн тогтсон сайн туршлага байна.

Австрали¹⁷: Парламентын дэгдээ тусгайлан "Австралийн Парламентын гишүүдийн зан төлөвийн дүрэм" (Behaviour Code for Australian Parliamentarians)-ийг 2024 онд шинэчлэн баталсан бөгөөд үүнд гишүүд бие биеэ хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх, бэлгийн дарамтаас сэргийлэх зэрэг хэм хэмжээг нарийвчлан тусгаж өгсөн байна.

Канад¹⁸: Канад улсын хувьд "Ёс зүйн дүрэм"-ийг Парламентын дэгийнхээ салшгүй хэсэг (Хавсралт) болгон баталдаг бөгөөд "Нийтийн танхимын гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийн дүрэм" (Хавсралт 1), "Нийтийн танхимын гишүүдийн хоорондын бэлгийн дарамтаас сэргийлэх ёс зүйн дүрэм" (Хавсралт 2) гэж төрөлжүүлэн баталж мөрддөг байна.

Франц¹⁹: Үндэсний Ассамблейн дэгийн 80-1 дүгээр зүйлд зааснаар Парламентын Товчоо (Bureau) нь гишүүдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх зарчмуудыг тодорхойлсон "Ёс зүйн дүрэм" (code de déontologie) баталдаг бөгөөд хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий тусгай "Ёс зүйн ажилтан" (déontologue)-ийг томилж ажиллуулдаг байна.

Энэтхэг²⁰: Парламентын дэгийн 316В дүгээр зүйлд Ёс зүйн хороо нь гишүүдийн "Ёс зүйн дүрэм" (Code of Conduct)-ийг боловсруулж, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах үндсэн чиг үүрэгтэй байна.

Улс орнуудын туршлагыг харахад хуралдааны дэг зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг:²¹

- сануулах;
- хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;
- хуралдаанд оролцох эрхийг хасах;
- торгох;
- бусад гэж ангилж байна.

Хүснэгт 2. Гадаадын зарим орны парламентын дэгийн хуульд тусгасан хариуцлагын төрлүүд

№	Хариуцлагын төрөл	Австрали: Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэг	Герман: Бундестагийн хуралдааны дэг	ОХУ: Холбооны Хурлын Төрийн Думын регламент	Өмнөд Солонгос: Үндэсний Ассамблейн тухай хууль	Япон: Парламентын тухай хууль Зөвлөхүүдийн танхимын хуралдааны дэг	Сингапур: Парламентын тухай хууль Хуралдааны дэг	Франц: Үндэсний Ассамблейн хуралдааны дэг
1	Сануулах	тусгагдаагүй	Хэлэлцэж буй асуудалтай холбоогүй үг хэлэх, дэг зөрчвөл 1 удаа	Регламентын заалтыг зөрчвөл сануулах	Нээлттэй хуралдаан дээр сануулга өгөх	сануулга өгөх, үг хэлэх эрхийг нь хязгаарлах, хэлсэн үгээ татаж авахын аль нэгийг шаардана	тусгагдаагүй	Ерөнхийлөгч /ҮА-ийн дарга/ сэдвээрээ ярихыг сануулна Ерөнхийлөгч дэг сахихыг сануулна
2	Хуралдаанд үг хэлэх эрхийг хасах	тусгагдаагүй	3 удаа сануулга авсан бол	Үг хэлэх хугацааг дуусгавар болгох	Сануулгыг дагах мөрдөхгүй бол үг хэлэх		Үг хэлэх хугацааг дуусгавар болгох	Сануулга авсан гишүүн чуулганы

¹⁷ Австрали Улс (2025) "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах:

https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

¹⁸ Канад Улс (2025) The Standing Orders of the House of Commons. Хандах:

<https://www.ourcommons.ca/procedure/standing-orders/index-e.html>

¹⁹ БНФУ (2025). "Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай" хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

²⁰ Энэтхэг Улс (2024). "Rules of procedure and conduct of business in Lok Sabha". Хандах: https://sansad.in/uploads/Rules_of_Procedures_E_9d8fd0f4c3.pdf?updated_at=2022-

²¹ ПСХХ. (2025). Парламент дахь намын бүлгийн гишүүний үйл ажиллагааг үнэлэх аргачлал (СТ-25/402) х.19, 21

					эрхийг хасна			хуралдааны төгсгөл хүртэл үг хэлэх эрхгүй
3	Хуралдаанд оролцох эрхийг хасах	Спикерийн захирамжийг дагахгүй бол 1 цаг, 24 цаг түүнээс дээш хугацаагаар түдгэлзүүлэх	30 хүртэл хоногоор оролцуулахгүй байж болно	тусгагдаагүй	30 хүртэл хоногоор хуралдаанд суухыг хориглох	шаардлага биелүүлэхгүй бол уг хуралдааны өдөр дуусах хүртэл, эсхүл маргааш өдрийг дуустал -30 хоног хүртэл	тухайн өдрийн хуралдаанаас гарахыг шаардах эрхтэй, татгалзсан тохиолдолд чуулганы хугацааг дуусах хүртэлх хугацаагаар	15 хоногийн хугацаанд ордонд хүрэлцэн ирэхийг хориглоно. Давтан хариуцлага хүлээх бол хугацааг 30 хоног хүртэл сунгана
4	Торгох	тусгагдаагүй	Дотоод дэг журам, нэр хүнд зөрчсөн гишүүн 1000 евро, давтан гаргасан бол 2000 еврогоор торгуулна	тусгагдаагүй	- Сануулга, уучлалт хүсэх үед цалингийн 2/1 - 30 хоног оролцох эрхийн хассан бол 3 сарын цалин олгохгүй	тусгагдаагүй	-50 000 доллар хүртэл, - Хуралдаанд оролцох эрхээ хасуулсан өдрийн цалинг олгохгүй	- Дэг сахиулахыг сануулсан тухай тэмдэглэл нь гишүүний цалингийн 1/4-ийг 1 сарын турш - 1 удаагийн энгийн зэмлэл 1 сарын турш цалингийн хагасаар - зэмлэл болон түр түдгэлзүүлсэн бол 2 сарын турш цалингийн хагсаар - санал хураалтад саад хийвэл 1 сарын цалингийн 1/4, давтан үйлдвэл 6 сар болж сунгагдана
5	Бусад хариуцлага	Гишүүнийг нэрлэх болон түдгэлзүүлэх	тусгагдаагүй	тусгагдаагүй	Нээлттэй хуралдаан дээр уучлалт хүсэх	-Нэгдсэн чуулганы нээлттэй хуралдаан дээр уучлалт хүсэх	-Гишүүнийг нэрлэх, -Баривчлах, хорих, -Гишүүнийг огцруулах	-Хуралдааны тэмдэглэлээр шаардлага тавина -ҮХ-ын Ерөнхийлөгч /ҮА-ийн дарга/-ийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй бол дээрх хугацааг 6 сар хүртэл сунгана

Түүнчлэн, улс орнуудын парламентын гишүүдийн ёс зүйн зөрчил болон ёс зүйн ноцтой зөрчлийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалбал:²²

Герман Улсын хувьд сахилгын арга хэмжээг гишүүн дэг зөрчсөн тохиолдолд Бундестагийн Ерөнхийлөгч тухайн гишүүнд анхааруулга өгөх, үг хэлэх эрхийг хасах (§36), ноцтой, давтан зөрчилд хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, мөнгөн торгууль ногдуулах арга хэмжээ авч болно (§37). Мөн ашиг сонирхлын ил тод байдлын үүргийг зөрчсөн тохиолдолд парламентын гишүүнд албадлагын торгууль ногдуулж болох бөгөөд торгуулийн хэмжээ нь жилийн цалингийн 50 хүртэл хувь байж болно (Бундестагийн гишүүний тухай хууль §44a(3)).

Шинэ Зеланд Улсын хувьд Сахилгын арга хэмжээг Төлөөлөгчдийн танхимын дэг зөрчсөн тохиолдолд Хуралдаан даргалагч анхааруулга өгөх (§94), нэр дурдаж сануулах (§95), эсхүл парламентын шийдвэрээр хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх арга хэмжээ авч болно (§96).

Япон Улсын хувьд сахилгын арга хэмжээг Парламентын тухай хуульд зааснаар гишүүн дэг зөрчсөн тохиолдолд зэмлэх, хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх зэрэг арга хэмжээ авч болно.

Өмнөд Солонгос Улсын хувьд Парламентын гишүүн зөрчил гаргасан тохиолдолд сануулга өгөх, уучлал хүсүүлэх, хуралдаанд оролцох эрхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл парламентын гишүүнээс хөөх арга хэмжээ авч болно (§163). Түдгэлзүүлэх зохицуулалтын хувьд хуралдаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх хугацаа ердийн тохиолдолд 30 хүртэл хоног, харин ашиг сонирхлын хориг зөрчсөн тохиолдолд 90 хүртэл хоног байж болох бөгөөд энэ хугацаанд гишүүний тэтгэмжийг бууруулдаг (§163).

Итали Улсын хувьд сахилгын арга хэмжээг ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн Ёс зүйн дүрэмд заасны дагуу хөрөнгө, орлого, ашиг сонирхлын мэдүүлэг, парламентын гадуурх үйл ажиллагааны талаарх мэдээллийг засах, дутуу мэдүүлсэн мэдээллийг нөхөн гаргуулах, мөн зөрчлийг олон нийтэд ил тод зарлах зэрэг арга хэмжээ авч болно (§2-6, §7)".

Парламентын гишүүний төсөв зарцуулах эрхийг зогсоох чиглэлээр зарим орнуудын туршлагыг харьцуулвал:

Франц Улсад парламентын дэг зөрчиж, сануулах арга хэмжээ авхуулсан, энэ нь тэмдэглэлд үлдсэн бол гишүүний парламентын нэмэгдлийн (indemnity) дөрөвний нэгийг 1 сарын хугацаагаар хасдаг. Сануулга авсан тохиолдолд нэмэгдлийн тал хувийг 1 сараар, харин хуралдаанаас түр хугацаагаар хөөх (түдгэлзүүлэх) хариуцлага тооцуулбал нэмэгдлийн тал хувийг 2 сараар (ноцтой тохиолдолд 6 сар хүртэл) хасдаг. Мөн санал хураалтад шударга бусаар хандвал нэмэгдлийн тодорхой хувийг 1-ээс 6 сарын хугацаатайгаар хасах шийтгэлтэй байдаг.²³

БНСУ (Өмнөд Солонгос): Сахилгын зөрчил гаргаж, хуралдаанд оролцох эрхээ 30 хүртэлх хоногоор (зарим тохиолдолд 90 хоног) хасуулсан гишүүний хууль тогтоох болон онцгой үйл ажиллагааны нэмэгдэл, бусад зардлыг тухайн хугацаанд 50 хувиар бууруулж олгодог. Илүү ноцтой зөрчил гаргасан гишүүнд сарын нэмэгдлийн 50 хувийг 2 сарын хугацаанд хасах, эсвэл 3 сарын хугацаанд бүх нэмэгдэл, зардлыг олгохгүй байх (олгогдсон бол буцаан татах) шийтгэл ногдуулна. Түүнчлэн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хурал тасалсан тохиолдолд тасалсан өдрийн тоотой тэнцэх хэмжээний дүнг тусгай үйл ажиллагааны зардлаас нь суутгадаг байна.²⁴

Их Британи Улсад парламентын үйл ажиллагаанд оролцох эрхээ хасуулсан (түдгэлзүүлсэн) гишүүний цалинг тухайн шийтгэлийн хугацаанд бүрэн олгохгүй зогсоодог. Мөн

²² ПСХХ. (2026). Парламентын гишүүдийн ёс зүйн зөрчил болон ёс зүйн ноцтой зөрчлийн эрх зүйн зохицуулалт- зарим улсын туршлага (СТ-26/212) х.8-12

²³ Франц: (2025). "Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай" хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

²⁴ Өмнөд Солонгос Улс (2020) "Үндэсний Ассамблейн тухай хууль". Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

бусдыг дарамтлах, танхайрах зэрэг зөрчил гаргавал гишүүнийг хуралдаанаас хөөгөөгүй байсан ч цалин, нэмэгдлийг нь олгохгүй байх, түүнчлэн гишүүнд үзүүлэх үйлчилгээ, төсөв хэрэгслийг (services and facilities) хасах, аялал томилолтын эрхийг нь хязгаарлах зэрэг санхүүгийн болон хангамжийн шийтгэл ногдуулж болдог.²⁵

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх	8 дугаар зүйл.Гишүүний бүрэн эрх 8.11.Ёс зүйн дэд хороо гишүүнд энэ хуулийн 8.7.2.г-д заасан хариуцлага хүлээлгэсэн бол түүнд хариуцлага хүлээлгэсэн сарын санхүүжилтийг нөхөн олгохгүй.
-	8.12.Энэ хуулийн 8.7-д заасан хариуцлагыг дэс дараалан хэрэглэхийг шаардахгүй.
-	8.13.Төрийн байгуулалтын байнгын хороо энэ хуулийн 8.6-д заасан мэдээллийг бүртгэх, мэдээлэх журмыг Ёс зүйн дэд хорооны саналаар батална.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Польш Улсын Парламент нь үйл ажиллагааныхаа ил тод, хариуцлагатай байх зарчмын хүрээнд хууль тогтоох үйл явц, парламентын шийдвэр, хуралдааны явцыг олон нийтэд нээлттэй хүргэх мэдээллийн тогтолцоо бүрдүүлсэн байдаг. Энэхүү тогтолцоо нь парламентын сайт, чуулганы тэмдэглэл, хууль тогтоомжийн мэдээллийн сан, хуралдааны зураг, протокол болон баримт бичгийн ил тод байдал зэрэг олон сувагт тулгуурладаг. Ийнхүү парламентын баримт мэдээллийг тогтмол нийтэлснээр иргэд болон хэвлэл мэдээллийн байгууллагад хууль тогтоох үйл явцын талаарх үнэн зөв, баталгаатай эх сурвалжаар хангах зорилго хэрэгждэг (Sejm of the Republic of Poland, 2024).²⁶

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох 11.3.Улсын Их Хурлын даргыг хэлэлцүүлэггүйгээр сонгох бөгөөд гишүүн саналаа илээр гаргаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.	11 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох 11.3.Улсын Их Хурлын даргыг сонгохтой холбогдуулан нэгдсэн хуралдаанд гишүүн нэр дэвшигч болон нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгээс асуулт асууж, үг хэлж болно. Улсын Их Хурлын даргыг сонгох асуудлаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.
13 дугаар зүйл.Улсын Их Хурлын даргын бүрэн эрх 13.1.11.хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах; 13.1.12.холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;	13 дугаар зүйл.Улсын Их Хурлын даргын бүрэн эрх 13.1.11.хууль тогтоомжийн төсөл, боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах; 13.1.12.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах;

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын дарга, спикерт нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэхийг зөвшөөрдөг дараах улсууд байна. Гэхдээ зарим улс мэтгэлцээнийг хатуу хориглодог байна:

ОХУ (Төрийн Дум): Төрийн Думын Регламентийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "хүн бүрийг хэлэлцэх үед нэр дэвшигчид үг хэлж, Төрийн Думын депутатуудын асуултад хариулна.

²⁵ Их Британи (2026) Standing Orders of the House of Commons - Public Business. Хандах: <https://www.parliament.uk/business/publications/commons/standing-orders-public11/>

²⁶ ПСХХ. (2025). Парламентын хэвлэл мэдээллийн нэгжийн эрх зүйн зохицуулалт (СТ-25-426) х.10

Нэр дэвшүүлсэн бүлэг бүрийн төлөөллүүд нэр дэвшигчийг дэмжсэн, эсхүл эсрэг үг хэлэх эрхтэй бөгөөд үүгээр хэлэлцүүлэг дуусна" гэж заасан байна.²⁷

Австрали: Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар Спикерт нэр дэвшүүлсэн болон дэмжсэн гишүүн тус бүр 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно. Хэрэв 2 эсхүл түүнээс дээш хүн нэр дэвшвэл бусад гишүүд 5 минутын хугацаатайгаар мэтгэлцээнд оролцож үг хэлэхийг зөвшөөрдөг.²⁸

Канад: Нийтийн танхимын дэгийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд сонгууль явуулахын өмнө нэр дэвшигчдийг 5 хүртэлх минут үг хэлэхийг урьдаг. Гэсэн хэдий ч дэгийн 4 дүгээр зүйлийн 13-т сонгуулийн үйл явцын үед аливаа мэтгэлцээн (debate) өрнүүлэхийг хатуу хориглосон байдаг.²⁹

Шинэ Зеланд³⁰ болон Сингапур³¹ (Шууд хориглосон): Шинэ Зеландын дэгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3-т "Парламентын даргыг сонгох тухай асуулт тавихгүй, ямар ч мэтгэлцээн явуулахгүй" гэж, Сингапурын дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2-т саналын талаар "мэтгэлцээн явуулахыг хориглоно" гэж шууд заасан байна.

Байнгын хорооны үйл ажиллагаагаар дамжуулан парламентын гишүүд сонгогчдыг хууль тогтоох үйл явцад шууд оролцуулах боломжтой болдог бөгөөд энэ нь иргэдэд "институцийн хүрээнд шийдвэр гаргах үйл явцад шууд нэвтрэх боломж" олгодог гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Иймээс байнгын хороод нь парламент болон нийгмийн хоорондын институцийн гүүр болж, төлөөлөх бүрэн эрхийг нэгдсэн хуралдаанаас илүү нарийвчилсан шинжилгээ, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг байна³².

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>14 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний чиг үүрэг</p> <p>14.1.Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.</p>	<p>14 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний чиг үүрэг</p> <p>14.1.Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, ийнхүү дэвшүүлснээс хойш 5 хоногийн дотор илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.</p>
<p>14.4.Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.4.1.Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулах;</p> <p>14.4.2.Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>14.4.3.Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг;</p>	<p>14.4.Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>14.4.1.Байнгын, дэд хороо, нам, эвслийн 14.4.1.Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулах;</p> <p>14.4.2.Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих, нэгдсэн хуралдааны ирцийг бүрдүүлэх;</p>

²⁷ ОХУ (1998). "Оросын холбооны улсын төрийн думын регламентийн тухай хууль". Хандах: <http://duma.gov.ru/duma/about/regulations/>

²⁸ Австрали Улс (2025) "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах: https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

²⁹ Канад Улс (2025) The Standing Orders of the House of Commons. Хандах: <https://www.ourcommons.ca/procedure/standing-orders/index-e.html>

³⁰ Шинэ Зеланд (2023). "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах: <https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

³¹ Сингапур Улс (2017). "Парламентын дэгийн тухай" хууль. Хандах: <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf>

³² ПСХХ (2026). Парламентын гишүүний төлөөлөх бүрэн эрх, түүний хэрэгжилтийн талаарх зарим улс орны харьцуулалт (СТ-26/214) х.11

14.4.4.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.	14.4.3.Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг; 14.4.4.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Гадаад орнуудын парламентад дэд даргыг (эсхүл түүнтэй дүйцэх албан тушаалтныг) сонгох хугацааг дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

Эстони (дараагийн ажлын долоо хоногийн эхний хуралдаанаар сонгох): Парламентын (Рийгикогу) дэд дарга нарын бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд дараагийн ажлын долоо хоногийн чуулганы нэгдсэн хуралдааны эхний өдөр дэд дарга нарын ээлжит бус сонгуулийг явуулна гэж заасан байна. Энэ нь манай "5 хоногийн дотор" гэсэнтэй хамгийн ойр буюу богино хугацаанд, тодорхой үе шаттайгаар товлон явуулах зохицуулалт юм.³³

Канад (Хугацаа заахгүйгээр "нэн даруй/хойшлуулалгүй" сонгох): Нийтийн танхимын дэд дарга бөгөөд бүх нийтийн хорооны даргын орон тоо гарсан тохиолдолд танхим залгамжлагчийг хойшлуулалгүйгээр (forthwith буюу нэн даруй) сонгох ажиллагааг эхлүүлнэ гэж заасан байна.³⁴

Өмнөд Африк (Хугацаа заахгүйгээр "нэн даруй/хойшлуулалгүй" сонгох): Дэд даргыг сонгох шаардлага гарсан үед Парламентын дарга Үндэсний Ассамблейд мэдэгдэх бөгөөд үүний дагуу танхим нэн даруй (immediately), эсхүл Парламентын даргын зарласан цагт сонгуулийг явуулна³⁵. Энэтхэг (Парламентын дарга хугацааг товлох): Дэд даргыг сонгох сонгуулийг Парламентын даргын товлосон өдөр явуулах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэ өдрийн тухай мэдэгдлийг гишүүн бүрд урьдчилан илгээнэ³⁶.

Австрали (Орон тоо гарсан үед тухай бүр сонгох): Төлөөлөгчдийн танхимын дэд дарга болон хоёрдугаар дэд даргыг парламент бүрийн эхэнд, эсхүл холбогдох албан тушаалын орон тоо гарсан аль ч үед сонгоно.³⁷

Гадаад орнуудын парламентын хууль, дэгийн тухай хуульд "Дэд дарга нь хуралдааны ирцийг биечлэн бүрдүүлнэ" гэж шууд тусгайлсан заалт нийтлэг биш байгаа бөгөөд олон улсын практикт нэгдсэн хуралдааны ирцийг хангах, бүрдүүлэх асуудлыг дараах байдлаар зохицуулсан байна:

1. Хамтын удирдлагын (Удирдах зөвлөлийн) хүрээнд ирцийг хянах:

Герман Улс: Бундестагийн нэгдсэн хуралдааныг даргалагч (Ерөнхийлөгч эсхүл түүнийг орлож буй Дэд ерөнхийлөгч) болон хурлын хэрэг хөтлөгч нар хамтран "Хуралдааныг удирдах зөвлөл"-ийг бүрдүүлдэг бөгөөд гишүүдийн ирц бүрдсэн эсэхэд эргэлзээ гарвал энэхүү Удирдах зөвлөл ирц бүрдсэн эсэхийг тоолж тогтоодог байна.³⁸

Македон: Ассамблейн дарга болон дэд дарга нар нь хамтдаа Ассамблейн гишүүнийг ажиллах нөхцөлөөр хангах, чуулганы динамикийг төлөвлөх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.³⁹

³³ БНЭстУ (2003). "Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль". Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/521032019014/consolide>

³⁴ Канад Улс (2025) The Standing Orders of the House of Commons. Хандах: <https://www.ourcommons.ca/procedure/standing-orders/index-e.html>

³⁵ Өмнөд Африкын Бүгд найрамдах Улс (2016). "Үндэсний Ассамблейн тухай хууль", Хандах: https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf

³⁶ Энэтхэг Улс (2024). "Rules of procedure and conduct of business in Lok Sabha". Хандах: https://sansad.in/uploads/Rules_of_Procedures_E_9d8fd0f4c3.pdf?updated_at=2022-

³⁷ Австрали Улс (2025) "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах: https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

³⁸ Герман Улс (2024). "Холбооны бүгд найрамдах герман улсын бундестагийн хуралдааны дэг". Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>

³⁹ Македон Улс (2013). "Бүгд Найрамдах Македон Улсын Ассамблейн хуралдааны дэгийн тухай хууль" Хандах: https://www.sobranie.mk/rules-procedures-of-the-assembly-ns_article-rules-of-procedure-of-the-assembly-of-the-republic-of-macedonia.nspх

2. Хуралдаан даргалах үедээ ирцийн бүрдлийг хариуцах:

Ихэнх улс орнуудад Дэд дарга нь зөвхөн Парламентын даргыг эзгүй үед хуралдааныг орлон даргалахдаа ирцийн асуудлыг хариуцдаг.

Өмнөд Солонгос: Даргын түр эзгүйд дэд дарга түүний чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд нэгдсэн хуралдааны ирц (нийт гишүүдийн 1/5) бүрдээгүй тохиолдолд хуралдааныг өндөрлөсөн, эсхүл завсарлуулсан тухайгаа хуралдаан даргалагч зарладаг.⁴⁰

Австрали: Танхимын ирц хангалтгүй байгааг аль нэг гишүүн сануулбал Спикер (түүнийг орлож буй дэд спикер) ирц тоолуулах тухай зарлан зохион байгуулдаг.⁴¹

3. Ирц бүрдүүлэх бодит ажлыг "Намын бүлэг" хариуцах (Whip-ийн тогтолцоо):

Олон улсын парламентат ёсны жишигт гишүүдийг хуралдаанд оруулах, ирцийг бүрдүүлэх үндсэн ажлыг намын бүлгийн удирдлага, тусгайлан томилогдсон зохион байгуулагчид хариуцдаг байна. Австрали: Парламентад "Олонхын зохион байгуулагчдын дарга" (Chief Government Whip) болон "Сөрөг хүчний зохион байгуулагчдын дарга" гэсэн тусгайлсан албан тушаалтнууд байх бөгөөд тэдгээр нь намын гишүүдийнхээ ирц, сахилга батыг хариуцдаг байна (Chief Government Whip).

⁴⁰ Өмнөд Солонгос Улс (2020) "Үндэсний Ассамблейн тухай хууль". Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁴¹ Австрали Улс (2025) "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах: https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

ГУРАВДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>17 дугаар зүйл.Ээлжит чуулган 17.1.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 9 дүгээр сарын 15-ны өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.</p>	<p>17 дугаар зүйл.Ээлжит чуулган 17.1.Улсын Их Хурлын намрын ээлжит чуулган 9 дүгээр сарын 10-ны өдрөөс, хаврын ээлжит чуулган 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 75-аас доошгүй ажлын өдөр чуулна.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын Парламентын дэгийн тухай хуулийг харвал, парламентын ээлжит чуулган, хуралдааны эхлэх хугацааг тогтоохдоо ижил бус, өөр өөр эрх зүйн болон зохион байгуулалтын загвар хэрэглэж байна. Зарим улс парламентын чуулганы эхлэх, дуусах хугацааг хуульд тодорхой товлон заасан байдаг бол зарим нь төрийн тэргүүн, парламентын дарга, эсхүл холбогдох байгууллагын шийдвэрээр тухай бүр товлон зарлах уян хатан зохицуулалттай байна. Нэгдүгээрт, чуулганы эхлэх хугацааг хуульд нарийвчлан, тогтмол хуанлийн хэлбэрээр тогтоосон улс орнуудын хувьд тодорхой огноо, гараг бүхий хатуу зохицуулалт үйлчилж байна. Эстони Улсад парламентын хаврын чуулган жил бүрийн 1 дүгээр сарын хоёр дахь Даваа гарагт, намрын чуулган 9 дүгээр сарын хоёр дахь Даваа гарагт тус тус эхэлдэг⁴². Франц Улсад парламентын ээлжит чуулган жил бүрийн 10 дугаар сарын эхний ажлын өдөр эхэлдэг⁴³ бол Өмнөд Солонгос Улсад ээлжит чуулган жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдөр эхлэхээр шууд заасан бөгөөд хэрэв энэ өдөр амралтын өдөр таарвал дараагийн өдөр эхэлдэг.⁴⁴ Үүнээс гадна ээлжит бус буюу тусгай чуулганыг 2, 3, 4, 5 дугаар саруудад, мөн 6 дугаар сарын 1, 8 дугаар сарын 16-ны өдөр зарлан хуралдуулж болохоор тусгайлан зохицуулсан нь парламентын үйл ажиллагааг жилийн турш тасралтгүй, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн явуулах боломжийг хангасан зохицуулалт байна.

Хоёрдугаарт, чуулганы эхлэх хугацааг төрийн тэргүүн эсхүл эрх бүхий албан тушаалтны албан ёсны акт (зарлиг, тунхаглал, шийдвэр)-аар тухай бүр тогтоодог улс орнуудын хувьд тодорхой нэг тогтмол огноо хуульд заагдаагүй, харин шийдвэрээр тогтоогддог онцлогтой. Япон Улсад парламентын чуулган Эзэн хааны зарлигт заасан өдөр эхлэх бөгөөд тухайн өдөр өглөөний 10:00 цагт хуралдаан нээгддэг.⁴⁵ Сингапур Улсад парламентын чуулган Ерөнхийлөгчийн Газет (Gazette)-д нийтэлсэн тунхаглалд заасан өдөр, цагт эхэлдэг бөгөөд өдөр тутмын хуралдаан нь ихэвчлэн 13:30 цагт эхэлдэг.⁴⁶ Австрали Улсад шинэ парламент анх цуглах болон шинэ чуулган эхлэх хугацааг Ерөнхий амбан захирагч тухай бүр тунхаглан тогтоодог тул урьдчилан тогтсон тодорхой огноо байдаггүй.⁴⁷ Өмнөд Африк Улсад парламентын анхны чуулганы эхлэх өдөр, цагийг Хуралдаан даргалагч зарладаг бөгөөд өдөр тутмын хуралдаан Даваагаас Пүрэв гарагт 14:00 цагт, Баасан гарагт 09:00 цагт эхэлдэг тогтмол хуваарьтай байна.⁴⁸ Гуравдугаарт, парламентын хуралдааны эхлэх хугацааг жилийн төлөвлөлт, хуралдааны хуанлиар дамжуулан тодорхойлдог улс орнуудын хувьд тодорхой хатуу нэг өдөр бус, тодорхой хугацааны хүрээнд эхлэх зохицуулалт үйлчилдэг. Шинэ Зеланд Улсад тухайн жилийн анхны хуралдаан 2 дугаар сарын сүүлчийн Мягмар гарагаас хэтрэхгүй хугацаанд эхлэх ёстой гэж заасан бөгөөд яг аль өдөр эхлэхийг Үйл ажиллагааны хорооны

⁴² Эстони: (2003). “Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль”. Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/521032019014/consolide>

⁴³ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁴⁴ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/law/view.do?hseq=55306&lang=ENG

⁴⁵ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

⁴⁶ Сингапур: (2017). “Парламентын дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.parliament.gov.sg/docs/default-source/default-document-library/standing-orders-of-the-parliament-of-singapore.pdf>

⁴⁷ Австрали: (2025) “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах: https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

⁴⁸ Өмнөд Африк: (2016). “Үндэсний Ассамблейн тухай хууль”, Хандах: https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf.

боловсруулсан жилийн хөтөлбөрөөр тодорхойлдог.⁴⁹ Канад Улсад Төлөөлөгчдийн танхимын дарга дараа жилийн хуралдааны хуанлийг жил бүрийн 9 дүгээр сарын 30-ны дотор парламентад өргөн барих үүрэгтэй бөгөөд үүгээр дамжуулан хуралдааны эхлэх, үргэлжлэх хугацааг урьдчилан тогтоодог боловч хуульд нэг тогтмол эхлэх огноо заадаггүй.⁵⁰ Улс орнуудын зохицуулалтыг харьцуулан үзэхэд зарим улс (Эстони, Франц, Өмнөд Солонгос) чуулганы эхлэх хугацааг тодорхой огноо, гарагтайгаар шууд хуульчилсан бол нөгөө хэсэг (Япон, Сингапур, Австрали, Өмнөд Африк) нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухай бүр тогтоодог, харин гурав дахь бүлэг (Шинэ Зеланд, Канад) нь тодорхой хугацааны хүрээнд төлөвлөлт хийх хэлбэрээр зохицуулдаг ялгаатай тогтолцоотой байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>21 дүгээр зүйл.Чуулганы хуралдааны нийтлэг журам</p> <p>21.20.Нам, эвслийн бүлгээс хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах шаардлагатай гэсэн санал гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд мэтгэлцээн явуулна.</p>	<p>21 дүгээр зүйл.Чуулганы хуралдааны нийтлэг журам</p> <p>21.20.Нам, эвслийн бүлгээс хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах шаардлагатай гэсэн санал гаргасан бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд мэтгэлцээн явуулна. Мэтгэлцээн явуулах журмыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тогтооно.</p>
<p>21.21.Энэ хуулийн 21.20-д заасан тохиолдолд болон бусад үед мэтгэлцээн явуулах журмыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр тогтооно.</p>	<p>21.21.Байнгын хороогоор хуулийн төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулах үед шаардлагатай гэж үзвэл хуралдааныг мэтгэлцээний горимд шилжүүлнэ.</p>
<p>21.23.Хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан нам, эвслийн бүлгүүдэд болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилах бөгөөд холбогдох журмыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга батална.</p>	<p>21.23.Хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд асуулт асуух нийт хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр тогтоохтой холбогдох журмыг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга батална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентын дэгийн зохицуулалтыг авч үзэхэд, хуулийн төслийг байнгын хороогоор хэлэлцэх явцад “мэтгэлцээний горимд шилжүүлэх” гэсэн нэр томъёо хэрэглэгддэггүй боловч агуулгын хувьд түүнтэй төстэй зохицуулалт хэд хэдэн парламентын тогтолцоонд байна. Эдгээр зохицуулалт нь хуулийн төслийг зөвхөн зүйл, заалт бүрээр техникийн байдлаар хэлэлцэхээс өмнө эсхүл эцсийн санал, дүгнэлт гаргахын өмнө төслийн ерөнхий үзэл баримтлал, бодлогын агуулга, хэрэгцээ шаардлага, зохицуулалтын үр нөлөөг гишүүдийн оролцоотойгоор нээлттэй хэлэлцэх боломжийг бүрдүүлэх агуулга бүхий байна. Тухайлбал, Герман Улсын Бундестагийн дэгийн зохицуулалтад байнгын хороонд шилжүүлсэн асуудлын эцсийн хэлэлцүүлгийн үед “өргөтгөсөн нээлттэй хорооны хэлэлцүүлэг” явуулах боломжийг тусгасан байна. Энэ хэлэлцүүлгийн хүрээнд байнгын хороо тухайн асуудлаар санал, дүгнэлт болон тайлангаа батлах бөгөөд Бундестагийн бүх гишүүн үг хэлэх, агуулгын шинжтэй санал гаргах эрхтэй байдаг.⁵¹ Бундестагийн дэгийн 106 дугаар зүйлийн хүрээнд “Нийтийн анхаарал татсан, цаг үеийн шинжтэй тодорхой сэдвээр таван минутаас хэтрэхгүй хугацаатай үг хэлэх хэлбэрээр өрнөх мэтгэлцээн /цаашид “цаг үеийн асуудлаарх мэтгэлцээн (debate on matters of topical interest)”

⁴⁹ Шинэ Зеланд: (2023). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах:

<https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

⁵⁰ Канад: (2025). “Төлөөлөгчдийн танхимын байнгын дэгийн журам”. Хандах:

<https://www.ourcommons.ca/About/StandingOrders/Appa.aspx>

⁵¹ Герман: (2022). “Германы Бундестагийн дэгийн журам”. Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>

гэх/-ийг, энэхүү Дэгийн журамд өөрөөр заагаагүй бол удирдамжаар зохицуулна /Хавсралт 5/” хэмээн заасан.

Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хуульд байнгын хороо хуулийн төслийг хэлэлцэхдээ эхлээд “ерөнхий хэлэлцүүлэг” явуулах ёстой гэж заасан. Энэхүү ерөнхий хэлэлцүүлэг нь хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж, түүний зохистой эсэх, бодлогын агуулга, хэрэгцээ шаардлагын талаар асуулт, хариулт, санал хэлэлцүүлэг өрнүүлэх мэтгэлцээний хэлбэртэй байна. Ерөнхий хэлэлцүүлгийг дуусгасны дараа байнгын хороо зүйл, заалт бүрээр хэлэлцэх шатанд шилжинэ.⁵² Тухайлбал, Үндэсний Ассамблейн тухай хуулийн 106-2 дугаар хэсэгт Филибастер хэрэгжүүлэх буюу хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхийг удаашруулах зорилгоор гишүүд хугацааны хязгааргүйгээр мэтгэлцэх парламентын процедурыг хуульчилсан байна. Энэ зохицуулалтыг хүрээнд Үндэсний Ассамблейн гишүүдийн 1/3-аас доошгүй нь гарын үсэг зурсан хүсэлтийг Парламентын даргад хүргүүлнэ. Энэ тохиолдолд Парламентын дарга тухайн хэлэлцэх асуудлаар филибастер хэрэгжүүлнэ.

Эстони Улсад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үеэр төслийн ерөнхий зарчмуудыг хэлэлцэх бөгөөд энэ үед намын бүлгүүдийн төлөөлөгчдөд байр сууриа илэрхийлэх, санал хэлэх, мэтгэлцээнд оролцох боломжийг олгодог. Швейцар Улсад хуулийн төслийн эхний шатанд “удиртгал мэтгэлцээн” явуулдаг.⁵³ Энэхүү мэтгэлцээний хүрээнд тухайн хуулийн төслийг цаашид хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
-	21.32.Хуралдаан даргалагч энэ хуулийн 21.31-д заасан парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий этгээдэд албан бичиг илгээнэ. Томилох эрх бүхий этгээд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуралдаан даргалагчид ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснийг хуралдаанд хуралдаан даргалагч уншиж танилцуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентын практикт гишүүн дэг, журам зөрчих эсхүл парламентыг үл хүндэтгэх үйлдэл гаргавал хуралдаан даргалагч тухайн зөрчлийг баримтжуулж, эрх бүхий хороо, албан тушаалтанд мэдээлдэг тогтолцоо байна. Тухайлбал, Австрали болон Шинэ Зеландын парламентад хуралдаан даргалагч дэг журам зөрчсөн гишүүний нэрийг зааж (naming), танхимаас гаргах эсвэл түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэх бөгөөд хэрэв уг асуудлыг тусгай хороонд шилжүүлэх зохицуулалттай бол Хуралдаан даргалагч үр дүнг дараагийн хуралдаанд танхимд тайлагнах үүрэг хүлээдэг байна.⁵⁴ Өмнөд Солонгосын хувьд Байнгын хорооны дарга сахилгын шийтгэл хүлээвэл зохих гишүүний талаар Хуралдаан даргалагч мэдээлэх бөгөөд Хуралдаан даргалагч уг асуудлыг Ёс зүйн тусгай хороонд шилжүүлэн, улмаар гаргасан дүгнэлт, шийдвэрийг нэгдсэн хуралдаанд тайлагнадаг журамтай байна.⁵⁵ АНУ-ын хувьд Төлөөлөгчдийн танхимын Зэвсэгт хүчний түрүүч (Sergeant-at-Arms) дүрэм зөрчсөн гишүүнд торгууль ногдуулах эрхтэй бөгөөд энэ тухайгаа Хуралдаан даргалагч болон Ёс зүйн хороонд мэдэгддэг бол Ёс зүйн хороо нь шалгалтын үр дүн, гаргасан дүгнэлтээ Танхимд албан ёсоор танилцуулдаг⁵⁶ байна.

⁵² Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах:

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁵³ Эстони: Riigikogu. Хандах <https://www.riigikogu.ee/en/contacts/>.

⁵⁴ Австрали: (2025) “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. §36. Хандах:

https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

⁵⁵ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах:

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁵⁶ АНУ: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах:

<https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

Өмнөд Африк Улсад танхимын дүрэм, журмыг санаатайгаар биелүүлэхгүй байх нь парламентыг үл хүндэтгэсэн хэрэг болно. Ийм нөхцөл байдал үүсэж, гишүүн танхимын дэг журмыг зөрчвөл хуралдаан даргалагч түүнийг танхимаас гарахыг тушаах бөгөөд хэрэв тушаалыг биелүүлэхгүй бол хамгаалалтын албаны тусламжтайгаар албадан гаргадаг. Ийм нөхцөл үүссэн тохиолдолд Хуралдаан даргалагч 24 цагийн дотор холбогдох дэд хороонд шилжүүлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх шийдвэрийг хоёр ажлын өдрийн дотор зарлах ёстой байна.⁵⁷ Түүнчлэн, Япон Улсад Сахилгын хорооноос гаргасан сахилгын арга хэмжээний шийдвэрийг Хуралдаан даргалагч нээлттэй хуралдаан дээр зарлах ёстой байдаг.⁵⁸ Харин Шинэ Зеландын парламентын дэгийн дагуу "Парламентыг үл хүндэтгэх" (Contempt of House) гэж гэдэгт Парламентын танхимыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах, хойшлуулах, эсхүл гишүүн болон албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхэд нь боогдуулах, шууд болон шууд бусаар ийм үр дагаварт хүргэх аливаа үйлдэл, эс үйлдэхүйг үл хүндэтгэсэн үйлдэл гэж үздэг.⁵⁹ Үл хүндэтгэх үйлдэлд парламентын танхим эсхүл хороог мэдүүлэг, нотлох баримт, өргөдлийн хэлбэрээр зориудаар төөрөгдүүлэхийг оролдох үйлдлүүд багтдаг. Мөн гишүүн өөрийн эд хөрөнгийн болон мөнгөн ашиг сонирхлын талаарх мэдүүлгээ зориудаар хугацаанд нь өгөхгүй байх, эсхүл худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх нь мөн үл хүндэтгэлд тооцогддог байна. Түүнчлэн гишүүнд нөлөөлөхийн тулд хээл хахууль авах, өгөх, эсхүл санал болгох, мөн албан үүргээ гүйцэтгэж буй гишүүн, ажилтан руу халдах, заналхийлэх, айлган сүрдүүлэх зэрэг үйлдлүүд үүнд хамаарна. Парламентын гишүүн нь Танхимын аливаа журам, захирамж, шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байх, эсхүл биелүүлэхээс татгалзсан тохиолдолд 2004 оны Парламентын эрх хэмжээ, давуу байдлын тухай (Powers and Privileges Act) хуульд заасны дагуу парламентыг үл хүндэтгэсэнд тооцогдож болно.⁶⁰

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
22 дугаар зүйл. Байнгын хороо 22.3. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	22 дугаар зүйл. Байнгын хороо 22.3. Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
22.3.6. шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 22.3.4, 22.3.5-д заасан хянан шалгах ажлын мөрөөр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой санал боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;	22.3.6. энэ хуулийн 22.3.4, 22.3.5-д заасан хянан шалгах ажлын мөрөөр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, биелэлтийг хангуулах болон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах;
22.3.9. хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар хууль зүйн зөвлөмж гаргуулах; <i>/Энэ заалтад 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</i>	22.3.9. хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төслийн талаар Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт, зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Тамгын газраар хийлгэх;
22.3.10. иргэд, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судалж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах;	
22.4. Энэ хуулийн 22.3.9-д заасан зөвлөмжийг холбогдох Байнгын хорооны	22.4. Энэ хуулийн 22.3.9-д заасан дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

⁵⁷ Өмнөд Африк: (2016). "Үндэсний Ассамблейн дүрэм", Хандах:

https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf.

⁵⁸ Япон: (1947). "Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль". Хандах:

<https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

⁵⁹ Шинэ Зеланд: (2023). "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах:

<https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

⁶⁰ Шинэ Зеланд: (2023). "Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай" хууль. Хандах:

<https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

<p>хуралдаанд танилцуулна. Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн зөвлөмжийг Байнгын хорооныхоо санал, дүгнэлтэд тусгаж нэгдсэн хуралдаанд оруулна. /Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</p>	<p>Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн дүгнэлтийг Байнгын хорооныхоо санал, дүгнэлтэд тусгаж нэгдсэн хуралдаанд оруулна.</p>
<p>22.6.Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна: 22.6.1./Энэ заалтыг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./ 22.6.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 22.6.3.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн; 22.6.8.Төрийн байгуулалтын; 22.6.9.Төсвийн; 22.6.10.Хууль зүйн; 22.6.11.Эдийн засгийн. 22.6.12.Өргөдлийн; /Энэ заалтыг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/ 22.6.13.Хүний хөгжил, нийгмийн бодлогын.</p>	<p>22.6.Улсын Их Хурал дараах Байнгын хороотой байна: 22.6.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын; 22.6.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн; 22.6.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын; 22.6.4.Өргөдлийн; 22.6.5.Төрийн байгуулалтын; 22.6.6.Төсвийн; 22.6.7.Хууль зүй, хүний эрхийн; 22.6.8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн; 22.6.9.Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын; 22.6.10.Эдийн засгийн; 22.6.11.Эрүүл мэнд, нийгмийн бодлого.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Швед Улсын Парламент (Риксдаг) нь 349 гишүүнтэй бөгөөд 15 хороо (committee), Европын Холбооны асуудал эрхэлсэн нэг хороотой. Хороо тус бүр намуудыг төлөөлсөн 17 гишүүнтэй ажилладаг. Үндсэн чиг үүрэг нь Риксдагийн шийдвэрийн төслийг боловсруулах; гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах; Европын Холбооны баримт бичигт тайлбар, санал боловсруулах; Риксдагийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих; судалгаа мэдээлэл гаргах; хорооны хуралдаан, өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах байна.⁶¹

Эстони Улсын Парламент (Рийгикогу) нь 101 гишүүнтэй, 11 байнгын хороотой (standing committee). Шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулах хороо, мөрдөн шалгах хороо, судалгааны хороо байгуулж болно. Рийгикогугийн нэг гишүүн зөвхөн нэг байнгын хороонд харьяалагдана. Үндсэн чиг үүрэг нь хууль, тогтоолын төсөл боловсруулах; төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх; байнгын хорооны гишүүдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байна. Рийгикогугийн байнгын хороод нь ажлын албатай (secretariats of committees) бөгөөд орон тоог байнгын хороодын ажлын ачааллаас хамааран тогтоодог бөгөөд 2021 онд дараах байдлаар баталсан байна⁶². Үүнд:

- Европын Холбооны асуудал эрхэлсэн байнгын хороо - 6;
- Байгаль орчны байнгын хороо - 3;
- Соёлын байнгын хороо - 5;
- Хөдөө аж ахуйн байнгын хороо - 3;
- Эдийн засгийн байнгын хороо -5;
- Үндсэн хуулийн байнгын хороо -5;
- Сангийн байнгын хороо -5;
- Үндэсний аюулгүй байдлын байнгын хороо - 3;
- Нийгмийн бодлогын байнгын хороо - 6;
- Гадаад харилцааны байнгын хороо - 3;
- Хууль зүйн байнгын хороо - 5;
- Аюулгүй байдлын албаны хяналтын тусгай хороо - 2;
- Авлигын эсрэг тусгай хороо - 2;

⁶¹ ПСХХ. (2025). Парламентын Байнгын хорооны ажлын албаны бүтэц, орон тоо, чиг үүргийн талаарх мэдээлэл. (СТ-25/433).

⁶² Эстони: Riigikogu. Хандах <https://www.riigikogu.ee/en/contacts/>.

- Төсвийн хяналтын тусгай хороо - 2⁶³.

Норвег Улсын Парламент (Стортинг) нь 169 гишүүнтэй, 12 байнгын хороотой (permanent committee)⁶⁴. Нэг байнгын хороо 8-18 гишүүнтэй. Хорооны үйл ажиллагаанд ажлын алба (secretariat) дэмжлэг үзүүлдэг. Үндсэн чиг үүрэг нь байнгын хорооны хуралдаан, сонсгол, уулзалт зохион байгуулах; хэвлэл мэдээлэл, иргэд олон нийттэй харилцах; байнгын хорооны үйл ажиллагаанд хараат бус мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байна.⁶⁵

Хууль тогтоох бүрэн эрхийн хугацаа бүрд Бундестагийн байнгын хороод шинээр байгуулагдаж, нэршил болон бүрэлдэхүүн нь өөрчлөгддөг. Ихэнх байнгын хороод нь Засгийн газрын бүтэц, чиг үүрэгтэй уялдан байгуулагддаг. Өөрөөр хэлбэл, Холбооны яам бүрт харгалзах парламентын хороо байдаг. Гэхдээ парламент тодорхой бодлогын чиглэлийг онцлох зорилгоор нэмэлт хороод байгуулж болно. 2026 оны эхэн үеийн байдлаар Герман Улсын Бундестаг нь байнгын (тогтмол) хороодоос гадна төрөлжсөн дэд хороо, судалгааны комисс, мөрдөн шалгах хороодын тогтолцоогоор үйл ажиллагаа явуулж байна. Герман Улсын байнгын хорооны бүтцийн хувьд.⁶⁶

- Хөдөө аж ахуй, хүнс, бүс нутгийн онцлогийн хороо (Agriculture, Food and Regional Identity);
- Төсвийн хороо (Budget);
- Соёл, хэвлэл мэдээллийн асуудал эрхэлсэн хороо (Cultural and Media Affairs);
- Батлан хамгаалахын хороо (Defence);
- Дижитал шилжилт ба төрийн шинэчлэлийн хороо (Digital Transformation and Government Modernisation);
- Эдийн засаг, эрчим хүчний хороо (Economic Affairs and Energy);
- Боловсрол, гэр бүл, ахмад настан, эмэгтэйчүүд, залуучуудын хороо (Education, Family Affairs, Senior Citizens, Women and Youth);
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн хороо (Economic Cooperation and Development);
- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, байгаль хамгаалал, цөмийн аюулгүй байдлын хороо (Environment, Climate Action, Nature Conservation and Nuclear Safety);
- Европын Холбооны асуудал эрхэлсэн хороо (European Union Affairs);
- Санхүүгийн хороо (Finance);
- Гадаад харилцааны хороо (Foreign Affairs);
- Эрүүл мэндийн хороо (Health);
- Орон сууц, хот байгуулалт, барилга, орон нутгийн засаглалын хороо (Housing, Urban Development, Building and Local Government);
- Хүний эрх, хүмүүнлэгийн тусламжийн хороо (Human Rights and Humanitarian Aid);
- Дотоод хэргийн хороо (Internal Affairs);
- Хамтарсан хороо (Joint Committee);
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хороо (Labour and Social Affairs);
- Хууль зүй, хэрэглэгчийн эрх хамгааллын хороо (Legal Affairs and Consumer Protection);
- Зуучлалын хороо (Mediation Committee);
- Өргөдлийн хороо (Petitions);
- Судалгаа, технологи, сансар судлал, технологийн үнэлгээний хороо (Research, Technology, Space and Technology Assessment);
- Сонгуулийн шалгалтын хороо (Scrutiny of Elections);
- Сонгуулийн шалгалт, гишүүдийн халдашгүй байдал, дэгийн асуудал эрхэлсэн хороо (Scrutiny of Elections, Immunity and the Rules of Procedure);

⁶³ Эстони: Riigikogu. Хандах https://www.riigikogu.ee/wpcms/wp-content/uploads/2021/03/Struktur-ja-koosseis-1.-m%C3%A4rtsi-2021_terviktekst.pdf.

⁶⁴ Норвег: (2024). "Стортингийн дэгийн тухай хууль" Хандах:

https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

⁶⁵ СТ-25/433 Парламентын Байнгын хорооны ажлын албаны бүтэц, орон тоо, чиг үүргийн талаарх лавлагаа мэдээлэл.

⁶⁶ Герман: (n.d.). Хороод (Committees). Хандах: <https://www.bundestag.de/en/committees>

- Спорт, сайн дурын үйл ажиллагааны хороо (Sports and Volunteering);
- Аялал жуулчлалын хороо (Tourism);
- Тээврийн хороо (Transport);
- Бусад байгууллагууд (Further bodies);
 - Тогтвортой хөгжлийн асуудлаарх парламентын зөвлөх зөвлөл (Parliamentary Advisory Council on Sustainable Development);
 - Шалган судлах үйл ажиллагаа (Inquiry);
 - Хяналт шалгалт (Scrutiny);
 - Судалгаа (Study).

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23 дугаар зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ</p> <p>23.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.2.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;</p> <p>23.2.2.Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;</p> <p>23.2.3.улсын хил хамгаалалтын бодлого;</p> <p>23.2.4.төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;</p> <p>23.2.5.гадаад бодлого;</p> <p>23.2.6.гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудал;</p> <p>23.2.7.Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал;</p> <p>23.2.8.цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого.</p>	<p>23 дугаар зүйл.Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ</p> <p>23.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.1.1.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;</p> <p>23.1.2.Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;</p> <p>23.1.3.улсын хил хамгаалалтын бодлого, хэрэгжилт;</p> <p>23.1.4.төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;</p> <p>23.1.5.гадаад бодлого;</p> <p>23.1.6.гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудал;</p> <p>23.1.7.Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал;</p> <p>23.1.8.цөмийн энерги ашиглах, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах бодлого;</p> <p>23.1.9.хилийн боомт, чөлөөт бүс байгуулах асуудал.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентын дэгийн зохицуулалтаас үзэхэд, байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээ, хариуцах салбар, чиг үүргийг парламентын дэгийн журам, дотоод зохион байгуулалтын дүрэм, эсхүл холбогдох хууль тогтоомжид нарийвчлан тусгасан нийтлэг хандлагатай байна. Тухайлбал, АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын байнгын хороодын хууль тогтоох харьяалал болон хяналт шалгалтын чиг үүргийг тусгасан. Хороо тус бүр ямар салбар, ямар төрлийн бодлогын асуудал, ямар агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавихыг тодорхой заадаг. Жишээлбэл, Хөдөө аж ахуйн хороо нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, химийн бодис, хүнсний бодлого, хөдөөгийн цахилгаанжуулалт зэрэг өргөн хүрээний асуудлыг хариуцдаг бол Зэвсэгт хүчний хороо нь батлан хамгаалах бодлого, цэргийн байгууллагын бүтэц, зэвсэглэл, үндэсний аюулгүй байдлын холбогдох асуудлыг эрхэлдэг байна.⁶⁷ Япон Улсын Зөвлөхүүдийн танхимд байнгын хороодын бүтэц, гишүүдийн тоо, хариуцах яам, агентлаг болон бодлогын чиглэлийг нэг бүрчлэн тогтоосон байдаг. Тухайлбал, Засгийн газрын хороо нь Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагын асуудлыг хариуцдаг бол Хууль зүйн хороо нь Хууль зүйн яам, шүүхийн захиргаа болон хууль зүйн бодлогын асуудлыг

⁶⁷ АНУ: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах: <https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

хариуцдаг.⁶⁸ Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хуульд 17 байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг тодорхойлсон байна. Тухайлбал, танхимын зохион байгуулалтын хороо, Хууль зүйн хороо, Үндэсний бодлогын хороо зэрэг хороод нь тодорхой яам, агентлаг, төрийн байгууллагын үйл ажиллагаа, бодлогын асуудлыг хариуцан хэлэлцэхээр зохицуулагдсан байна. Тухайлбал, хуулийн 37 дугаар зүйлд байнгын хороодын эрхлэх асуудлыг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд.⁶⁹

1. Танхимын үйл ажиллагааны хороо:

- (a) Үндэсний Ассамблейн үйл ажиллагаатай холбоотой асуудал;
- (b) Үндэсний Ассамблейн тухай хууль болон Үндэсний Ассамблейн журамтай холбоотой асуудал;
- (c) Үндэсний Ассамблейн Тамгын газрын эрхлэх асуудал;
- (d) Үндэсний Ассамблейн Номын сангийн эрхлэх асуудал;
- (e) Үндэсний Ассамблейн Төсвийн албаны эрхлэх асуудал;
- (f) Үндэсний Ассамблейн Судалгааны албаны эрхлэх асуудал;
- (g) Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын газар болон Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны эрхлэх асуудал;
- (h) Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүний эрхийн үндэсний комиссын эрхлэх асуудал.

2. Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн хороо:

- (a) Хууль зүйн яамны эрхлэх асуудал;
- (b) Засгийн газрын хууль тогтоомжийн яамны эрхлэх асуудал;
- (c) Аудит, хяналтын зөвлөлийн эрхлэх асуудал;
- (d) Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах газрын эрхлэх асуудалд хамаарах асуудал;
- (e) Үндсэн хуулийн шүүхийн захиргааны үйл ажиллагаатай холбоотой асуудал;
- (f) Шүүх болон цэргийн шүүхийн захиргаатай холбоотой асуудал;
- (g) Сангийн удирдлагатай холбоотой асуудал;
- (h) Үндэсний Ассамблейн хууль буюу журмын төсөл тус бүрийн бүтэц, хэлбэр, найруулгыг хянан шалгах асуудал.

3. Үндэсний бодлогын хороо:

- (a) Засгийн газрын бодлого зохицуулалтын газар болон Ерөнхий сайдын Тамгын газрын эрхлэх асуудал;
- (b) Эх орончид болон ахмад дайчдын асуудал эрхэлсэн яамны эрхлэх асуудал;
- (c) Шударга өрсөлдөөний комиссын эрхлэх асуудал;
- (d) Санхүүгийн үйлчилгээний комиссын эрхлэх асуудал;
- (e) Авлигын эсрэг болон иргэний эрхийн комиссын эрхлэх асуудал.

4. Эдийн засаг, санхүүгийн хороо:

- (a) Эдийн засаг, сангийн яамны эрхлэх асуудал;
- (b) Солонгосын банкны эрхлэх асуудал.

5. Боловсролын хороо:

Боловсролын яамны эрхлэх асуудал.

6. Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны хороо:

- (a) Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яамны эрхлэх асуудал;
- (b) Солонгосын харилцаа холбооны комиссын эрхлэх асуудал;
- (c) Цөмийн аюулгүй байдал, хамгаалалтын комиссын эрхлэх асуудал.

⁶⁸ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

⁶⁹ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

7. Гадаад харилцаа, нэгдлийн хороо:
- (a) Гадаад хэргийн яамны эрхлэх асуудал;
 - (b) Солонгосын нэгдэх (Өмнөд–Хойд Солонгосын) бодлогын яамны эрхлэх асуудал;
 - (c) Үндэсний нэгдлийн зөвлөх зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал.
8. Үндэсний батлан хамгаалах хороо:
- Үндэсний батлан хамгаалах яамны эрхлэх асуудал.
9. Төрийн захиргаа, аюулгүй байдлын хороо:
- (a) Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны эрхлэх асуудал;
 - (b) Төрийн албаны удирдлагын эрхлэх асуудал;
 - (c) Үндэсний сонгуулийн комиссын эрхлэх асуудал;
 - (d) Орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаатай холбоотой асуудал.
10. Соёл, спорт, аялал жуулчлалын хороо:
- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны эрхлэх асуудал.
11. Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн асуудал, далай, загас агнуурын хороо:
- (a) Хөдөө аж ахуй, хүнс, хөдөөгийн асуудал;
 - (b) Далай, загас агнуурын асуудал.
12. Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүч, жижиг, дунд үйлдвэр болон гарааны бизнесийн хороо:
- (a) Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны эрхлэх асуудал;
 - (b) Жижиг, дунд үйлдвэр болон гарааны бизнесийн яамны эрхлэх асуудал.
13. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хороо:
- (a) Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудал;
 - (b) Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны эрхлэх асуудал.
14. Байгаль орчин, хөдөлмөрийн хороо:
- (a) Байгаль орчны яамны эрхлэх асуудал;
 - (b) Хөдөлмөр, хөдөлмөр эрхлэлтийн яамны эрхлэх асуудал.
15. Газар, дэд бүтэц, тээврийн хороо:
- Газар, дэд бүтэц, тээврийн яамны эрхлэх асуудал.
16. Тагнуулын хороо:
- (a) Үндэсний тагнуулын албаны эрхлэх асуудал;
 - (b) Тагнуул болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг төлөвлөх, зохицуулах үүрэг бүхий яам, агентлагийн эрхлэх хүрээнд хамаарах тагнуулын албаны төсвийн төсөл болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хянан хэлэлцэх асуудал хамаарна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.3.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.3.1.газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;</p> <p>23.3.2.хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;</p> <p>23.3.3.хөдөөгийн хөгжлийн бодлого;</p> <p>23.3.4.мал аж ахуйн бодлого;</p> <p>23.3.5.малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах;</p> <p>23.3.6.газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;</p> <p>23.3.7.улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;</p> <p>23.3.8.геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;</p> <p>23.3.9.агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;</p> <p>23.3.10.цаг уур, орчны хяналтын асуудал;</p> <p>23.3.11.усны бодлого, нөөц, усны бохирдол;</p> <p>23.3.12.хог хаягдал, дахин боловсруулалт;</p> <p>23.3.13.байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал;</p> <p>23.3.14.байгаль орчны судалгаа, хөгжил;</p> <p>23.3.15.ан агнуур;</p> <p>23.3.16.газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт;</p> <p>23.3.17.газрын кадастр, зураглал.</p>	<p>23.2.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.2.1.газрын хэвлийн баялгаас бусад байгалийн баялаг;</p> <p>23.2.2.улсын тусгай хамгаалалттай газар;</p> <p>23.2.3.геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;</p> <p>23.2.4.агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;</p> <p>23.2.5.цаг уур, орчны хяналтын асуудал;</p> <p>23.2.6.гүний болон гадаргын усны бодлого, нөөц, усны бохирдол;</p> <p>23.2.7.хог хаягдал, дахин боловсруулалт;</p> <p>23.2.8.байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал;</p> <p>23.2.9.байгаль орчны судалгаа, хөгжил;</p> <p>23.2.10.ан агнуур</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Швейцар Улсын Байгаль орчин, нутаг дэвсгэрийн төлөвлөлт, эрчим хүчний хороо (ESPEC) дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁰

- тогтвортой хөгжлийн бодлого, байгаль орчин болон хүн амын хэрэгцээний тэнцвэр;
- байгаль орчин, хүн амыг хор хөнөөлөөс хамгаалах эрх зүйн зохицуулалт;
- орон зайн төлөвлөлт, газрын зохистой ашиглалт, суурьшлын бүсийн зохицуулалт;
- газрын судалгаа, кадастр, зураглал;
- усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, далангийн аюулгүй байдал;
- ой мод, биологийн олон янз байдлын хамгаалалт;
- амьтан, ургамал, тэдгээрийн амьдрах орчны хамгаалалт;
- ан агнуур, загас агнуурын бодлогын зохицуулалт;
- эрчим хүчний бодлого, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих;
- цөмийн эрчим хүчний эрх зүйн зохицуулалт.

АНУ (Төлөөлөгчдийн танхим)-ын Байгалийн нөөцийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷¹

- байгалийн нөөц, ой мод, үндэсний парк, нийтийн эзэмшлийн газрын бодлого;
- зэрлэг ан амьтан, загас агнуур, тэдгээрийн хамгаалалт;

⁷⁰ Швейцар: (2025) Байгаль орчин, нутаг дэвсгэрийн төлөвлөлт, эрчим хүчний хороо (Environment, Spatial Planning and Energy Committees (ESPEC). Хандах:

<https://www.parlament.ch/en/organe/committees/specialist-committees/committees-espec>

⁷¹ АНУ: (2025). "Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам". Хандах:

<https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

- геологийн судалгаа;
- усны нөөц, усжуулалт, газар нөхөн сэргээлт;
- ашигт малтмал, уул уурхайн нөөцийн ашиглалт;
- далай, эргийн бүсийн менежмент.

Мөн АНУ-ын Эрчим хүч, худалдааны хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- эрчим хүчний нөөцийн олборлолт, хадгалалт, нийлүүлэлт, зохицуулалт;
- эрчим хүчний хэмнэлт, хамгаалалт;
- байгаль орчны судалгаа, технологийн хөгжил.

Норвег Улсын Эрчим хүч, байгаль орчны байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷²

- эрчим хүчний бодлого, түүний дотор газрын тос, эрчим хүчний нөөц;
- усны нөөц, усны урсгалын зохицуулалт;
- байгаль орчны хамгааллын бодлого.

Шинэ Зеланд Улсын Байгаль орчны хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷³

- байгаль орчны хамгаалалт;
- байгаль орчны бодлого, зохицуулалт;
- уур амьсгалын өөрчлөлтийн асуудал;
- байгаль орчны аудит, тайлангийн хяналт.

Энэтхэг Улсын Шинжлэх ухаан, технологи, байгаль орчин, ой, уур амьсгалын өөрчлөлтийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁴

- байгаль орчин, ой модны талаарх бодлого;
- уур амьсгалын өөрчлөлтийн талаарх зохицуулалт;
- дэлхий судлал, шинжлэх ухааны холбогдох асуудал;
- атомын энергийн бодлого.

Франц Улсын Тогтвортой хөгжил, орон зайн төлөвлөлтийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁵

- орон зайн төлөвлөлт;
- тээвэр, дэд бүтэц, нийтийн ажил;
- байгаль орчны бодлого;
- ан агнуурын зохицуулалт.

Австрали Улсын Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүч, байгаль орчин, усны асуудал эрхэлсэн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁶

- уур амьсгалын өөрчлөлтийн бодлого;
- эрчим хүчний бодлого;ы
- байгаль орчны хамгаалалт;
- усны нөөцийн удирдлага.

Өмнөд Солонгос Улсын хувьд Байгаль орчин, хөдөлмөрийн хороо нь байгаль орчны бодлого, байгаль орчны яамны харьяа асуудлыг асуудлыг эрхэлнэ.⁷⁷

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
23.13.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: 23.13.1.боловсрол; 23.13.2.жөндөрийн тэгш байдлыг хангах бодлого;	23.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: 23.3.1.боловсрол; 23.3.2.биеийн тамир, спорт;

⁷² Норвег: (2024). “Стортингийн дэгийн тухай хууль” Хандах:

https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

⁷³ Шинэ Зеланд: “Байгаль орчны хороо (Environment Committee). Хандах:

<https://www3.parliament.nz/en/pb/sc/scl/environment/>

⁷⁴ Энэтхэг: (2024). “Лок Сабха дахь дэгийн журам болон үйл ажиллагаа явуулах дүрэм”. Хандах:

https://sansad.in/uploads/Rules_of_Procedures_E_9d8fd0f4c3.pdf?updated_at=2022-

⁷⁵ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁷⁶ Австрали: (2025) “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах: https://www.aph.gov.au/-/media/05_About_Parliament/53_HoR/532_PPP/Standing_Orders/SOs_as_at_23_July_2025.pdf

⁷⁷ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах:

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

<p>23.13.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил; 23.13.4.мэргэжлийн боловсрол, сургалт; 23.13.5.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого; 23.13.6.нийтийн биеийн тамир, спорт; 23.13.7.соёл, урлаг; 23.13.8.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого; 23.13.9.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа; 23.13.10.хүн амын хөгжлийн бодлого; 23.13.11.шинжлэх ухаан; 23.13.12.эрүүл мэндийн бодлого. <i>/Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/</i></p>	<p>23.3.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил; 23.3.4.мэргэжлийн боловсрол, сургалт; 23.3.5.соёл, урлаг; 23.3.6.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого; 23.3.7.шинжлэх ухаан, технологи, инновацын үндэсний бодлого; 23.3.8.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого.</p>
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Франц Улсын Соёлын асуудал, боловсролын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁸

- сургуулийн болон дээд боловсролын бодлого, зохицуулалт;
- судалгаа шинжилгээ, шинжлэх ухааны үйл ажиллагаа;
- залуучуудын бодлого, спортын салбар;
- соёл, урлагийн үйл ажиллагаа;
- харилцаа холбоо болон оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт.

Шинэ Зеланд Улсын Боловсрол, ажиллах хүчний хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁷⁹

- боловсрол, сургалт, мэргэжлийн бэлтгэлийн бодлого;
- хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, цагаачлалын бодлого.

Харин Нийгмийн үйлчилгээ, олон нийтийн хороо нь соёл, урлаг, өв соёлын бодлого; спорт, амралт, чөлөөт цагийн үйл ажиллагааг эрхэлнэ. Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, инновацын хороо шинжлэх ухаан, судалгаа, инновацын бодлого; оюуны өмчийн зохицуулалт; харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудлыг эрхэлнэ.

Өмнөд Солонгос Улсын Боловсролын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁸⁰

- боловсролын бодлого, боловсролын яамны харьяа үйл ажиллагаа.

Соёл, спорт, аялал жуулчлалын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- соёл, спорт, аялал жуулчлалын бодлого.

Харин Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн хороо шинжлэх ухаан, технологи, инновацын бодлого; мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн асуудлыг эрхэлнэ.

Япон Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁸¹

- боловсрол, соёл, спортын бодлого;
- шинжлэх ухаан, технологийн бодлого.

⁷⁸ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁷⁹ Шинэ Зеланд: (2023). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах: <https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

⁸⁰ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁸¹ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.12.Өргөдлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: /Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.12.1.иргэн, байгууллагаас Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, тэдгээрийн удирдлага, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, холбогдох Байнгын хорооны саналыг үндэслэн тухайн асуудлаар байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, сонсох, дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд санал хүргүүлэх, мэдээлэх; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.12.2.нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудал. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: /Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.1.боловсрол; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.2.жөндөрийн тэгш байдлыг хангах бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.4.мэргэжлийн боловсрол, сургалт; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.5.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.6.нийтийн биеийн тамир, спорт; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.7.соёл, урлаг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.8.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.9.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.10.хүн амын хөгжлийн бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.11.шинжлэх ухаан; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.13.12.эрүүл мэндийн бодлого. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p>	<p>23.4.Өргөдлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.4.1.иргэн, байгууллагаас Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах, бусад хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хамаарах Улсын Их Хурал, түүний Байнгын, дэд хороо, гишүүнд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл авах, түүнчлэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах бодлогын асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх саналыг нэгдсэн хуралдаанд оруулах;</p> <p>23.4.2.нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар цахим хэлбэрээр гаргасан иргэдийн өргөдлийг холбогдох Байнгын хороотой хамтран хэлэлцэх;</p> <p>23.4.3.иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах, бусад хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд хамаарах эсэхийг хянан үзэж, хамаарахгүй өргөдлийг хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр шилжүүлэх;</p> <p>23.4.4.хүний хувийн мэдээлэлд хамаарах асуудлаар иргэнээс гаргасан өргөдлийг судлан шаардлагатай бол Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Засгийн газар, холбогдох бусад байгууллагад албан бичгээр хандах;</p> <p>23.4.5.өргөдөл, гомдол хүлээн авах, бүртгэх, ангилах, гишүүнд хуваарилах, цахим систем ажиллуулах талаар дотоод зохион байгуулалтын журам батлах.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын Өргөдлийн байнгын хорооны эрхлэх асуудалд холбогдох зохицуулалтыг харвал.⁸²

Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)-ын хувьд Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн дагуу Өргөдлийн байнгын хороо (цаашид, ӨБХ гэх) нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: өргөдөл хүлээн авч, түүнийг хэлэлцэх (§220(a)); өргөдөл болон түүний системтэй холбоотой аливаа асуудлыг судлах (§220(a)); өргөдлийн талаар Төлөөлөгчдийн Танхимд тайлагнах (§220(a)); өргөдөлд Төлөөлөгчдийн Танхимын нэрийн өмнөөс албан ёсоор хариу өгөх (§208(e)) байна.

Их Британи Улс (Нийтийн Танхим)-ын хувьд Нийтийн Танхимын хуралдааны дэгийн дагуу ӨБХ нь өргөдлийг хүлээн авах, хянан үзэх, судлах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, Засгийн газар болон Парламентын түвшинд тайлагнах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд: Нийтийн Танхимд ирүүлсэн цаасан өргөдөл, мөн Парламент болон Засгийн газрын өргөдлийн цахим хуудас (petition.parliament.uk)-аар ирүүлсэн цахим өргөдлийг хүлээн авч хянан үзэх (§145A(1)); холбогдох талууд (гэрч, холбогдох албан тушаалтан, мэргэжилтэн, өргөдөл гаргагч)-ыг сонголд дуудах, бичиг баримт болон тэмдэглэл шаардах, газар дээр нь ажиллах, шаардлагатай үед тайлагнах (§145A(3); (5)); дэд хороо байгуулах (дэд хороо нь гурван гишүүнтэй бөгөөд мөн адил холбогдох талуудаас мэдээлэл гаргуулах, бичиг баримт болон тэмдэглэл шаардах, тайлангаа ӨБХ-нд танилцуулах чиг үүрэгтэй (§145A(4); (6)); өргөдлийг Вестминстерийн танхимд хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэж, шийдвэрээ Нийтийн Танхимд танилцуулах (§145A(7); 10(1)(a)) үүрэгтэй байна.

Герман Улс (Бундестаг)-ын хувьд Бундестагийн хуралдааны дэг болон “Өргөдлийн байнгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим (Процессын зарчим)”-д зааснаар ӨБХ нь өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх, холбогдох байгууллагаас мэдээлэл шаардах, өргөдөл гаргагч болон шинжээчдийг сонсох, тайлан дүгнэлт гаргаж Бундестагт танилцуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд: өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх (Дэгийн §108; Процессын зарчмын §1; 8); өргөдөлд тавигдах шаардлага хангагдаагүй, эсхүл хангалтгүй тохиолдолд хүлээн авахаас татгалзах (Процессын зарчмын §4; 7.3); өргөдлийг ӨБХ-нд шилжүүлэн авч хэлэлцэх, бусад байнгын хороодтой уялдуулах, шаардлагатай бол тэднээс санал авах (Дэгийн §109; Процессын зарчмын §6.3); мэдээлэл цуглуулах, сонголт зохион байгуулах, холбооны яам, байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас баримт бичиг, тайлбар шаардах, өргөдөл гаргагч, гэрч, шинжээчийг сонсох (Дэгийн §110; Процессын зарчмын §6.1) байна. Түүнчлэн, зарим бүрэн эрхээ нэг буюу хэд хэдэн гишүүндээ шилжүүлэх (Дэгийн §111; Процессын зарчмын §6.3); тайлан, зөвлөмж гаргах, сар бүр өргөдлийн шийдвэрийн жагсаалтыг, жил бүр үйл ажиллагааны тайланг Бундестагт танилцуулах, мөн өргөдөл гаргагчид болон олон нийтэд шийдвэрийн үр дүнг мэдэгдэх (Дэгийн §112; Процессын зарчмын §9; 11); шаардлагатай тохиолдолд өргөдлийн талаарх шийдвэрийн төслийг Бундестагт өргөн мэдүүлэх (Процессын зарчмын §6.3) эрх, үүрэгтэй байна.

Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)-ын хувьд Төлөөлөгчдийн Конгрессын хуралдааны дэгд зааснаар ӨБХ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төлөөлөгчдийн Конгресст ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч шалгах (§49.2);
- шаардлагатай гэж үзвэл Төлөөлөгчдийн Конгрессын даргаар дамжуулан өргөдлийг дараах байгууллагад шилжүүлэх шийдвэр гаргах (§49.2):
 - Ард түмний өмгөөлөгч буюу Омбудсменд (the Defender of the People);
 - тухайн асуудлыг хэлэлцэж буй Төлөөлөгчдийн Конгрессын өөр байнгын хороонд;
 - Сенат, Засгийн газар, Шүүх, Прокурорын алба, өөртөө засах нийгэмлэг, аймгийн зөвлөл, Канарын арлын зөвлөл (Cabildo), эсхүл хотын зөвлөлд;
- хэрэв дээрх байгууллагад шилжүүлэх нь зохимжгүй гэж үзвэл өргөдлийг цаашид хэлэлцэхгүйгээр хэрэгсэхгүйд тооцох (§49.3);
- өргөдөл хүлээн авсныг баталгаажуулж, гаргасан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэх (§49.4);ы

⁸² ПСХХ (2025). “Өргөдлийн байнгын хорооны эрх зүйн зохицуулалт ба үйл ажиллагааны харьцуулсан судалгаа” (СТ-25/239).

- Засгийн газар болон төрийн байгууллагаас мэдээлэл, баримт бичиг шаардах, холбогдох сайд, төрийн албан тушаалтан, шинжээчийг дуудах эрхтэй (§44).

Европын Холбоо (Европын Парламент)-ын хувьд Европын Парламентын хуралдааны дэгийн дагуу ӨБХ дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: өргөдлийг хүлээн авч, хамааралтай эсэхийг шалган тогтоох (§232-233); шаардлагатай тохиолдолд баримт цуглуулах буюу шалгалт хийх (§234); өргөдлийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээн ил тод байдлыг хангах (§235); иргэдийн өргөдөл, санаачилгыг авч хэлэлцэх (§236) хамаарна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.8.Төрийн байгуулалтын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.8.1.Монгол Улсын Үндсэн хуулийн асуудал;</p> <p>23.8.2.төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;</p> <p>23.8.3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны журам;</p> <p>23.8.4.засаг захиргааны шинэтгэл, төвлөрлийг сааруулах бодлого;</p> <p>23.8.5.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, хот, тосгоны Зөвлөл, Захирагчийн сонгууль;</p> <p>23.8.6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, хот, тосгоны эрх зүйн үндэс;23.8.7.нутгийн өөрөө удирдах ёс;</p> <p>23.8.8.төрийн алба;</p> <p>23.8.9.төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;</p> <p>23.8.10.ард нийтийн санал асуулга;</p> <p>23.8.11.төр, сүм хийдийн харилцаа;</p> <p>23.8.12.хэвлэл мэдээллийн хараат бус байдал;</p> <p>23.8.13.төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намтай харилцах;</p> <p>23.8.14.Улсын Их Хурлын тухай хууль тогтоомж, Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө;</p> <p>23.8.15.гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийн асуудал, түүний баталгаа;</p> <p>23.8.16.бүсчилсэн хөгжлийн бодлого.</p> <p>23.8.17.гишүүний ёс зүй, сахилгын асуудал;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.8.18.гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.8.19.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох асуудал;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.8.20.чуулганы хуралдааны дэг болон дэг сахиулах асуудал;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p>	<p>23.5.Төрийн байгуулалтын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн шинэтгэлийн асуудал;</p> <p>23.5.2.төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн асуудал;</p> <p>23.5.3.Монгол Улсын Үндсэн Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүний улс төрийн өндөр мэргэшилтэй эсэх асуудал;</p> <p>23.5.4.засаг захиргааны шинэтгэл, төвлөрлийг сааруулах бодлого;</p> <p>23.5.5.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль, хот, тосгоны Зөвлөл, Захирагчийн сонгууль;</p> <p>23.5.6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс, хот, тосгоны эрх зүйн үндэс;</p> <p>23.5.7.нутгийн өөрөө удирдах ёс;</p> <p>23.5.8.төрийн алба;</p> <p>23.5.9.төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;</p> <p>23.5.10.ард нийтийн санал асуулга;</p> <p>23.5.11.төр, сүм хийдийн харилцаа;</p> <p>23.5.12.хэвлэл мэдээллийн хараат бус байдал;</p> <p>23.5.13.төрийн бус байгууллага, улс төрийн нам;</p> <p>23.5.14.Улсын Их Хурлын хууль тогтоомж;</p> <p>23.5.15.гишүүний халдашгүй байдал, бүрэн эрх, түүний баталгаа;</p> <p>23.5.16.бүсчилсэн хөгжлийн бодлого;</p> <p>23.5.17.гишүүний ёс зүй, сахилга, гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг;</p> <p>23.5.18.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэх гишүүний чуулганы ажиллагаанд оролцох асуудал;</p> <p>23.5.19.чуулганы хуралдааны дэг болон дэг сахиулах асуудал;</p> <p>23.5.20.төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого.</p>

23.8.21.төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагын бодлого. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнууд парламентын дотоод зохион байгуулалт, төрийн байгуулалтай холбоотой асуудлыг хариуцсан байнгын хороодыг өөр өөр нэршил, эрхлэх асуудлын хүрээгээр хуульчилсан байна. Тухайлбал:

Франц Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж, ерөнхий захиргааны хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸³

- Үндсэн хууль, парламентын дэг журам;
- сонгуулийн эрх зүй;
- төрийн захиргааны ерөнхий тогтолцоо;
- орон нутгийн засаг захиргаа;
- төрийн албаны эрх зүйн зохицуулалт.

Өмнөд Солонгос Улсын Төрийн захиргаа, аюулгүй байдлын хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁴

- дотоод хэрэг, төрийн захиргааны бодлого;
- орон нутгийн засаг захиргааны асуудал;
- сонгуулийн байгууллагын захиргаа;
- төрийн албан хаагчдын бодлого, боловсон хүчний удирдлага.

Өмнөд Солонгос Улсын Төрийн байгуулалтын (House Steering) хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁵

- парламентын үйл ажиллагаа, дэг журам;
- төрийн дээд байгууллагуудын (Ерөнхийлөгчийн тамгын газар гэх мэт) үйл ажиллагаа.

Норвег Улсын Хяналт шалгалт, Үндсэн хуулийн асуудлын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁶

- Үндсэн хуулийн асуудал;
- сонгуулийн хууль тогтоомж;
- төрийн байгууллагад тавих парламентын хяналт;
- Үндсэн хуулийн хариуцлага.

Мөн Норвег Улсын Орон нутгийн засаг захиргаа, төрийн захиргааны байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- орон нутгийн засаг захиргаа;
- бүс нутгийн болон хөдөөгийн бодлого;
- төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт;
- цагаачлал, орон сууцны бодлого;
- улс төрийн намын санхүүжилт.

Итали Улсын Үндсэн хууль, Дотоод хэргийн хороо (I хороо) дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁷

- Үндсэн хуулийн бодлого;
- гүйцэтгэх засаглалын төв байгууллагын үйл ажиллагаа;
- дотоод хэрэг, төрийн захиргааны зохицуулалт;

⁸³ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁸⁴ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁸⁵ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁸⁶ Норвег: (2024). “Стортингийн дэгийн тухай хууль” Хандах: https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

⁸⁷ Итали: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах: https://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/Regolamento_ENG.pdf

- хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцэх байдлын дүгнэлт гаргах.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.9.Төсвийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.9.1.улсын нэгдсэн төсөв;</p> <p>23.9.2.улсын төсвийн орлого, зарлага, төсвийн хяналт;</p> <p>23.9.3.төрийн санхүү, зээл, тусламжийн болон татварын бодлого;</p> <p>23.9.4.гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл;</p> <p>23.9.5.Засгийн газрын тусгай сангийн нэгдсэн бодлого;</p> <p>23.9.6.Улсын Их Хурлын төсвийн төлөвлөлт;</p> <p>23.9.7.аудитын асуудал;</p> <p>23.9.8.төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал.</p>	<p>23.6.Төсвийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.6.1.улсын нэгдсэн төсөв;</p> <p>23.6.2.улсын төсвийн орлого, зарлага, төсвийн хяналт;</p> <p>23.6.3.төрийн санхүү, зээл, тусламжийн болон татварын бодлого;</p> <p>23.6.4.Засгийн газрын тусгай сангийн нэгдсэн бодлого;</p> <p>23.6.5.Улсын Их Хурлын төсвийн төлөвлөлт;</p> <p>23.6.6.гадаад улс, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл;</p> <p>23.6.7.аудитын асуудал;</p> <p>23.6.8.төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Засгийн газраас гаргах үнэт цаасны тухай асуудал.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнууд төсөв, санхүү, эдийн засгийн бодлого, төсвийн хяналттай холбоотой асуудлыг хариуцсан байнгын хороодыг өөр өөр нэршил, эрхлэх асуудлын хүрээгээр хуульчилсан байна. Тухайлбал: Франц Улсын Санхүү, ерөнхий эдийн засаг, төсвийн хяналтын хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁸

- улсын санхүү, санхүүгийн хууль тогтоомж;
- төсвийн бодлого, олон жилийн санхүүгийн төлөвлөлт;
- төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;
- татвар, мөнгөний бодлого, банк, даатгал;
- төрийн өмч, төрийн оролцоотой аж ахуйн нэгж;
- яамдын төсөв, зарцуулалтын хяналт.

Өмнөд Солонгос Улсын Эдийн засаг, санхүүгийн хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁸⁹

- эдийн засаг, санхүүгийн бодлого;
- төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлого.

Төсөв, дансны тооцооны тусгай хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- улсын төсвийн төсөл, төлөвлөлт;
- төсвийн гүйцэтгэл, дансны тооцоо;
- төсөвт нөлөөлөх хуулийн төслийн зардлын тооцоо.

Шинэ Зеланд Улсын Санхүү, зарлагын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁰

- төсвийн бодлого, татвар, орлого;
- эдийн засгийн бодлого, банк, даатгал, тэтгэвэр;
- төрийн аудит;
- засгийн газрын зарлага, санхүүгийн гүйцэтгэл;
- жилийн санхүүгийн тайланд хяналт тавих.

Норвег Улсын Санхүү, эдийн засгийн асуудлын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ.⁹¹

- эдийн засгийн бодлого, хөрөнгө, өрийн удирдлага;
- санхүүгийн зах зээл, санхүүгийн удирдлага;
- нягтлан бодох бүртгэл, аудит;

⁸⁸ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

⁸⁹ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁹⁰ Шинэ Зеланд: (2023). Нийтийн танхимын дэгийн тухай хууль. Хандах: <https://www.parliament.nz/media/10573/standing-orders-2023.pdf>

⁹¹ Норвег: (2024). “Стортингийн дэгийн тухай хууль” Хандах: https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

- татвар, хураамж, тариф;
- парламентын төсвийн хуваарилалт.

Өмнөд Африкийн Улсын Санхүүгийн байнгын хороо болон Төсвийн хуваарилалтын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁹²

- мөнгөний хуулийн төслүүдийн хэлэлцүүлэг, нэмэлт өөрчлөлт;
- нийтийн хөрөнгө, төсвийн зарцуулалтад хяналт тавих;
- төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- ерөнхий аудиторын тайланг хянан хэлэлцэх.

Япон Улсын Төсвийн хороо болон Аудитын хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁹³

- улсын төсвийн төсөл, батлах үйл явц;
- төсвийн зарцуулалт, нөөц сангийн ашиглалт;
- төрийн сангийн тайлан, үүрэг амлалт;
- аудитын байгууллагын шалгалт, дүгнэлт.

АНУ-ын (Төлөөлөгчдийн танхим)ын Төсвийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁴

- төсвийн нэгдсэн бодлого, тогтоол;
- төсвийн үйл явц, зохицуулалт;
- холбооны төсөвт хяналт тавих.

АНУ-ын Зам, сувгийн хороо (Ways and Means) дараах асуудлыг эрхэлнэ:

- татвар, орлогын бодлого;
- улсын өр, санхүүгийн үүрэг;
- төрийн мөнгөн хөрөнгийн удирдлага.

Канад Улсын Засгийн газрын үйл ажиллагаа, төсөөллийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁵

- төсвийн төсөөлөл, зарлагын төлөвлөлт;
- төрийн байгууллагуудын санхүү, удирдлага;
- татварын зардал, зээлийн баталгаа;
- онцгой нөхцөлийн сан, нөөц сангийн зохицуулалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.10.Хууль зүйн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.10.1.эрх зүйн бодлого;</p> <p>23.10.2.хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа;</p> <p>23.10.3.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого;</p> <p>23.10.4.улсын хил хамгаалалтын бодлогын хэрэгжилт;</p> <p>23.10.5.хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;</p> <p>23.10.6.шүүх эрх мэдлийн эрх зүйн үндэс, хараат бус байдлыг хангах асуудал;</p> <p>23.10.7.прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэл;</p> <p>23.10.8.нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;</p> <p>23.10.9.эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргаан, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа;</p>	<p>23.7.Хууль зүй, хүний эрхийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.7.1.Үндсэн хуулийн дэг журам, иргэний үндсэн эрх, эрх чөлөө, эрх зүйн бодлого;</p> <p>23.7.2.хүний эрх, түүний баталгаа;</p> <p>23.7.3.гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого;</p> <p>23.7.4.хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;</p> <p>23.7.5.шүүх эрх мэдлийн эрх зүйн үндэс, хараат бус байдлыг хангах асуудал;</p> <p>23.7.6.хууль сахиулах, мөрдөн шалгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, прокурорын үйл ажиллагаа;</p> <p>23.7.7.нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;</p> <p>23.7.8.эрүү, иргэн, захиргааны хэрэг, маргаан, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа;</p> <p>23.7.9.өршөөл үзүүлэх асуудал;</p>

⁹² Өмнөд Африк (2016). “Үндэсний Ассамблейн дүрэм”. Хандах: <https://www.parliament.gov.za/rules-of-na>

⁹³ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

⁹⁴ АНУ: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах: <https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

⁹⁵ Канад: (2025) Төлөөлөгчдийн танхимын дотоод журам. Хандах: <https://www.ourcommons.ca/procedure/standing-orders/index-e.html>

<p>23.10.10.өршөөл үзүүлэх асуудал; 23.10.11.патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг; 23.10.12.цагаачлал, иргэний харьяалал; 23.10.13.архив; 23.10.14.эрх зүйн туслалцаа; 23.10.15.өмгөөлөл; 23.10.16.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл; 23.10.17.улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах асуудал.</p>	<p>23.7.10.патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг; 23.7.11.цагаачлал, иргэний харьяалал; 23.7.12.архив; 23.7.13.эрх зүйн туслалцаа; 23.7.14.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл; 23.7.15.улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах асуудал; 23.7.16.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны журам, гишүүний томилгоо.</p>
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: АНУ-ын (Төлөөлөгчдийн танхим) Хууль зүйн хороо (Committee on the Judiciary) дараах асуудлыг эрхэлнэ.⁹⁶

- иргэний болон эрүүгийн шүүх ажиллагаа, шүүх эрх мэдлийн тогтолцоо;
- захиргааны практик, процедур;
- Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал;
- иргэний эрх, эрх чөлөө;
- эрүүгийн хууль тогтоомж, гэмт хэрэгт тооцох асуудал;
- холбооны шүүхүүд, шүүгчдийн томилгоо, үйл ажиллагаа;
- цагаачлалын бодлого, хилийн бус хяналт;
- оюуны өмч (патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг);
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
- хууль тогтоомжийн кодчилал, шинэчилсэн найруулга;
- дотоод аюулгүй байдалд холбогдох зарим гэмт хэрэг.

Шинэ Зеланд Улсын Хууль зүйн хороо (Justice Committee) дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁷

- Үндсэн хууль, сонгуулийн эрх зүй;
- хүний эрх;
- шүүхийн тогтолцоо, шударга ёсны бодлого;
- эрүүгийн хууль тогтоомж, гэмт хэрэг;
- цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэл;
- төрийн хууль зүйн үйлчилгээ.

БНСУ-ын Хууль тогтоомж, хууль зүйн хороо (Legislation and Judiciary Committee) дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁸

- хууль зүйн яам болон хууль тогтоомжийн асуудал;
- Үндсэн хуулийн цэцийн захиргааны асуудал;
- шүүх болон цэргийн шүүхийн захиргаа;
- хууль, тогтоолын төслийн бүтэц, найруулгын хяналт.

Норвег Улсын Хууль зүйн байнгын хороо (Standing Committee on Justice) дараах асуудлыг эрхэлнэ:⁹⁹

- шүүхийн тогтолцоо;
- цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад холбогдох асуудал;
- эрүүгийн хууль;
- процессын болон иргэний ерөнхий хууль тогтоомж;
- захиргааны ерөнхий хууль;
- өршөөл, нөхөн төлбөртэй холбоотой асуудал.

⁹⁶ АНУ: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах:

<https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

⁹⁷ Шинэ Зеланд: (2023). Нийтийн Танхимын дэгийн тухай хууль. Хандах:

<https://www.parliament.nz/media/10573/standing-orders-2023.pdf>

⁹⁸ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах:

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

⁹⁹ Норвег: (2024). “Стортингийн дэгийн тухай хууль” Хандах:

https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf

Франц Улсын Үндсэн хууль, хууль тогтоомж, ерөнхий захиргааны хороо дараах асуудлыг эрхэлнэ:¹⁰⁰

- Үндсэн хууль, сонгуулийн эрх зүй, парламентын дэг;
- үндсэн эрх, нийтийн эрх чөлөө;
- шүүхийн зохион байгуулалт;
- иргэний, арилжааны болон эрүүгийн эрх зүй;
- захиргааны эрх зүй, төрийн албаны зохицуулалт.

Их Британи Улсын Хууль зүйн хороо (Justice Committee) дараах асуудлыг эрхэлнэ:¹⁰¹

- хууль зүйн яамны бодлого, үйл ажиллагаа;
- шүүх, трибуналын захиргаа;
- прокурорын байгууллагын үйл ажиллагаа;
- Ерөнхий прокурорын газрын зардал, удирдлага;
- ноцтой залилангийн эсрэг байгууллагын үйл ажиллагаа.

Япон Улсын Хууль зүйн хороо (Committee on Judicial Affairs) дараах асуудлыг эрхэлнэ:¹⁰²

- хууль зүйн яамны харьяа бодлого, үйл ажиллагаа;
- шүүхийн шүүх эрх мэдлийн захиргаатай холбоотой асуудлууд.

Итали Улсын Хууль зүйн хороо (II хороо - Justice) дараах асуудлыг эрхэлнэ:¹⁰³

- хууль зүйн салбарын бодлого, хууль тогтоомж, хэрэгжилт.

Швейцар Улсын Хууль зүйн асуудал эрхэлсэн байнгын хорооны тусгайлан эрхлэх чиг үүргийн хүрээнд:¹⁰⁴

- Швейцар болон олон улсын иргэний эрх зүй, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй (үүнд өр төлбөр барагдуулах, дампуурал, олон улсын хувийн эрх зүй багтана);
- Шударга бус өрсөлдөөн (гэрээний асуудлууд, төөрөгдүүлсэн болон харьцуулсан зар сурталчилгаа, шударга бус гэрээний нөхцөл);
- Газрын эрх зүй;
- Швейцар болон олон улсын эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй, ял эдлүүлэх эрх зүй (үүнд мөнгө угаах гэмт хэрэг багтана);
- Шүүх эрх мэдлийн байгууллагууд;
- Албадан дайчлан авах (Expropriation);
- Дархан эрх (зөвхөн Төлөөлөгчдийн зөвлөлд), өршөөл (татварын өршөөлийг оруулахгүй);
- Захиргааны ерөнхий хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүй;
- Өмгөөлөгч болон нотариатчидын асуудал тус тус хамаарч байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
23.3.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: 23.3.1.газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого; 23.3.2.хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал; 23.3.3.хөдөөгийн хөгжлийн бодлого; 23.3.4.мал аж ахуйн бодлого; 23.3.5.малын даатгал болон малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах;	23.8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ: 23.8.1.бэлчээр, тариалангийн газрын бодлого; 23.8.2.хүнсний хангамж, баталгаат байдал, хүнсний үйлдвэрлэлийн бүтээмжийн өсөлт; 23.8.3.жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;

¹⁰⁰ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах:

<https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

¹⁰¹ Их Британи: (2025). “Нийтийн танхимын дотоод журам” (Standing Orders of the House of Commons).

¹⁰² Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах:

<https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

¹⁰³ Итали: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах:

https://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/Regolamento_ENG.pdf

¹⁰⁴ Швейцар: Хууль зүйн байнгын хороо (Legal Affairs Committees, LAC). Хандах:

<https://www.parlament.ch/en/organe/committees/specialist-committees/committees-lac>

<p>23.3.6.газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;</p> <p>23.3.7.улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;</p> <p>23.3.8.геологи, уул уурхайн холбогдолтой эрэл, хайгуул, ашиглалтын ажилд тавих байгаль орчны хяналт;</p> <p>23.3.9.агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал;</p> <p>23.3.10.цаг уур, орчны хяналтын асуудал;</p> <p>23.3.11.усны бодлого, нөөц, усны бохирдол;</p> <p>23.3.12.хог хаягдал, дахин боловсруулалт;</p> <p>23.3.13.байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах асуудал;</p> <p>23.3.14.байгаль орчны судалгаа, хөгжил;</p> <p>23.3.15.ан агнуур;</p> <p>23.3.16.газрын сангийн нэгдсэн бодлого, зохицуулалт;</p> <p>23.3.17.газрын кадастр, зураглал.</p>	<p>23.8.4.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>23.8.5.хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн логистик, дэд бүтэц;</p> <p>23.8.6.үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлого;</p> <p>23.8.7.хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт, тэдгээрийн аюулгүй байдал;</p> <p>23.8.8.хөдөөгийн хөгжлийн бодлого;</p> <p>23.8.9.газар тариалан, мал аж ахуй, үрийн аж ахуйн бодлого;</p> <p>23.8.10.газар тариалан, малын даатгалын бодлого;</p> <p>23.8.11.малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах.</p>
--	---

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Нэг танхимтай парламентуудын аж үйлдвэржилтийн бодлого эрхэлсэн байнгын хороодын эрхлэх асуудал дараах байдлаар улс орон бүрд ялгаатай зохицуулагдсан байна.¹⁰⁵

Хүснэгт 3. Нэг танхимтай парламенттай улс орнуудын аж үйлдвэржилтийн бодлого эрхэлсэн байнгын хороодын эрхлэх асуудал

Улс, парламентын нэр (нийт гишүүдийн тоо)	Байнгын хорооны нэр (гишүүдийн тоо)	Эрхлэх асуудал
1. БОЛГАР Үндэсний Ассамблей (240 гишүүнтэй)	Эдийн засгийн бодлого, инновацын байнгын хороо (19 ¹⁰⁶ гишүүнтэй) (<i>Committee on Economic Policy and Innovation</i>)	<p>Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, дэгийн тухай хуульд уг байнгын хорооны эрхлэх асуудлыг тодорхой тусгаагүй байна. Үндэсний Ассамблейн албан ёсны цахим хуудаст дурдсанаар тус байнгын хороо нь дараах асуудлыг эрхэлдэг:</p> <ul style="list-style-type: none"> • эдийн засгийн бодлого; • аж үйлдвэрийн хөгжил; • худалдаа, үйлчилгээний салбар; • жижиг, дунд бизнесийн бодлого; • инновац, технологийн хөгжил; • хөрөнгө оруулалтын орчин; • төр, хувийн хэвшлийн түншлэл; • зах зээлийн зохицуулалт. <p>Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, дэгийн тухай хуулийн¹⁰⁷ §21(4)-д тус байнгын хорооны дэргэд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон Монопол эрх мэдлийг хязгаарлахтай холбоотой асуудалд хяналт тавих байнгын ажиллагаатай дэд хороо байгуулахаар заасан байна.</p>
2. БОТСВАНА	Санхүү, худалдаа,	<p>Үндэсний Ассамблейн дэгийн тухай хуулийн¹⁰⁸ §117(E)2:</p> <ul style="list-style-type: none"> • санхүү;

¹⁰⁵ ПСХХ (2025). Нэг танхимтай парламентуудын аж үйлдвэржилтийн бодлого эрхэлсэн байнгын хороодын эрхлэх асуудал (СТ-25/405)

¹⁰⁶ Болгар: Үндэсний Ассамблейн цахим хуудас. (Committee on Economic Policy and Innovation). Хандах линк: <https://www.parliament.bg/en/parliamentarycommittees/3599>

¹⁰⁷ Болгар: (2024). “Үндэсний Ассамблейн зохион байгуулалт, дэгийн тухай хууль”. Хандах линк: <https://www.parliament.bg/en/podns>

¹⁰⁸ Ботсвана: (2017) [2022]. Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль (Standing Orders of the National Assembly of Botswana) (2017[2022]). Хандах:

https://www.parliament.gov.bw/index.php?Itemid=650&id=235&option=com_content&view=article

	Үндэсний Ассамблей (65 гишүүнтэй)	Эдийн засгийн хөгжлийн байнгын хороо (8 гишүүнтэй) (Committee on Finance, Trade and Economic Development)	<ul style="list-style-type: none"> • хөгжлийн бодлого; • худалдаа; • аж үйлдвэр. <p>Дээрх асуудлыг эрхэлсэн Засгийн газрын яам, агентлаг, байгууллагуудын үйл ажиллагаанд парламентын хяналт, шалгалт хийнэ.</p>
3.	ИЗРАИЛ Кнессет (120 гишүүнтэй)	Эдийн засгийн асуудлын байнгын хороо (24 гишүүнтэй) (Economic Affairs Committee)	Кнессетийн хуралдааны дэгийн тухай хуулийн ¹⁰⁹ §100(3): <ul style="list-style-type: none"> • аж үйлдвэр, худалдаа; • хэрэглээ, хангамж болон төсөвлөлт • хөдөө аж ахуй, загасны аж ахуй; • тээврийн бүх салбар; • хамтын нийгэмлэгүүд (cooperatives); • эдийн засгийн төлөвлөлт зохицуулалт; • хөгжлийн бодлого; • төрийн концесс, эд хөрөнгийн • итгэмжлэлийн асуудал; • эзэнгүй араб иргэдийн өмч; • дайсагнагч орнууд дахь еврей иргэдийн өмч; • нас барсан еврей иргэдийн өмч.
4.	КОСТА РИКА Хууль Тогтоох Ассамблей (57 гишүүнтэй)	Эдийн засгийн байнгын хороо (9 гишүүнтэй) (Comisión de Asuntos Económicos)	Хууль Тогтоох Ассамблейн дэгийн тухай хуулийн ¹¹⁰ §66: <ul style="list-style-type: none"> • эдийн засаг; • худалдаа; • аж үйлдвэр; • нийтлэг зах зээл; • бүс нутгийн интеграци.
5.	ЛАТВИ Сейм (100 гишүүнтэй)	Эдийн засаг, хөдөө аж ахуй, байгаль орчин болон бүс нутгийн бодлогын байнгын хороо (12 гишүүнтэй) (Economic, Agricultural, Environmental and Regional Policy Committee)	Тус хороо нь дараах асуудлыг эрхэлдэг (Saeima of the Republic of Latvia, 2025): <ol style="list-style-type: none"> 1) эдийн засагтай холбоотой асуудал¹¹¹: <ul style="list-style-type: none"> • хөдөө аж ахуй • барилга; • эрчим хүч; • харилцаа холбоо; • тээвэр (газрын, агаарын, далайн болон боомтын удирдлага); 2) байгаль орчны хамгаалал, бүс нутгийн эдийн засгийн бодлого; 3) бусад: <ul style="list-style-type: none"> • худалдаа; • зар сурталчилгаа; • хэрэглэгчийн эрхийг хамгаалах; • худалдаа, өрсөлдөөний зохицуулалт; • төрийн худалдан авалт; • нийтийн үйлчилгээний зохицуулалт; • төрийн өмчит аж ахуйн нэгжийн удирдлага; • хувьчлал; • газар ашиглалт; • аялал жуулчлал; • бараа, үйлчилгээний аюулгүй байдал; • цахим харилцаа холбоо; • амьтан хамгаалал; • хог хаягдлын менежмент; • ан агнуур, ой аж ахуйн удирдлага.

¹⁰⁹ Израил: Кнессетийн хуралдааны дэгийн тухай хууль (*Rules of Procedure of the Knesset*) (2023).

Хандах линк: <https://main.knesset.gov.il/EN/activity/Documents/RulesOfProcedure/ChapterH1.pdf>

¹¹⁰ Коста Рика: Хууль Тогтоох Ассамблейн дэгийн тухай хууль (*Reglamento de la Asamblea Legislativa de Costa Rica*) (1995 [2023]). Хандах линк:

<https://www.asamblea.go.cr/ca/Reglamentos%20de%20la%20Asamblea/Reglamento de la Asamblea Legislativa.pdf>

¹¹¹ Латви Сеймийн албан ёсны цахим хуудас. (Economic, Agricultural, Environmental and Regional Policy Committee). Хандах линк: https://www.saeima.lv/faktulapas/Tautsaimniecibas_komisija_EN.pdf

6.	ЛИТВА Сейм (141 гишүүнтэй)	Эдийн засгийн байнгын хороо (13 гишүүнтэй) (Committee on Economics)	Бүгд Найрамдах Литва Улсын Сеймийн дэгийн тухай хуулийн ¹¹² §60: <ul style="list-style-type: none"> эрчим хүч, тээвэр (агаар, усан зам, төмөр зам, авто зам), хөдөлгөөний аюулгүй байдал, дэд бүтэц, ложистик, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, төрийн өмчийн ашиглалт, захиран зарцуулалт, хувьчлал, төрийн худалдан авалт, эдийн засгийн чөлөөт бүс; аж ахуйн нэгж, төр хувийн хэвшлийн түншлэл, төрийн бус байгууллага; эдийн засгийн хөгжлийн урт хугацааны стратеги, макро эдийн засаг, өрсөлдөх чадвар, жижиг, дунд үйлдвэр, хөрөнгө оруулалт; төрийн сангуудын хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих; дигитал эдийн засаг, инновац, технологийн хөгжил.
7.	ЛЮКСЕМБ УРГ Төлөөлөгчдийн Танхим (60 гишүүнтэй)	Эдийн засаг, жижиг дунд үйлдвэр, эрчим хүч, сансар судлал болон аялал жуулчлалын байнгын хороо ¹¹³ (23 гишүүнтэй) (Committee on the Economy, Small and Medium-sized Enterprises, Energy, Space and Tourism)	Төлөөлөгчдийн Танхимын 22 байнгын хорооны нэг нь Эдийн засаг, жижиг, дунд үйлдвэр, эрчим хүч, сансар, аялал жуулчлалын байнгын хороо юм (Chamber des deputes Luxembourg, 2023): <ul style="list-style-type: none"> эдийн засгийн бодлого; жижиг дунд үйлдвэрүүд; эрчим хүчний бодлого; сансар судлал; аялал жуулчлал.
8.	НОРВЕГ Стортинг (169 гишүүнтэй)	Бизнес, аж үйлдвэрийн байнгын хороо (17 гишүүнтэй) (Standing Committee on Business and Industry)	Стортингийн дэгийн тухай хуулийн ¹¹⁴ §14(9): <ul style="list-style-type: none"> бизнес, аж үйлдвэр, худалдаа; далайн тээвэр; төрийн өмчийн бодлого; экспортын төрийн баталгаа; өрсөлдөөний болон үнийн бодлого; хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн хэлэлцээр; хүнсний бодлого; загас агнуур; халим загасны агнуур; усны аж ахуй; яргай загасны агнуур.
9.	ӨМНӨД СОЛОНГОС Үндэсний Ассамблей (300 гишүүнтэй)	Аж үйлдвэр, худалдаа, эрчим хүч, жижиг, дунд үйлдвэр, гарааны бизнесийн байнгын хороо (26 гишүүнтэй) (Trade, Industry, Energy, SMEs, and Startups Committee)	Үндэсний Ассамблейн тухай хуулийн ¹¹⁵ §37(1): <ul style="list-style-type: none"> аж үйлдвэр; худалдаа; эрчим хүч; жижиг, дунд үйлдвэр; гарааны бизнес.
10.	ПОРТУГАЛ	Эдийн засаг, олон нийтийн	Эдийн засаг, нийтийн аж ахуй, төлөвлөлт, орон сууцны байнгын хорооны дотоод журмын ¹¹⁶ §2:

¹¹² Литва: Бүгд Найрамдах Литва Улсын Сеймийн дэгийн тухай хууль (Seimas of the republic of Lithuania statute) (1994 [2024]). Хандах: <https://e-seimas.lrs.lt/portal/legalAct/lt/TAD/28280b424a6511efb121d2fe3a0eff27?jfwid=>

¹¹³ Люксембург Төлөөлөгчдийн Танхимын дэгийн тухай хууль (Rules of Procedure of the Chamber of Deputies) (2025). Хандах: <https://www.chd.lu/sites/default/files/2025-04/reglement-chd-15-03-2025.pdf>.

¹¹⁴ Норвег: (2024). Стортингийн дэгийн тухай хууль Хандах: https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

¹¹⁵ Өмнөд Солонгос: (2000 [2023]). “Үндэсний Ассамблейн тухай хууль” Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=25732&lang=ENG

¹¹⁶ Португал: Эдийн засаг, нийтийн аж ахуй, төлөвлөлт, орон сууцны байнгын хорооны дотоод журам (Rules of Procedure of the Standing Committee on Economy, Public Works, Planning and Housing)

	Бүгд Найрамдах Улсын Ассамблей (230 гишүүнтэй)	ажил, төлөвлөлт, орон сууцны хороо (25 гишүүнтэй) (Standing Committee on Economy, Public Works, Planning and Housing)	<ul style="list-style-type: none"> • аж үйлдвэр; • үйлдвэрлэлийн өмчийн удирдлага; • худалдаа, үйлчилгээ; • эдийн засгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалт; • гадаадын хөрөнгө оруулалт татах загварууд; • аялал жуулчлал; • өрсөлдөөн; • хэрэглэгчийн эрхийг хамгаалах; • шинжлэх ухаан, технологийн хөгжил, шилжүүлэг; • барилга, олон нийтийн ажил; • харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээ; • орон сууцны бодлого, түрээс, хотын менежмент, засвар, сэргээн босголтын бодлого.
11.	ФИНЛАНД Риксдаг (200 гишүүнтэй)	Эдийн засгийн байнгын хороо (26 гишүүнтэй) (Commerce Committee)	Парламентын дэгийн тухай хуулийн ¹¹⁷ §7-д нэрлэсэн Эдийн засгийн байнгын хороо: <ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэл, худалдаа; • аж үйлдвэр; • эрчим хүч; • бизнесийн байгууллагууд, аж ахуйн нэгж; • өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх; • банк, санхүүгийн байгууллагууд; • хувийн даатгалын үйл ажиллагаа; • санхүү, үнэт цаасны зах зээл; • бусад хороодын хариуцдаггүй төрийн өмчийн компаниудын асуудал¹¹⁸.
12.	ШВЕД Риксдаг (349 гишүүнтэй)	Аж үйлдвэр, худалдаа, эдийн засгийн байнгын хороо (17 гишүүнтэй) (Committee on Trade and Industry)	Риксдагийн тухай хуулийн ¹¹⁹ хавсралтын §7.5.1-ын нэмэлт заалтын 14 дүгээр дэд хэсэг: <ul style="list-style-type: none"> • аж үйлдвэр, гар урлал; • худалдаа; • эдийн засгийн бодлого; • инновац, технологи; • хэрэглэгчийн эрх; • эрчим хүч; • улсын өмчит компаниуд; • үнэ ба өрсөлдөөн.
13.	ШИНЭ ЗЕЛАНД Парламент (123 гишүүнтэй)	Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, инновацын байнгын хороо (54 гишүүнтэй) (Economic Development, Science and Innovation Committee)	Төлөөлөгчдийн Танхимын дэгийн тухай хуулийн ¹²⁰ §189: <ul style="list-style-type: none"> • бизнесийн хөгжил; • аялал жуулчлал; • төрийн эзэмшлийн ашигт малтмал (crown minerals); • худалдаа, хэрэглэгчийн эрх, худалдааны стандарт; • судалгаа, шинжлэх ухаан; • инновац; • оюуны өмч; • өргөн нэвтрүүлэг, харилцаа холбоо; • мэдээллийн технологи.
14.	ЭСТОНИ Рийгикогу (101 гишүүнтэй)	Эдийн засгийн байнгын хороо (10 гишүүнтэй) (Economic Affairs Committee)	Тус хороо нь эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг салбаруудын хүрээнд хууль тогтоох үйл ажиллагааг удирдан чиглүүлж, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй бөгөөд дараах асуудлуудыг хариуцан хэлэлцдэг ¹²¹ : <ul style="list-style-type: none"> • барилга, орон сууцны бодлого; • шуудан, цахим холбоо; • эрчим хүч; • тээвэр; • аялал жуулчлал;

¹¹⁷ Финланд: (1999 [2013]). "Парламентын дэгийн тухай хууль". Хандах: https://www.parliament.fi/EN/naineduskuntatoimii/Documents/parliaments_rules_of_procedure.pdf.

¹¹⁸ Финланд: Риксдагийн албан ёсны цахим хуудас (Commerce Committee) Хандах: <https://www.eduskunta.fi/EN/valiokunnat/talousvaliokunta/Pages/default.aspx>.

¹¹⁹ Швед: (2014 [2023]). Риксдагийн тухай хууль (Riksdag Act) Хандах: https://www.riksdagen.se/globalassets/05.-sa-fungerar-riksdagen/demokrati/the-riksdag-act-2023_new.pdf.


¹²⁰ Шинэ Зеланд: (2023). Төлөөлөгчдийн Танхимын дэгийн тухай хууль Хандах: <https://www.parliament.nz/media/10573/standing-orders-2023.pdf>

¹²¹ Эстони: Рийгикогуын албан ёсны цахим хуудас. Хандах линк: <https://www.riigikogu.ee/en/parliament-of-estonia/committees/economic-affairs-committee/>.

			<ul style="list-style-type: none"> • төрийн өмч; • төрийн худалдан авалт; • бараа, үйлчилгээний чанарт тавигдах шаардлага; • эдийн засгийн хөгжлийн бодлого; • бизнес эрхлэлтийг дэмжих бодлого.
--	--	--	---

Байнгын хорооны нэрийн хувьд, судалгаанд хамрагдсан 14 улсын парламентын дийлэнх нь эдийн засаг, аж үйлдвэр, худалдаа, жижиг, дунд үйлдвэр, инновац зэрэг асуудлыг багтаасан нэгдмэл бүтэцтэй байнгын хороо байгуулан ажиллуулж байна. Ихэнх тохиолдолд эдийн засаг болон үйлдвэрлэлийн бодлогыг нэгтгэсэн бүтэц зонхилж байна. Байнгын хороодын гишүүдийн тоо дунджаар 10–25 гишүүнтэй байна. Парламентуудын нийт гишүүдийн тоонд байнгын хорооны гишүүдийн эзлэх хувийг харьцуулж үзэхэд, Люксембург, Израил, Коста Рика зэрэг улсад энэ үзүүлэлт харьцангуй өндөр байхад Швед, Шинэ Зеланд хамгийн бага хувийг эзэлж байна (Зураг 1).

Зураг 1. Парламентын нийт гишүүдийн тоонд байнгын хорооны гишүүдийн эзлэх хувь



Судалгаад хамрагдсан 14 улсын парламентын байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооныхтой харьцуулахад, дараах чиглэлүүдэд төстэй байдал ажиглагдаж байна. (Зураг 2.) Үүнд:

- 1) **бизнес, хөрөнгө оруулалт, төр-хувийн түншлэл:** Болгар, Ботсвана, Литва, Финланд зэрэг улсад эдгээр чиглэл тусгайлан зохицуулагддаг нь парламентын бодлогод эдийн засгийн түншлэл, хөрөнгө оруулалтын орчныг стратегийн түвшинд авч үздэг байна;
- 2) **жижиг, дунд үйлдвэрлэл:** Болгар, Люксембург, Өмнөд Солонгос, Финланд, Швед зэрэг улсын холбогдох байнгын хороодын бүрэн эрхэд жижиг, дунд үйлдвэрийн дэмжлэгийг тусгасан нь зохицуулалт, хяналтыг хууль тогтоох түвшинд хэрэгжүүлж байна;
- 3) **инновац, технологи, бүтээмж:** Болгар, Португал, Швед, Шинэ Зеланд зэрэг улсад шинжлэх ухаанд суурилсан хөгжлийн бодлогыг хууль тогтоох бодлогын төвд байршуулсан байна;
- 4) **хөнгөн болон хүнд үйлдвэрлэл:** Израил, Литва, Норвег зэрэг улсад аж үйлдвэрийн бодлого мэргэшсэн байнгын хорооны чиг үүрэгт багтаж, үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн зохицуулалтыг онцгойлон авч үздэг байна;
- 5) **эрчим хүч, дэд бүтэц:** Латви, Люксембург, Финланд, Эстони зэрэг улсад эрчим хүч, тээвэр, барилгын асуудлыг нэгдмэл байдлаар хариуцдаг бүтэцтэй нь дэд бүтцийн хөгжлийг парламентын түвшинд зохион байгуулдаг байна.

Зураг 2. Байнгын хороодын эрхлэх асуудлын уялдаа



Эрх зүйн зохицуулалтын хувьд, судалгаанд авагдсан улс орнуудаас Норвег, Өмнөд Солонгос, Португал, Финланд, Шинэ Зеланд, Швед зэрэг улсын парламентын тухай хууль болон дэгийн тухай хуульд тодорхой тусгагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.11.Эдийн засгийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.11.1.эдийн засгийн дотоод, гадаад бодлого;</p> <p>23.11.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;</p> <p>23.11.3.төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа;</p> <p>23.11.4.даатгалын бодлого, энэ хуулийн 23.9.8-д зааснаас бусад үнэт цаасны тухай асуудал;</p> <p>23.11.5.төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого;</p> <p>23.11.6.гадаадын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;</p> <p>23.11.7.ашигт малтмалын суурь судалгаа, эрэл хайгуул, ашиглалтын бодлого;</p> <p>23.11.8.газрын тос, байгалийн хийн асуудал;</p> <p>23.11.9.үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого;</p> <p>23.11.10.шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого;</p> <p>23.11.11.төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;</p> <p>23.11.12.стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт;</p> <p>23.11.13.албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт;</p> <p>23.11.14.барилга, хот байгуулалт;</p> <p>23.11.15.түлш, эрчим хүч;</p> <p>23.11.16.зам тээвэр, шуудан;</p> <p>23.11.17.орон сууц, нийтийн аж ахуй;</p> <p>23.11.18.аялал жуулчлалын хөгжлийн стратеги;</p> <p>23.11.19.аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил;</p> <p>23.11.20.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого.</p> <p>23.11.21.жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p>	<p>23.9.Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.9.1.дигитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;</p> <p>23.9.2.цахим дэд бүтэц;</p> <p>23.9.3.мэдээллийн технологийн хөгжил;</p> <p>23.9.4.шуудан, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;</p> <p>23.9.5.хиймэл оюуны хөгжил;</p> <p>23.9.6.хиймэл оюуны бодлого, хяналт, зохицуулалтын асуудал.</p>

23.11.22.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.23.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.24.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.25.мэдээллийн технологийн хөгжил; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.26.харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.27.дижитал шилжилт, техник, технологийн шинэчлэл; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.28.өндөр технологи, үндэсний инновацын бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.29.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	
23.11.30.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./	

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Өмнөд Солонгос Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны хороо дараах асуудлыг эрхэлнэ.¹²²

- шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн бодлого;
- харилцаа холбооны салбарын зохицуулалт, хяналт;
- өргөн нэвтрүүлэг, мэдээллийн дэд бүтцийн хөгжил;

Энэтхэг Улсын Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хороо дараах асуудлыг эрхэлнэ.¹²³

- харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;
- электроник, мэдээллийн технологийн хөгжил;
- мэдээлэл, өргөн нэвтрүүлгийн салбарын зохицуулалт.

Бразил Улсын Шинжлэх ухаан, технологи, харилцаа холбоо, компьютерийн ухааны хороо дараах асуудлыг эрхэлнэ.¹²⁴

- шинжлэх ухаан, технологийн шинэчлэл, судалгаа;
- харилцаа холбооны бодлого, зохицуулалт;
- мэдээлэл зүй, дэвшилтэт технологийн хөгжил.

¹²² Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

¹²³ Энэтхэг: (2024). “Лок Сабха дахь дэгийн журам болон үйл ажиллагаа явуулах дүрэм”. Хандах: https://sansad.in/uploads/Rules_of_Procedures_E_9d8fd0f4c3.pdf?updated_at=2022-

¹²⁴ Бразил: (2006). “Бразил Улсын хууль тогтоох байгууллага: Төлөөлөгчдийн танхим”. Хандах: https://www2.camara.leg.br/english/CD_English.pdf

Шинэ Зеланд Улсын Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, инновацын хороо дараах асуудлыг эрхэлнэ:¹²⁵

- судалгаа, шинжлэх ухаан, инновацын бодлого;
- мэдээллийн технологийн хөгжил;
- өргөн нэвтрүүлэг, харилцаа холбооны зохицуулалт;
- оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт.

Франц Улсын Эдийн засгийн асуудлын хороо дараах асуудлыг эрхэлнэ:¹²⁶

- Хөдөө аж ахуй, загас агнуур;
- эрчим хүч, аж үйлдвэр;
- хэрэглээний судалгаа ба инновац;
- хэрэглэгчийн эрх ашиг, дотоод болон гадаад худалдаа;
- шуудан, цахим харилцаа холбоо;
- аялал жуулчлал;
- хот байгуулалт, орон сууц;
- хэрэглээний судалгаа, инновацын бодлого;
- шуудан болон цахим харилцаа холбооны бодлого, зохицуулалт.

Канад Улсын Үйлдвэрлэл, технологийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- үйлдвэрлэлийн салбар дахь технологийн шинэчлэл, хөгжүүлэлт.
- Засгийн газрын үйл ажиллагаа, тооцооллын хороо дараах асуудлыг эрхэлнэ:
- төрийн байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ;
- шинээр нэвтэрч буй технологийн үр ашиг, хэрэгжилтэд хяналт тавих.

АНУ (Төлөөлөгчдийн танхим)-ын Эрчим хүч, худалдааны хороо дараах асуудлыг эрхэлнэ:

- дотоод болон гадаад харилцаа холбооны зохицуулалт, бодлого.
- Шинжлэх ухаан, сансар судлал, технологийн хороо дараах асуудлыг эрхэлнэ:
- шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт;
- технологийн туршилт, инновацын дэмжлэг.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
23.11.Эдийн засгийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:	23.10.Эдийн засгийн байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:
23.11.1.эдийн засгийн дотоод, гадаад бодлого;	23.10.1.эдийн засгийн дотоод, гадаад бодлого;
23.11.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;	23.10.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
23.11.3.төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа;	23.10.3.төрийн мөнгөний бодлого, банк, Монголбанкны үйл ажиллагаа;
23.11.4.даатгалын бодлого, энэ хуулийн 23.9.8-д зааснаас бусад үнэт цаасны тухай асуудал;	23.10.4.банк бус санхүүгийн харилцаа, энэ хуулийн 23.6.8-д зааснаас бусад үнэт цаас;
23.11.5.төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого;	23.10.5.энэ хуулийн 23.8.10-д зааснаас бусад даатгалын бодлого;
23.11.6.гадаадын хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;	23.10.6.төрийн өмчийн удирдлага, зохицуулалт, хувьчлалын бодлого;
23.11.7.ашигт малтмалын суурь судалгаа, эрэл хайгуул, ашиглалтын бодлого;	23.10.7.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
23.11.8.газрын тос, байгалийн хийн асуудал;	23.10.8.шударга өрсөлдөөний бодлого;
23.11.9.үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого;	23.10.9.төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;
23.11.10.шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бодлого;	23.10.10.стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт;
23.11.11.төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;	23.10.11.албан ёсны статистикийн үйл ажиллагаа;

¹²⁵ Шинэ Зеланд: (2023). Нийтийн танхимын дэгийн тухай хууль. Хандах: <https://www.parliament.nz/media/10573/standing-orders-2023.pdf>

¹²⁶ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

<p>23.11.12.стандартчилал, хэмжил зүй, чанарын баталгаажуулалт;</p> <p>23.11.13.албан ёсны статистикийн үйл ажиллагааны зохицуулалт;</p> <p>23.11.14.барилга, хот байгуулалт;</p> <p>23.11.15.түлш, эрчим хүч;</p> <p>23.11.16.зам тээвэр, шуудан;</p> <p>23.11.17.орон сууц, нийтийн аж ахуй;</p> <p>23.11.18.аялал жуулчлалын хөгжлийн стратеги;</p> <p>23.11.19.аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил;</p> <p>23.11.20.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого.</p> <p>23.11.21.жигжиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.22.хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.23.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.24.цахим засаглалын бодлого, үйл ажиллагаа;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.25.мэдээллийн технологийн хөгжил;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.26.харилцаа холбооны бодлого, үйл ажиллагаа;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.27.дижитал шилжилт, техник, технологийн шинэчлэл;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.28.өндөр технологи, үндэсний инновацын бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.29.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого;</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p> <p>23.11.30.инновацын дэд бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэх бодлого.</p> <p>/Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн./</p>	<p>23.10.12.барилга, орон сууц, нийтийн аж ахуй;</p> <p>23.10.13.аялал жуулчлалын хөгжлийн бодлого;</p> <p>23.10.14.аялал жуулчлалын дэд бүтцийн хөгжил;</p> <p>23.10.15.газрын эдийн засгийн үр ашгийн бодлого;</p> <p>23.10.16.хүнд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлого;</p> <p>23.10.17.хүнд үйлдвэрлэлийн логистик, дэд бүтэц;</p> <p>23.10.18.газрын тос, байгалийн хийн асуудал;</p> <p>23.10.19.ашигт малтмал, түүний суурь судалгаа, хайгуул, ашиглалтын бодлого;</p> <p>23.10.20.түлшний хангамж, нөөцийн бодлого;</p> <p>23.10.21.эрчим хүчний нэгдсэн бодлого;</p> <p>23.10.22.зам, тээвэр;</p> <p>23.10.23.газрын сангийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, бүртгэл;</p> <p>23.10.24.инновацыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого.</p>
---	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Франц Улсад Эдийн засгийн асуудлын хороо нь хөдөө аж ахуй, загасны аж ахуй, эрчим хүч, үйлдвэрлэл, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, дотоод болон гадаад худалдаа, аялал жуулчлал, хот байгуулалт, орон сууцны бодлогын асуудлыг эрхэлдэг. Харин эдийн засгийн макро түвшний бодлого, улсын санхүү, төсвийн гүйцэтгэл, мөнгөний бодлогыг Санхүү, ерөнхий эдийн засаг, төсвийн хяналтын хороо тусад нь хариуцдаг.¹²⁷

¹²⁷ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

Шинэ Зеланд Улсад Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, инновацын хороо нь бизнес хөгжил, худалдаа, аялал жуулчлал, хэрэглэгчийн эрх, оюуны өмч, мэдээллийн технологийн асуудлыг эрхэлдэг. Үүнээс ялгаатайгаар эдийн засгийн бодлогын санхүүгийн хэсэг болох төсөв, татвар, банк, даатгал, төрийн аудитын асуудлыг Санхүү, зарлагын хороо хариуцдаг.¹²⁸

Өмнөд Солонгост Эдийн засаг, санхүүгийн хороо нь Эдийн засаг, санхүүгийн яам болон Төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогын асуудлыг хамтад нь эрхэлдэг. Мөн эдийн засгийн бодлогын чиглэлийг Худалдаа, үйлдвэрлэл, эрчим хүч, жижиг дунд үйлдвэрлэлийн хороо тусад нь хариуцдаг.¹²⁹

Япон Улсад Эдийн засаг, үйлдвэрлэлийн хороо нь Эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэлийн яам болон Шударга худалдааны комиссын харьяа асуудлыг эрхэлдэг. Харин макро эдийн засаг, санхүүгийн зохицуулалт, банк санхүүгийн тогтолцоотой холбоотой асуудлыг Санхүүгийн хороо тусад нь хариуцдаг.¹³⁰

Норвег Улсад Эдийн засаг, үйлдвэрлэлийн хороо нь далайн тээвэр, улсын өмчийн бодлого, экспортын баталгаа, үнийн бодлого зэрэг эдийн засгийн өргөн хүрээний бодлогыг хамардаг. Тус хороо нь мөн гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын хэрэгжилтийг үнэлэх чиг үүрэгтэй.¹³¹

Германы Бундестагт эдийн засгийн болон санхүүгийн асуудлыг институцийн хувьд ялган зохицуулдаг бөгөөд санхүүгийн ач холбогдол бүхий бүх хуулийн төслийг хэлэлцэхдээ Төсвийн хорооны санал, дүгнэлтийг заавал авдаг. Энэ нь эдийн засгийн бодлого боловсруулахад төсвийн сахилга бат, хяналтыг чухалчилж байгааг харуулна.¹³²

АНУ (Төлөөлөгчдийн танхим)-ын хувьд Эдийн засгийн асуудлыг нэг хороонд төвлөрүүлэхгүйгээр салбар тус бүрээр хуваарилсан байдаг. Үүнд: Санхүүгийн үйлчилгээний хороо нь банк, мөнгөний бодлого, үнэт цаасны зах зээлийг; Жижиг бизнесийн хороо нь жижиг, дунд бизнесийн хөгжлийг; Эрчим хүч, худалдааны хороо нь үйлдвэрлэл, худалдаа, зах зээлийн зохицуулалтыг тус тус хариуцдаг.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>23.13.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.13.1.боловсрол;</p> <p>23.13.2.жендэрийн тэгш байдлыг хангах бодлого;</p> <p>23.13.3.монгол хэл, бичиг, үндэсний цөөнхийн хэл, бичиг, ёс заншил;</p> <p>23.13.4.мэргэжлийн боловсрол, сургалт;</p> <p>23.13.5.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого;</p> <p>23.13.6.нийтийн биеийн тамир, спорт;</p> <p>23.13.7.соёл, урлаг;</p> <p>23.13.8.түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого;</p> <p>23.13.9.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа;</p>	<p>23.11.Эрүүл мэнд, нийгмийн бодлогын байнгын хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p> <p>23.11.1.эрүүл мэндийн бодлого;</p> <p>23.11.2.хүн амын хөгжлийн бодлого;</p> <p>23.11.3.хүн ам зүй, гэр бүлийн бодлого;</p> <p>23.11.4.хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөдөлмөрийн харилцаа;</p> <p>23.11.5.жендэрийн тэгш байдлыг хангах бодлого;</p> <p>23.11.6.нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, халамжийн бодлого.</p>

¹²⁸ Шинэ Зеланд: (2023). Нийтийн танхимын дэгийн тухай хууль. Хандах: <https://www.parliament.nz/media/10573/standing-orders-2023.pdf>

¹²⁹ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

¹³⁰ Япон: (1947). “Япон Улсын Зөвлөхүүдийн танхимын дэгийн тухай хууль”. Хандах: <https://www.sangiin.go.jp/eng/law/rothoc/index.htm>

¹³¹ Норвег: (2024). “Стортингийн дэгийн тухай хууль” Хандах: https://www.stortinget.no/globalassets/pdf/english/rules-of-procedure_2024.pdf.

¹³² Герман (2022). “Германы Бундестагийн дэгийн журам”. Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>

бодлого; 23.13.10.хүн амын хөгжлийн 23.13.11.шинжлэх ухаан; 23.13.12.эрүүл мэндийн бодлого. /Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн/	
--	--

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Зарим улсын парламент эрүүл мэнд болон нийгмийн бодлогын асуудлыг нэгтгэсэн байдлаар зохион байгуулсан бол, нөгөө хэсэг нь эдгээр асуудлыг тусад нь дагнан эрхлэх хороодоор хуваарилсан байна. Тухайлбал, Франц, Швейцар, Өмнөд Солонгос, Япон, Итали, Эстони зэрэг улсад эрүүл мэнд болон нийгмийн хамгаалал, халамж, хөдөлмөрийн шинжтэй асуудлууд нэг хорооны бүрэн эрхэд төвлөрсөн байна. Францын Нийгмийн асуудлын хороо нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, мэргэжлийн сургалт, эрүүл мэнд, эв нэгдэл, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүл, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын санхүүжилт, цаашлаад нийгмийн оролцоо, боломжийн тэгш байдлын өргөн хүрээний асуудлыг хамарч байгаагаараа хамгийн иж бүрэн чиг үүрэгтэйд тооцогдоно. Үүнтэй адил Швейцарын Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн хороо нь нийгмийн даатгал, нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн салбарын бодлого, хууль тогтоомжийг хамтад нь авч үздэг бол Японы Эрүүл мэнд, халамж, хөдөлмөрийн хороо нь яамны бүтэцтэй уялдан эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн асуудлыг нэгтгэн эрхэлж байна.

Харин Австрали, Канад, Норвег, Шинэ Зеланд, Их Британи, Энэтхэг зэрэг улсад эрүүл мэнд болон нийгмийн бодлогын асуудлыг хоёр ба түүнээс дээш хороонд хуваан эрхлүүлсэн байна. Жишээлбэл, Норвегт Эрүүл мэнд, халамжийн үйлчилгээний байнгын хороо нь эрүүл мэндийн үйлчилгээ, нийтийн эрүүл мэнд, эмийн бодлого, асрамж, халамжийн үйлчилгээг хариуцдаг бол Хөдөлмөр, нийгмийн асуудлын байнгын хороо нь хөдөлмөрийн зах зээл, ажлын орчин, тэтгэвэр, нийгмийн халамж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлогыг тусад нь авч үздэг. Канадын хувьд Эрүүл мэндийн байнгын хороо нь эрүүл мэндийн салбарын асуудлыг дангаар эрхэлдэг бол Хүний нөөц, ур чадвар, нийгмийн хөгжил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байдлын хороо нь нийгмийн хөгжил, тэгш оролцоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг өргөн хүрээнд хариуцаж байна. Их Британи ч мөн адил Эрүүл мэнд, нийгмийн халамжийн сонгох хороогоор дамжуулан эрүүл мэндийн салбар дахь бодлого, зардал, үйл ажиллагаанд хяналт тавьж, харин Ажил, тэтгэвэр тэтгэмжийн сонгох хороо нь хөдөлмөр эрхлэлт, тэтгэмж, нийгмийн хамгааллын асуудлыг тусад нь хянан хэлэлцдэг.

АНУ-ын Төлөөлөгчдийн танхимын жишээ нь дээрх орнуудаас тодорхой ялгаатай байна. Тухайлбал, эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал нь нэг хороонд төвлөрөх бус, хэд хэдэн байнгын хорооны харьяанд функцээр нь хуваагдан эрхлэгддэг. Эрчим хүч, худалдааны хороо нь биоанагаахын судалгаа, эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд, хорио цээрийн асуудлыг; Боловсрол, ажиллах хүчний хороо нь хөдөлмөр, мэргэжлийн нөхөн сэргээлт, ажилчдын нөхөн олговрыг; Зам, сувгийн хороо нь нийгмийн хамгаалал болон цалингийн суутгалаар санхүүждэг эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг тус тус хариуцдаг. Энэ нь бодлогын асуудлыг салбараар бус, санхүүжилт, эрх зүйн зохицуулалт, институцийн хуваарилалтаар ангилан авч үздэг парламентын тогтолцооны онцлог зохицуулалт байна.¹³³

Мөн зарим улсын хороодын чиг үүрэг нь яамдын бүтэцтэй шууд уялдсан байхад, заримынх нь хувьд нийгмийн бүлэг, бодлогын зорилтот чиглэлээр тодорхойлогдож байна. БНСУ-ын Эрүүл мэнд, халамжийн хороо, Японы Эрүүл мэнд, халамж, хөдөлмөрийн хороо нь холбогдох яамдын эрхлэх асуудлаар хүрээгээ тогтоож байгаа бол Франц, Шинэ Зеланд, Энэтхэгийн жишээнд хороо нь яамны бүтэцээс гадна нийгмийн тэгш байдал, оролцоо, эмзэг бүлгийн хамгаалал, гэр бүлийн бодлого зэрэг нийгмийн өргөн хүрээний асуудлыг багтаан авч үздэг байна.

¹³³ АНУ: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн журам”. Хандах: <https://cha.house.gov/cache/files/5/3/5361f9f8-24bc-4fbc-ac97-3d79fd689602/1F09ADA16E45C9E7B67F147DCF176D95.118-rules-01102023.pdf>

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>25 дугаар зүйл. Байнгын хорооны бүрэлдэхүүн 25.1.Байнгын хороо 32 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болно.</p>	<p>25 дугаар зүйл.Байнгын хорооны бүрэлдэхүүн 25.1.Байнгын хороо 32 21 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүн нэгэн зэрэг хоёроос илүүгүй Байнгын хороонд харьяалагдан ажиллаж болно. /Энэ хэсэгт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./ 25.2.Байнгын хорооны бүрэлдэхүүнийг батлахдаа Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцаа болон нам, эвслийн Улсын Их Хуралд авсан суудлын хувийг харгалзана.</p>
<p>25.3.Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн зөвхөн нэг Байнгын хороонд харьяалагдана.</p>	<p>25.3.Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн зөвхөн нэг Байнгын хороонд харьяалагдана.</p>
<p>25.4.Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн өөрийн эрхлэх асуудал нь хамаарах Байнгын хорооны бүрэлдэхүүнд орохгүй.</p>	
<p>25.5.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд гурваас илүүгүй байна. /Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>25.5.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн хоёроос илүүгүй байна.</p>
<p>25.7.Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно.</p>	<p>25.7.Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгоно.</p>
<p>-</p>	<p>25.8.Байнгын хорооны даргыг дахин болон улируулан сонгох бол энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан сонгоно.</p>
<p>25.8.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны даргаар ажиллахгүй.</p>	<p>25.9.</p>
<p>25.9.Байнгын хорооны дарга долоо ба түүнээс дээш хоногоор түр эзгүй байх тохиолдолд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар үүргийг нь аль нэг гишүүнд орлуулж гүйцэтгүүлнэ. Хэрэв долоогоос доош хоногоор эзгүй байх тохиолдолд Байнгын хорооны дарга албан үүргээ өөр гишүүнд түр хариуцуулна.</p>	<p>25.10.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентын байнгын хорооны бүрэлдэхүүний тоог тогтоох арга нь тухайн улсын парламентын бүтэц, улс төрийн тогтолцоо, дотоод зохион байгуулалтын онцлогоос хамааран өөр өөрөөр зохицуулагдсан байна. Харьцуулан үзэхэд байнгын хорооны гишүүдийн тоог тогтоох зохицуулалтыг ерөнхийд нь математик хувь хэмжээ, тогтмол тоон хязгаар, парламентын удирдлагын байгууллагын шийдвэр гэсэн үндсэн гурван загварт ангилж болохоор байна.

Нэгдүгээрт, зарим улс байнгын хорооны бүрэлдэхүүний хэмжээг парламентын нийт гишүүдийн тоотой уялдуулан математик харьцаа, хувь хэмжээний аргаар тогтоож байна. Тухайлбал, Франц Улсад байнгын хороо тус бүрийн дээд хэмжээг Үндэсний ассамблейн нийт гишүүдийн наймны нэгээс хэтрэхгүй байхаар, бүхэл тоонд дээш нь тоймлон тогтоодог. Үүнтэй төстэйгөөр Бразил улсын Төлөөлөгчдийн танхим байнгын хорооны бүрэлдэхүүнийг нийт гишүүдийн тодорхой хувьтай уялдуулж, нэг хороо нь нийт бүрэлдэхүүний 3.5 хувиас багагүй,

12 хувиас ихгүй байх ёстой гэж тогтоосон байна. Ийм зохицуулалт нь парламентын нийт бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдан хороодын хэмжээ уян хатан өөрчлөгдөх боломжийг бүрдүүлдэг онцлогтой.

Хоёрдугаарт, олон улсын жишигт байнгын хорооны бүрэлдэхүүний тоог тогтмол тоон хязгаараар, өөрөөр хэлбэл дэгийн тухай хууль, парламентын дотоод журамд шууд зааж тогтоосон тохиолдол түгээмэл байна. Япон Улсын Зөвлөхүүдийн танхимд байнгын хороодын гишүүдийн тоо хороо тус бүрээр нарийвчлан тогтоогдсон байдаг бөгөөд жишээлбэл, Засгийн газрын асуудал эрхэлсэн хороо 22, Төсвийн хороо 45, Сахилгын хороо 10 гишүүнтэй байна. Их Британи улсад яамдын үйл ажиллагаатай холбоотой сонгон шалгаруулах хороод ихэвчлэн 11 хүртэл гишүүнтэй байхаар тогтоогдсон бол хууль, тогтоолын төсөл хэлэлцэх зориулалттай ерөнхий хороод 16-50 хүртэлх гишүүнтэй байж болдог. Энэтхэг улсад мөн хорооны чиг үүргээс хамааран бүрэлдэхүүний тоо ялгаатай тогтоогдсон бөгөөд Төрийн санхүүгийн хяналтын хороо 22, Төсөв, тооцооны хороо 30, Салбарын байнгын хороод 31 гишүүнтэй байна. Сингапур улсад байнгын сонгон шалгаруулах хороод ихэвчлэн дарга болон 7 гишүүнээс, Австрали улсад ерөнхий зориулалтын байнгын хороод 10 гишүүнээс бүрдэх бөгөөд тодорхой асуудлаар нэмэлтээр 4 хүртэл гишүүн оролцуулж болдог. Канад улсад ихэнх байнгын хороо 10 гишүүнтэй, харин зарим онцгой чиг үүрэг бүхий хороо, тухайлбал Төрийн санхүүгийн хороо 9 гишүүнтэй байна. Итали улсад хороодын бүрэлдэхүүнийг тус бүрийн онцлогт тохируулан тогтоодог бөгөөд, тухайлбал Хууль тогтоох хороо 10, Сонгуулийн хороо 30 гишүүнтэй байхаар зохицуулжээ.

Гуравдугаарт, зарим улс байнгын хорооны бүрэлдэхүүний тоог урьдчилан хатуу тогтоохоос илүүтэйгээр парламентын удирдлагын байгууллага, дотоод захиргааны бүтэц, эсхүл нэгдсэн чуулганы шийдвэрээр шийдвэрлэх эрх бүхий байгууллагад даалган тогтоодог байна. Тухайлбал, Эстони улсад Рийгикогугийн Удирдах зөвлөл байнгын хороодын гишүүдийн тоог тогтоох бүрэн эрхтэй. Шинэ Зеланд улсад парламент бүрийн эхэнд байгуулагддаг Ажил хэрэг эрхлэх хороо бусад хороодын эрх хэмжээг тогтоодог. Швейцар улсад Үндэсний зөвлөлийн товчоо хороодын бүрэлдэхүүний тоог шийдвэрлэх бөгөөд Үндэсний зөвлөлийн байнгын хороод 25, Харин Мужуудын зөвлөлийн хороод 13 гишүүнтэй байхаар тогтсон байна. Норвег улсад Стортинг өөрөө байнгын хороодын гишүүдийн тоог нэмэгдүүлэх, бууруулах шийдвэрийг хэдийд ч гаргах боломжтой байдаг. Энэ төрлийн зохицуулалт нь парламентын ажлын ачаалал, улс төрийн нөхцөл байдал, төлөөллийн хэрэгцээнд нийцүүлэн уян хатан өөрчлөлт хийх боломжийг олгодог байна.

Дээрх ялгаатай зохицуулалтын зэрэгцээ, судалгаанд хамрагдсан орнуудын нийтлэг нэг зарчим нь байнгын хорооны суудлыг улс төрийн нам, эвслийн парламентад эзлэх харьцангуй хүчний харьцаанд нийцүүлэн хуваарилах явдал байна. Өөрөөр хэлбэл, хорооны нийт гишүүдийн тоог ямар аргаар тогтоосноос үл хамааран тухайн суудлуудыг парламент дахь нам, бүлгүүдэд пропорциональ байдлаар хуваарилах зарчим түгээмэл үйлчилж байна. Тухайлбал, Герман улсад Бундестагийн хороодыг парламент дахь бүлгүүдийн харьцангуй хүчтэй уялдуулан бүрдүүлэхийг тусгайлан зохицуулсан бол Өмнөд Африк улсад боломжтой тохиолдолд нам бүр хороонд дор хаяж нэг төлөөлөгчтэй байх ёстой гэж үздэг. Энэ нь байнгын хороо нь зөвхөн мэргэжлийн чиг үүргийн байгууллага төдийгүй улс төрийн төлөөллийн тэнцвэрийг хадгалах институцийн механизм хэмээн үздэгтэй холбоотой байна.

Байнгын хорооны бүрэлдэхүүнийг Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим), Их Британи Улс (Нийтийн Танхим), Герман Улс (Бундестаг), Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс), Европын Холбоо (Европын Парламент)-ыг тус тус дэлгэрүүлэн Өргөдлийн байнгын хорооны жишээгээр авч үзэв. Үүнд:¹³⁴

Тухайлбал, Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)-ын хувьд ӨБХ найман гишүүнээс бүрдэх бөгөөд тэднээс тав нь эрх баригч намын, гурван нь Засгийн газрын бус (сөрөг хүчний/бие даагч) гишүүдээс сонгогдоно (Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэгийн §220(b)). Их Британи Улс (Нийтийн Танхим)-ын хувьд ӨБХ хамгийн ихдээ 11 гишүүнтэй байна (Нийтийн Танхимын хуралдааны дэгийн §145A(2)). Гишүүдийг Засгийн болон сөрөг хүчний намуудаас сонгох бөгөөд бүрэлдэхүүнийг Нийтийн Танхим дахь нийт суудалтай хувь

¹³⁴ ПСХХ (2025). Өргөдлийн байнгын хорооны эрх зүйн зохицуулалт ба үйл ажиллагааны харьцуулсан судалгаа. (СТ-25/239).

тэнцүүлэн тогтооно (Parliament & UK Government, n.d.). Герман Улс (Бундестаг)-ын хувьд ӨБХ-нд тогтсон гишүүдийн тоо байхгүй. ӨБХ-ны бүрэлдэхүүнийг парламент дахь бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна (Бундестагийн хуралдааны дэгийн §12). Гишүүдийг бүлгүүд томилдог. Харин намд харьяалагдаагүй гишүүдийг Бундестагийн Ерөнхийлөгч санал хэлэх эрхтэй боловч саналын эрхгүйгээр ӨБХ-нд орж болно (§57). 2025 оны байдлаар ӨБХ нь 26 гишүүнтэй байна (German Bundestag, n.d.-2). Испани Улс (Төлөөлөгчдийн Конгресс)-ын хувьд ӨБХ-ны гишүүдийг парламент дахь бүлгүүдийн санал болгосноор Төлөөлөгчдийн Конгрессын дарга баталгаажуулж, олон нийтэд зарлана. Тэднийг бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна (Төлөөлөгчдийн Конгрессын хуралдааны дэгийн §40.1-2). ӨБХ-ны удирдах бүтэц (Mesa) нь дарга, хоёр дэд дарга, хоёр нарийн бичгээс бүрдэнэ (§41.1).

Европын Холбоо (Европын Парламент)-ны хувьд Европын Парламентын хуралдааны дэгт ӨБХ-ны гишүүдийн тоог тогтоогоогүй боловч бүрэлдэхүүнийг бүлгүүдийн суудлын тоонд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна. Мөн гишүүдийг сонгохдоо жендерийн тэнцвэрийг хангах шаардлагатай (§216.2). Бүлгүүд хоорондоо тохиролцож ӨБХ-ны бүрэлдэхүүнийг бүрдүүлнэ. Хэрэв тохиролцоонд хүрээгүй бол асуудлыг хурлын дарга шийдвэрлэнэ. Хэрэв бүлэг хугацаандаа нэр дэвшигчээ оруулаагүй бол тухайн суудал хоосон үлдэнэ, өөр бүлгийн гишүүнээр нөхөхийг хориглодог (§216.3).

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>26 дугаар зүйл.Байнгын хорооны даргын чиг үүрэг 26.1.Байнгын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 26.1.1.Байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулах; 26.1.2.Байнгын хорооны өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, хуралдааныг удирдах;</p>	<p>26 дугаар зүйл.Байнгын хорооны даргын чиг үүрэг 26.1.Байнгын хорооны дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 26.1.1.Байнгын хорооны хуралдааны ирцийг бүрдүүлж, бэлтгэлийг хангаж, зохион байгуулах; 26.1.2.Байнгын хорооны өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж, хуралдааныг удирдах;</p>
<p>26.1.5.Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах;</p>	<p>26.1.5.Байнгын хорооны ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнах бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад үед нэгдсэн хуралдаанд заавал оролцож Байнгын хорооны эрхлэх асуудалтай холбоотой асуултад хариулах;</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентын дэгийн зохицуулалтаас үзэхэд байнгын хорооны дарга нь хорооны үйл ажиллагааг зохион байгуулах, хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааныг даргалах, дэг журам сахиулах, түүнчлэн хорооны хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийг парламентын нэгдсэн хуралдаанд танилцуулах үндсэн чиг үүрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, олон улсын практикт байнгын хорооны дарга нь зөвхөн хуралдаан даргалагч бус, харин хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт, төлөөлөл, тайлагнал, хариуцлагыг хангах гол субъект гэж үзэгдэж байна.

Улс орнуудын парламентын дэгийн журамд байнгын хорооны дарга хорооны хуралдааныг товлох, хэлэлцэх асуудлыг төлөвлөх, хуралдааны бэлтгэлийг хангах чиг үүргийг нийтлэг байдлаар тусгасан байна. Тухайлбал, Эстони Улсад хорооны дарга хороог төлөөлөхөөс гадна хорооны ажлын төлөвлөгөө болон хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг хороонд танилцуулах үүрэгтэй. Герман Улсын Бундестагийн дэгийн зохицуулалтаар хорооны дарга хуралдааныг бэлтгэх, зарлан хуралдуулах үүрэгтэй бөгөөд хуралдааны тов, хэлэлцэх асуудлыг тогтоодог. Өмнөд Солонгос Улсад хорооны дарга хорооны хуралдааны хэлэлцэх асуудал, нээх огноо, цагийг тогтоох эрхтэй. Мөн Итали Улсад хорооны дарга хороог төлөөлж, хуралдааныг зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлдэг бол Япон Улсад хорооны хуралдааны огноо, цагийг тогтоох эрхийг хорооны даргад олгосон байна. Швейцар Улсад хорооны ерөнхийлөгч буюу дарга нь хорооны ажлыг төлөвлөж, хэлэлцэх асуудлыг тогтоодог. Эдгээр зохицуулалтаас харахад байнгын хорооны

даргын хуралдааны бэлтгэл хангах, хэлэлцэх асуудлыг төлөвлөх, хуралдааныг зохион байгуулах чиг үүрэг нь олон улсын парламентын нийтлэг практикт хамаарч байна.

Байнгын хорооны дарга нь хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, хуралдааныг удирдах, хорооны дотоод дэг журмыг сахиулах чиг үүрэгтэй байдаг нь олон улсын зохицуулалтад мөн адил тусгагдсан байна. Тухайлбал, Өмнөд Солонгос Улсад хорооны дарга хороог төлөөлж, үйл ажиллагааг хянах, дэг журам сахиулах, хорооны хэргийг удирдах үүрэгтэй. Герман Улсад хорооны дарга хорооны шийдвэрийг хэрэгжүүлж, хуралдааныг даргалдаг. Өмнөд Африкт хорооны дарга нь хорооны хуралдааныг даргалахаас гадна хорооноос олгосон чиг үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, хорооны эрх ашгийг төлөөлөн ажилладаг. Эстони Улсад хорооны дарга хорооны үйл ажиллагааг зохион байгуулж, хуралдааныг даргалдаг бол Швейцар Улсад хорооны ерөнхийлөгч хорооны хуралдааныг даргалах, хороог гадаад харилцаанд төлөөлөх чиг үүрэгтэй байна.

Дээрхээс гадна, байнгын хорооны даргын чиг үүрэгт хорооны хэлэлцсэн асуудал, санал, дүгнэлт, тайланг парламентын нэгдсэн хуралдаанд танилцуулах, шаардлагатай тохиолдолд тайлбар өгөх, асуултад хариулах хамаарч байна. Тухайлбал, Өмнөд Солонгос Улсад хороогоор хэлэлцэж дууссан хуулийн төслийг нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудалд оруулах үед хорооны дарга тухайн төслийн хэлэлцүүлгийн явц, үр дүнг нэгдсэн хуралдаанд тайлагнадаг. Энэтхэг Улсад хорооны тайланг хорооны дарга Танхимд танилцуулах зохицуулалттай. Япон Улсад хорооны дарга тайлан тавихдаа хувийн үзэл бодлоо нэмж илэрхийлэхгүй байх үүрэгтэй гэж заасан нь хорооны дарга зөвхөн хорооны шийдвэр, байр суурийг хариуцан тайлагнах зохицуулалттай. Мөн Өмнөд Африкт хорооны тайланг Танхимд танилцуулж буй хорооны дарга эсхүл тухайн хорооны гишүүн тайлангийн агуулгыг тайлбарлах, тодруулах зорилгоор Ассамблейд хандаж үг хэлэх боломжтой. Герман Улсад хорооны ажлын явцын талаар хорооны дарга эсхүл илтгэгчээр дамжуулан Бундестагт тайлагнахыг парламентын намын бүлэг шаардах эрхтэй. Шинэ Зеландын хувьд хороо тайлангаа баталсан бол хорооны нэрийн өмнөөс дарга гарын үсэг зурж баталгаажуулан Танхимд хүргүүлдэг.

Дээрх улс орнуудын зохицуулалтаас харахад байнгын хорооны дарга нь хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт, хуралдааны бэлтгэл, хуралдаан даргалах, дэг журам сахиулах, хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх, нэгдсэн хуралдаанд тайлагнах зэрэг чиг үүрэгтэй байна. Ялангуяа хорооны ажлыг парламентын нэгдсэн хуралдаанд танилцуулах, тайлбар өгөх, шаардлагатай бол асуултад хариулах зохицуулалт нь БНСУ, Энэтхэг, Япон, Өмнөд Африк, Герман, Шинэ Зеланд зэрэг улсын парламентын практикт тусгагдсан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>27 дугаар зүйл.Дэд хороо 27.3.Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна: /Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./ 27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27 дугаар зүйл.Дэд хороо 27.3.Улсын Их Хурал Байнгын хорооны бүрэлдэхүүнд дараах дэд хороог байгуулна: 27.3.1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Тусгай хяналтын;</p>
<p>27.3.2.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	
<p>27.3.3.Төрийн байгуулалтын байнгын хороонд Бүсчилсэн хөгжлийн, Ёс зүйн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27.3.3.Төрийн байгуулалтын байнгын хороонд Ёс зүйн, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын; 27.3.4.Төсвийн байнгын хороонд Төсвийн зарлагын хяналтын</p>
<p>27.3.5.Хууль зүйн байнгын хороонд Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын, Хүний эрхийн;</p>	<p>27.3.5.Хууль зүй, хүний эрхийн байнгын хороонд Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын, Хүний эрхийн; /Энэ заалтын "Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын" гэснийг 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p>

<p>/Энэ заалтын "Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын" гэснийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p>	
<p>27.3.6.Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд Боловсрол, шинжлэх ухааны, Соёл, спорт, залуучуудын; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	
<p>27.3.7.Эдийн засгийн байнгын хороонд Аялал жуулчлалын хөгжлийн, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн, Инновац, цахим бодлогын хөгжлийн, Тогтвортой хөгжлийн зорилгын. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27.3.7.Эдийн засгийн байнгын хороонд Тогтвортой хөгжлийн зорилгын. /Энэ хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>
<p>27.4.Энэ хуулийн 27.3-т зааснаас бусад дэд хороо байгуулах, татан буулгах, тэдгээрийн дагнан хариуцах асуудлыг харьяалах Байнгын хорооны саналыг үндэслэн нэгдсэн хуралдаанаар шийдвэрлэнэ.</p>	
<p>27.5.Энэ хуулийн 27.3-т заасан дэд хороо дараах асуудлыг эрхэлнэ: /Энэ хэсгийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.1.Агаар, орчны бохирдлын дэд хороо агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах талаарх бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.2.Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.3.Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо боловсрол, шинжлэх ухааны нэгдсэн бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.4.Бүсчилсэн хөгжлийн дэд хороо бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27.5.Энэ хуулийн 27.3-т заасан дэд хороо дараах асуудлыг эрхэлнэ:</p>
<p>27.5.5.Ёс зүйн дэд хороо гишүүний ёс зүй, сахилга, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэг сахиулах асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27.5.5.Ёс зүйн дэд хороо гишүүний ёс зүй, сахилга, хөрөнгө, орлогын мэдүүлэг, чуулганы хуралдааны дэг сахиулах асуудлыг;</p>
<p>27.5.6.Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.7.Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хороо өндөр технологи, үндэсний инновацыг дэмжих, хөгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, цахим хөгжлийн бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.8.Соёл, спорт, залуучуудын дэд хороо соёл, урлаг, түүх, соёл, оюуны өвийг хамгаалах, сэргээх бодлого, нийтийн биеийн тамир, спортын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	

<p>27.5.9.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах, хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.10.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.11.Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг; /Энэ заалтад "тагнуул болон гүйцэтгэх" гэснийг "тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх" гэж 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p> <p>27.5.12.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p> <p>27.5.13.Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх ажиллагаа болон энэ зорилгоор явуулж байгаа тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад гүйцэтгэх ажил /мөрдөн шалгах нууц ажиллагаа/-ын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг; /Энэ заалтыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p> <p>27.5.14.Хүний эрхийн дэд хороо хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын бодлогын асуудлыг; /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	<p>27.5.9.Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хууль тогтоомж болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг;</p> <p>27.5.10.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн хяналтын асуудлыг;</p> <p>27.5.11.Тусгай хяналтын дэд хороо төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт, улсын хил хамгаалалт, төрийн тусгай хамгаалалтын асуудлыг; /Энэ заалтад "тагнуул болон гүйцэтгэх" гэснийг "тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын гүйцэтгэх" гэж 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд уг өөрчлөлтийг 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p> <p>27.5.12.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбогдсон асуудлыг;</p> <p>27.5.13.Хууль сахиулах ажиллагааны тусгай хяналтын дэд хороо хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх ажиллагаа болон энэ зорилгоор явуулж байгаа тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагад харьяалуулснаас бусад гүйцэтгэх ажил /мөрдөн шалгах нууц ажиллагаа/-ын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг; /Энэ заалтыг 2026 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</p> <p>27.5.14.Хүний эрхийн дэд хороо хүний эрх, эрх чөлөөний баталгаа, өршөөл, цагаачлал, иргэний харьяаллын бодлогын асуудлыг;</p>
<p>27.5.15.Хүнс, хөдөө аж ахуйн дэд хороо хүнс, хөдөө аж ахуйн бодлого, хөтөлбөр, хөдөө аж ахуйн хоршооны асуудлыг. /Энэ заалтыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</p>	
<p>27.7.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороодоос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.</p>	<p>27.6.Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлаар гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд бие даан оруулна.</p> <p>27.7.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын болон Ёс зүйн дэд хороодоос бусад дэд хорооны бүрэлдэхүүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн хоёрны нэгээс илүүгүй байна.</p>
<p>27.8.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон есөн гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн</p>	<p>27.8.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон есөн гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна. Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг</p>

харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг баримтална.	баримтална. Ёс зүйн дэд хороо есөн гишүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын дэд дарга нар заавал орно.
27.9.Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно.	27.9.Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд уншиж сонсгосноор тогтоол баталсанд тооцно.
27.10.Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно.	27.10.Дэд хорооны даргыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн олонхын саналаар сонгох бөгөөд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргыг цөөнхийн бүлгийн гишүүдээс, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэхээргүй бол цөөнхийн гишүүдээс сонгоно. Ёс зүйн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын аль нэг дэд даргыг дэд хорооны гишүүд дотроосоо сонгоно.
27.11.Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба түүнийг улируулан сонгож болно.	27.11.Дэд хорооны даргын бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба түүнийг улируулан сонгож болно. Дэд хорооны даргыг улируулан сонгохдоо энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан сонгоно. Дэд хорооны дарга хуралдааны ирцийг бүрдүүлж, бэлтгэлийг хангаж, зохион байгуулах, хуралдаан удирдах болон холбогдох Байнгын хороонд ажлаа хариуцан тайлагнах үндсэн чиг үүрэгтэй.
27.14.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны дүрмийг Төрийн байгуулалтын байнгын хороо батална.	27.14.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын болон Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар Улсын Их Хурал батална.
-	27.15.Дэд хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн орохгүй. 27.16.Дэд хорооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг холбогдох Байнгын хорооны үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлнэ. 27.17.Дэд хорооны дарга долоо ба түүнээс дээш хоногоор түр эзгүй байх тохиолдолд түүний саналыг харгалзан Улсын Их Хурлын даргын захирамжаар үүргийг нь дэд хорооны аль нэг гишүүнд орлуулан гүйцэтгүүлнэ. Хэрэв долоогоос доош хоногоор эзгүй байх тохиолдолд дэд хорооны дарга албан үүргээ өөр гишүүнд түр хариуцуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Германы Бундестагийн хороодыг хууль тогтоох үйл ажиллагааны "цөм" гэж нэрлэдэг (Deutscher Bundestag). Дэд хорооны талаарх нарийвчилсан зохицуулалтыг Бундестагийн дэгийн тухай хууль (Geschäftsordnung - GOBT)-ийн 55 дугаар зүйлд тусгасан байдаг.¹³⁵ Байнгын хороодоос ялгаатай нь дэд хороодыг ихэвчлэн үндсэн хороод нь өөрсдөө байгуулдаг. Бундестагийн дэгийн тухай хуулийн §55(1)-д Хороо нь тодорхой зорилтын хүрээнд гишүүдийнхээ дундаас дэд хороо байгуулж болохоор заасан. Процедурын нэг чухал хамгаалалт нь хорооны гишүүдийн гуравны нэг нь татгалзсан тохиолдолд дэд хороо байгуулахыг хориглодог явдал юм. Энэ нь олонхын бүлэг техникийн хэлэлцүүлгийн үеэр цөөнхийн дуу хоолойг хязгаарлахаас сэргийлэх зорилготой холбоотой байдаг.¹³⁶ Дэд хороод нь ихэвчлэн аль нэг хорооны дотоод нэгж байх боловч мөн хуулийн 54 дүгээр зүйлд байнгын хороотой зэрэгцэн ажиллах "тусгай хороо" (Sonderausschüsse)

¹³⁵ Герман: (2023). "Германы Бундестагийн дотоод журам". Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/10080000.pdf>

¹³⁶ ПСХХ. (2026). "Парламентын дэд хороодын үйл ажиллагааны эрх зүйн орчны талаарх зарим орны харьцуулалт" (СТ-26/411).

байгуулахыг зөвшөөрдөг. Бундестагийн дэд хороод нь албан ёсны боловч үүсмэл шинжтэй бүтцийн нэгжүүд бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүн Бундестаг дахь улс төрийн хүчний харьцааг (Fraktionen) тусгасан байх ёстой.¹³⁷

Дэгийн хуулийн §55(1)-ийн дагуу дэд хорооны гишүүдийг үндсэн хорооны бүрэлдэхүүнээс сонгодог боловч "онцгой тохиолдолд" үндсэн хорооны бус гишүүдийг парламентаас томилж болдог. Энэ нь тухайлбал, Соёлын бодлогын дэд хороо, эсхүл Европын эрх зүйн дэд хороо зэрэгт бусад хорооны нарийн мэргэжлийн шинжээчдийг татан оролцуулах боломжийг олгодог. Дэд хорооны бүрэлдэхүүний тоог үндсэн хороо тогтоодог боловч байнгын хорооноос (30-50 гишүүн) ямагт цөөн тооны гишүүнтэй байдаг. Дэд хорооны дарга, орлогчийг томилохдоо Дэгийн хуулийн 58 дугаар зүйлийг баримтлах бөгөөд Ахлагчдын зөвлөлийн (Ältestenrat) тогтоосон хувь тэнцүүлэх зарчмыг баримталдаг. Бундестагийн дэд хорооны эрх хэмжээ нь үндсэн хорооноос шилжүүлсэн асуудлаар хатуу хязгаарлагддаг. Дэд хороо нь бие даан хууль санаачлах эрхгүй. Харин үндсэн хороонд (lead committee буюу *federführender Ausschuss*) нэгдсэн хуралдаанд оруулах эцсийн зөвлөмжийг бэлтгэж өгдөг байна. Дэд хорооны бүрэн эрх нь үндсэндээ мөрдөн шалгах болон бэлтгэл хангах шинжтэй байдаг. Тэдгээр нь Дэгийн хуулийн 70 дугаар зүйлийн дагуу сонсгол (Anhörungen) зохион байгуулж, шинжээч, засгийн газрын төлөөлөгчдийг дуудаж мэдүүлэг авах эрхтэй. Гэвч тэдний шийдвэр нь зөвхөн зөвлөмжийн шинжтэй байдаг. Дэд хороо шийдвэрийн зөвлөмж бүхий тайланг батлах бөгөөд түүнийг нь үндсэн хороо хэлэлцэж, нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байдаг. Тодорхой асуудлыг дэд хороонд шилжүүлэхдээ үндсэн хорооны албан ёсны санал хураалтаар шийдвэрлэдэг. Дэд хорооны хуралдааны хэлэлцүүлгийн дэг нь хорооны нийтлэг дэгийн хүрээнд (Бундестагийн дэгийн хуулийн §57-74) байна. Үүнд ирцийн шаардлага (§67) болон илтгэгч томилох (§65) зэрэг ордог байна. Германы Бундестагийн нэг онцлог нь хорооны хуралдаанууд ихэвчлэн хаалттай явагддаг соёл юм. Дэгийн хуулийн 69-ийн дагуу улс төрийн өрсөлдөгчид техникийн асуудлаар хоорондоо чөлөөтэй санал солилцох боломжийг олгох үүднээс хуралдааныг олон нийтэд хаалттай явуулдаг.² Харин олон нийтэд мэдээлэл өгөх, хөндлөнгийн шинжээч оролцуулах зорилгоор нийтийн сонсголыг (§70) онцгой тохиолдолд зохион байгуулдаг.

Франц Улсын Үндэсний ассамблей дахь дэд нэгжүүдийн эрх зүйн үндэс нь Үндэсний Ассамблейн Дэгийн хууль (Règlement de l'Assemblée nationale - RAN)¹³⁸ юм.⁹ Тус дэгийн хуульд "sous-commission" буюу дэд хороо гэсэн тогтсон институцийн ангилал байхгүй боловч үүний оронд мэдээллийн түр бүлэг (missions d'information) болон мөрдөн шалгах комисс (commissions d'enquête) гэсэн дэд нэгжүүдийг байгуулан ажиллуулдаг. Тус хуулийн 145-1 дүгээр зүйлд байнгын хороод тодорхой асуудлаар дэд нэгж байгуулахыг зөвшөөрдөг. Мөн III хэсгийн V бүлэгт (145-аас 145-8 дугаар зүйл) хороодын "мэдээлэл цуглуулах үүрэг"-ийг тодорхойлсон бөгөөд үүнийг мэдээллийн түр бүлэг байгуулах байдлаар дамжуулан гүйцэтгэдэг. Дэд нэгжүүд нь түр шинжтэй бөгөөд даалгавар биелсэн эсвэл бүрэн эрхийн хугацаа дуусахад татан буугдана. Мэдээллийн түр бүлгийг нэг хорооны дэргэд эсвэл хэд хэдэн хороо хамтран (missions communes) байгуулж, засгийн газрын тодорхой үйл ажиллагааг салбар дундын түвшинд хянан шалгах боломжтой болдог (Assemblée nationale, 2023). Дэд нэгжүүдийн эрх хэмжээ нь Дэгийн хуулийн 36 дугаар зүйлд заасан үндсэн хорооны чиг үүргээс урган гардаг. Тэд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх болон гүйцэтгэх засаглалд хяналт тавих хоёр үндсэн чиглэлд анхааран ажилладаг. Францын Үндэсний ассамблейн дэд нэгжүүдийн нэг онцгой бүрэн эрх нь "мөрдөн шалгах бүрэн эрх" (pouvoirs d'enquête)-ийг олж авах боломж юм. Дэгийн хуулийн 145-5 дугаар зүйлийн дагуу Ассамблей нь дэд нэгж эсхүл мэдээллийн түр бүлэгт зургаан сараас илүүгүй хугацаагаар албан ёсны мөрдөн шалгах комиссынхтой адил бүрэн эрх олгож болно. Үүнд аливаа этгээдийг байцаалтад дуудах эрх багтах бөгөөд дуудсан хугацаанд ирээгүй тохиолдолд 7500 еврогийн торгууль ногдуулах эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна (Assemblée nationale, 2024). Итали Улсын парламентын тогтолцоо нь тус улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлээр баталгаажсан хороодын хараат бус, бие даасан байдлаар тодорхойлогддог (Camera dei deputati, 2025).¹⁵ Депутатуудын танхим (Camera dei Deputati) нь хорооны ажил болон нэгдсэн хуралдааны

¹³⁷ Герман: (2023). "Германы Бундестагийн дотоод журам". Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/10080000.pdf>

¹³⁸ Франц: (2009). "Үндэсний Ассамблейн дотоод журам" (Règlement de l'Assemblée nationale). Хандах: https://www.assemblee-nationale.fr/dyn/17/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale

мэтгэлцээнийг холбох үүднээс "Есийн хороо" (Comitato dei nove) зэрэг нарийн мэргэшсэн дэд хороодын бүтцийг ашигладаг (Camera dei deputati).

Депутатуудын танхимын дэгийн тухай хууль (Regolamento della Camera - RC)¹³⁹-иар хороо, дэд хорооны үйл ажиллагааны нарийвчилсан журмыг тогтоодог. Тус дэгийн хуулийн §22.4-д зааснаар "Хороод нь өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлыг хэлэлцэх зорилгоор байнгын дэд хороо байгуулж болно." "Есийн хороо" (Comitato dei nove) гэдэг нь Дэгийн хуулийн §79.12 дүгээр зүйлийн дагуу байгуулагддаг заавал байх ёстой нэгж юм. Энэ нь хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулах (sede referente) шатанд байгуулагддаг бөгөөд энэ нь зөвхөн практик бус, харин хууль тогтоох үйл явцын албан ёсны шаардлага юм. Бүтэц, бүрэлдэхүүний хувьд, Есийн хороо нь илтгэгч (relatore) болон улс төрийн бүлгүүдийн хувь тэнцүүлсэн төлөөлөл бүхий нийт 9 гишүүнээс бүрддэг. Үндсэн хороо хуулийн төслийн ерөнхий хэлэлцүүлгийг дуусгаж, чуулганы танхимд оруулах эцсийн бичвэрийг боловсруулсны дараа энэхүү хороог томилдог. Есийн хорооны гишүүд чуулганы нэгдсэн хуралдааны үеэр танхимын төв хэсэгт, депутатуудын суудлын яг өмнө байрлах хагас дугуй ширээнд суудаг. Энэ нь тэднийг хорооны "өргөтгөсөн төлөөлөл" гэдгийг илтгэж, нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн явцад танхимд байнгын лавлагаа, тодруулга өгөх үүргийг хүлээлгэдэг. Италийн дэд хороодын эрх хэмжээ нь үндсэн хорооноос бүрэн хамааралтай байдаг. Байнгын дэд хороод нь бусад хороодод шилжүүлсэн хуулийн төслүүдэд "дүгнэлт" (pareri) өгөх, эсвэл засгийн газрын зохицуулалтыг (atti del Governo) урьдчилан хянахад ихэвчлэн ашиглагддаг. Есийн хорооны бүрэн эрх нь хуулийн төслийн "заалт бүрээр хэлэлцэх" шатанд онцгой ач холбогдолтой. Тэд нэгдсэн хуралдаан хэлэлцүүлэгт санал болгосон нэмэлт өөрчлөлт бүрд хорооны дүгнэлтийг илэрхийлэх эрхтэй. Хэдийгээр тэдний санал дүгнэлтийг Танхимд заавал хүлээн авах үүрэггүй ч илтгэгчийн болон Есийн хорооны дэмжсэн санал нь процедурын хувьд асар жинтэй байдаг бөгөөд олонхын санал хураалтын чиг баримжаа болдог байна.

Вестминстерийн уламжлалтай Их Британид Нийтийн танхим (House of Commons)-ын дэд хороодын эрх зүйн үндэс нь Нийтийн танхимын Дэг (Standing Orders - S.O.)¹⁴⁰-д тусгагдсан байдаг. Тус дэгийн салбарын хяналтын хороодын асуудлыг зохицуулдаг §152(3)-т "салбарын хороо бүр дэд хороо томилж болно" гэж заасан байдаг. Стандартын хороо зэрэг бусад хороодод энэхүү эрхийг өөр тусгай дэгээр олгодог байна (UK Parliament).¹⁴¹ Хэрэв тухайн хороонд дэд нэгж байгуулах эрх олгосон нөхцөл, журам дэгд байхгүй бол тухайн хороо Танхимаас тусгайлан "Танхимын захирамж" (Order of the House) гаргуулан авах ёстой. Энэ нь Их Британийн парламентыг Герман эсвэл Австрали зэрэг бүх хороодод ерөнхий эрх олгодог тогтолцооноос ялгаатай болгодог байна. Бүтэц, зохион байгуулалтын хувьд Их Британийн Нийтийн танхимын дэд хороод нь хуралдааны хүчинтэй ирцийн дээд хэмжээ (ихэвчлэн гурван гишүүн) болон "ажилтан, бичиг баримт, бүртгэл шаардах" бүрэн эрх бүхий Парламентын албан ёсны бүтцийн нэгжүүд юм.¹⁷ Үндсэн хороо нь дэд хорооны гишүүд болон даргыг томилдог. Нийтийн танхимын бас нэг онцлог шинж нь "албан бус зохицуулалт" (informal arrangements) ашиглах явдал байдаг. Хэрэв хороонд дэд хороо байгуулах албан ёсны эрх байхгүй бол тодорхой гишүүд тогтмол уулзаж, тодорхой асуудлыг судлахаар албан бусаар хэлэлцэн тохиролцож болно. Гэвч эдгээр бүлэг нь албан ёсны статусгүй тул бие даан тайлагнах эсвэл албадан мэдүүлэг авах эрхгүй, гагцхүү тэдний ажлыг үндсэн хороо нь албан ёсоор хүлээн зөвшөөрсний дараа л эрх зүйн хүчин төгөлдөр болно (UK Parliament). Дэд хороо Танхимд ажлаа шууд хариуцан тайлагнадаггүй тэд зөвхөн өөрийг нь байгуулсан үндсэн хороонд ажлаа тайлагнана. Үндсэн хороо тайланг албан ёсоор "хүлээн зөвшөөрсний" дараа л Нийтийн танхимын баримт бичиг болгон нийтэлнэ. Дэд хорооны гаргасан шийдвэрүүд нь зөвхөн зөвлөмжийн шинжтэй байдаг. Тэд тайлангийн төсөл боловсруулж, санал, дүгнэлт болгох боловч эдгээр бичиг баримтуудын улс төрийн болон эрх зүйн жин нөлөө нь үндсэн хорооны эцсийн шийдвэрээс л хамаардаг.

¹³⁹ Итали: (2025). "Төлөөлөгчдийн танхимын дотоод журам" (Rules of Procedure of the Chamber of Deputies). Хандах:

https://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/Regolamento_ENG.pdf

¹⁴⁰ Их Британи: (2012). "Нийтийн танхимын дотоод журам". Хандах:

<https://publications.parliament.uk/pa/cm201213/cmstords/614/body.htm>

¹⁴¹ Их Британи: (2012). "Нийтийн танхимын дотоод журам". Хандах:

<https://publications.parliament.uk/pa/cm201213/cmstords/614/body.htm>

Австрали Улсын нь Дэгийн тухай хуулийн §234-д¹⁴² Танхимын аливаа хороо гурав ба түүнээс дээш гишүүнтэйгээр дэд хороо байгуулж болохоор заасан. Энэ нь хороо бүрд тусгайлсан нөхцөл, журам шаардалгүйгээр хорооны эрх мэдлийг түгээмэл байдлаар зохицуулснаараа Их Британи Улсаас ялгаатай. Иймээс дэд хорооны зохион байгуулалт Австралийн Парламентын хороодын тогтолцоонд түгээмэл хэрэглэгддэг бөгөөд Вестминстерийн загвартай бусад улс орноос харьцангуй илүү институцижсэн байдаг (Parliament of Australia). Австралийн дэд хорооны гишүүдийг үндсэн хорооноос нь сонгодог. Тэдгээр дэд хорооны гол онцлог нь ирцийн босгыг маш доогуур тавьдаг, тухайлбал дэд хороо үйл ажиллагаа явуулахад ердөө хоёр гишүүн байхад л хангалттай. Энэ нь алслагдсан бүс нутгуудад очиж мэдээлэл цуглуулах, газар дээр нь шалгалт хийх боломжийг олгодог гэж үздэг байна (Parliament of Australia). Австралийн дэд хороод зөвхөн үндсэн хороондоо ажлаа хариуцан тайлагнана. Тэд тайлангийнхаа хамт хуралдаан бүрийнхээ тэмдэглэлийг ирүүлэх үүрэгтэй. Өөр нэг чухал зохицуулалт бол дэд хорооны түвшинд "албан ёсны тусгай санал" (dissenting report) гаргах заалт байдаггүй. Хэрэв гишүүн дүгнэлттэй санал нийлэхгүй байвал тайланг үндсэн хорооны түвшинд хэлэлцэх үед саналаа албан ёсоор тэмдэглүүлэх ёстой (Parliament of Australia).

Өмнөд Африк Улсын хувьд, хороодын үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг Үндэсний Ассамблейн дэг (9 дүгээр хэвлэл)¹⁴³-ээр тодорхойлдог. Дэгийн §151-ээр хороодод дэд хороо байгуулах эрх олгосон. Түүнчлэн, Үндэсний Ассамблейн Дэгийн хороо нь өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах дэд хороодыг тусгайлан томилох бүрэн эрхтэй. дэд хороо нь "хорооны дотоод бүтэц" байдлаар зохицуулагдаж, хороо өөрөө (parent committee) тодорхой нөхцөл хангагдсан үед дэд хороог байгуулна. Тодруулбал, хороо нь (i) дэгт шууд заасан тохиолдолд, эсхүл (ii) Ассамблейн тогтоолоор зөвшөөрөгдвөл дэд хороо байгуулж болно. Өмнөд Африкийн Үндэсний ассамблейн хороод, түүний дотор дэд нэгжүүд нь Парламент дахь улс төрийн намуудын төлөөлөл болон харьцааг хатуу баримталдаг (Parliament of the Republic of South Africa). Дэгийн §172 дугаар зүйлд зааснаар нэгдүгээрт, дэд хороо нь үндсэн хорооныхоо өмнө хариуцлага хүлээнэ (accountable). Хоёрдугаарт, дэд хороо нь үндсэн хорооны тогтоосон бодлогын хүрээнд, мөн дэг болон үндсэн хорооны гаргасан заавар, удирдамж, журамд нийцүүлэн үүргээ гүйцэтгэнэ. Дүрмийн хороо нь дараах байнгын дэд хороодыг ажиллуулдаг: Үүнд, 1) Ассамблейн дүрмийг хянах дэд хороо: Танхимын дүрмийг тасралтгүй үнэлж, шинэчлэх үүрэгтэй; 2) Гишүүнийг танхимаас албадан гаргах асуудал эрхэлсэн дэд хороо: Нэгдсэн хуралдааны үеэрх сахилгын журмыг хариуцдаг нарийн мэргэшсэн байгууллага байна. Үндсэн хороо нь дэд хорооны бүрэлдэхүүнийг өөрийн гишүүд дотроос томилно. Энэ нь дэд хороо нь "шинэ" улс төрийн төлөөллийн бүтэц үүсгэхээс илүүтэй, үндсэн хорооны бүрэлдэхүүний хүрээнд ажиллах (representation continuity) зарчмыг баримталж байгаа хэрэг юм. Хороо болон дэд нэгжүүд нийтийн сонсгол зохион байгуулж, сонирхогч этгээдүүдийн саналыг хүлээн авах ёстой. Энэ нь Үндсэн хуулиар хүлээсэн үүрэг бөгөөд олон нийтийн оролцоог хангаагүй тохиолдолд тухайн хуулийг Үндсэн хуулийн цэцээс хүчингүйд тооцох үндэслэл болдог байна.

Харьцуулсан судалгаанаас харахад эх газрын эрх зүйн бүл (Герман, Франц, Итали) болон англо-саксоны эрх зүйн бүл (Их Британи, Австрали)-ийн хооронд дэд хороодын эрх зүйн зохицуулалтын хувьд зарчмын ялгаа ажиглагдаж байна. Үүнд: Эх газрын эрх зүйн бүлд дэд хороод, тэдгээрийн бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа зэргийг өндөр түвшинд нарийвчлан хуульчилсан байна. Герман болон Францын Дэгийн хуулиудад тэдгээр хороодын зорилт, чиг үүрэг, эрх хэмжээ, ажиллах хугацаа, мөрдөн шалгах бүрэн эрхийг нарийн тодорхойлсон байдаг. Мөн дэгийн хуульд нь тухайн дэд нэгж байгуулагдах нөхцөл, журмыг (жишээ нь, Германы 1/3-ийн эсэргүүцэл) тусгайлан нарийн тодорхой заасан байна. Англо-саксоны эрх зүйн бүлд хандлага нь илүү "зөвшөөрлийн" шинжтэй боловч шатлан захирах бүтэц нь хатуу тогтсон байна. Дэд хороод нь зөвхөн үндсэн хорооноос шилжүүлсэн эрх мэдлийн хүрээнд л үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Дэгээр тусгайлан дэд хороод нь үндсэн хорооноосоо тусдаа эрх зүйн бие даасан байдалгүй гэдгийг онцлон зохицуулсан байна. Гэрчийг дуудах (subpoena

¹⁴² Австрали: (2025). "Төлөөлөгчдийн танхимын дотоод болон хуралдааны журам". Хандах: https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders

¹⁴³ Өмнөд Африк: (2016). "Үндэсний Ассамблейн дотоод журам". Хандах: https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf

power) эрх мэдэл нь нэг гол ялгаатай тал юм. Англо-саксоны тогтолцоонд (Их Британи, Австрали) энэ эрх мэдэл нь Танхимын "дээд" давуу эрх бөгөөд тухайн салбар хороодод, дараа нь дэд хороодод тус тус төлөөлүүлэн шилжүүлдэг. Эх газрын эрх зүйн тогтолцоонд (ялангуяа Франц, Итали) энэ эрх мэдэл нь хуулиар тогтоогдсон байдаг бөгөөд үл биелүүлсэн тохиолдолд ногдуулах шийтгэлийг ерөнхий, эсхүл Дэгийн хуульд тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>28 дугаар зүйл.Хянан шалгах түр хороо</p> <p>28.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна.</p>	<p>28 дугаар зүйл.Хянан шалгах түр хороо</p> <p>28.1.Хянан шалгах түр хороог Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу байгуулна.</p>
<p>28.2.Хянан шалгах түр хороо нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг нотлох баримт цуглуулах, хянан шалгагч, шинжээч томилох, баримт бичигт дүн шинжилгээ хийх, гэрчээс мэдүүлэг авах зэрэг хуульд тусгайлан заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар хянан шалгаж, тайлан, санал, дүгнэлтээ тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.</p>	<p>28.2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Эстони Улсад хууль тогтоомжийн хэрэгжилт болон нийгмийн анхаарлын төвд буй асуудлуудад парламентын зүгээс түр хугацаанд чиглэсэн хяналт тавих тохиолдолд түр (ad hoc) хяналтын хэлбэрийг хэрэгжүүлдэг. Байнгын болон хянан шалгах хороод нь Рийгикогугийн дэг болон дотоод журмын тухай хуулийн дагуу эрх мэдлийнхээ хүрээнд судалгаа, хяналт-шалгалтын тайлан бэлтгэж, Рийгикогуд танилцуулах эрхтэй (§23¹). Мөн Хянан шалгах хороо нь явцын тайланг жилд нэгээс доошгүй удаа, ажлаа дуусгасны дараа эцсийн тайланг парламентын хуралдаанд танилцуулах үүрэгтэй (§20). Эдгээрийн дотроос хоёр гол хэлбэр нь онцлогтой: хянан шалгах хороо байгуулах, үндэсний хэмжээний чухал асуудлыг хэлэлцэх механизм юм. Хянан шалгах хороо байгуулах хэлбэр нь олон нийтийн ашиг сонирхолд хамааралтай тодорхой нөхцөл байдал, үйл явцыг судлан шалгах зорилгоор хэрэгждэг. Рийгикогугийн дэг болон дотоод журмын тухай хуулийн 20 дугаар зүйлд энэ хэлбэрийн хяналтыг дараах байдлаар нарийвчлан зохицуулсан байдаг. Үүнд:

- 1) Рийгикогу олон нийтийн ашиг сонирхолд хамаарах нөхцөл байдлыг шалгах зорилгоор хянан шалгах хороо байгуулах боломжтой;
- 2) уг хороог Рийгикогугийн тогтоолоор байгуулж, бүрэлдэхүүн, чиг үүрэг, бүрэн эрхийн хугацааг тухайн тогтоолд тусгах шаардлагатай;
- 3) хороо нь явцын тайлангаа жилд нэгээс доошгүй удаа, хорооны үйл ажиллагаа дуусгавар болсны дараа эцсийн тайланг Рийгикогуд танилцуулах үүрэг хүлээдэг.

Япон Улсын Парламентад тодорхой асуудлыг судлах, шалгах зорилгоор түр (ad hoc) хороод байгуулдаг. Түр хороодын хувьд Парламентын тухай хуулийн 45 дугаар зүйлд зааснаар, байнгын хорооны харьяалалд хамаарахгүй, эсхүл онцгой анхаарал шаардсан асуудлыг хэлэлцэх зорилгоор байгуулагдсан тусгай хороод нь тухайн асуудлаар гүнзгий судалгаа, шалгалт явуулах, гэрч дуудаж мэдүүлэг авах, баримт бичиг шаардах зэрэг эрхтэй байна. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх дэгийг Парламентын тухай хуулийн 47 дугаар зүйлд зохицуулсан байна. Уг зүйлд байнгын хороо болон түр хороо нь зөвхөн чуулганы хугацаанд өөрт нь шилжүүлсэн асуудлыг хэлэлцэнэ. Парламентын байнгын болон түр хороод нь асуудлыг хэлэлцэх эсэх, түүнийг нэгдсэн хуралдаанд оруулах шаардлагыг Парламентын тухай хуулийн шийдвэрлэдэг (§56). Үүнд:

- хэрэв байнгын хороо тухайн арга хэмжээг нэгдсэн хуралдаанд оруулах шаардлагагүй гэж үзвэл, уг арга хэмжээг хуралдаанд танилцуулахгүй;

- Захиргаа болон дүрмийн байнгын хороо шаардлагатай гэж үзвэл, Парламентад танилцуулагдсан, эсхүл санал болгосон арга хэмжээний агуулгын тайлбарыг хэлэлцүүлэгт сонсоно.

Хяналтын үр нөлөөг хангах тайлангийн механизмын хувьд, парламент хууль хэрэгжилттэй холбоотой асуудалд хороодоор дамжуулан хяналт тавьдаг. Тодруулбал, Парламентын тухай хуулийн дагуу Парламент шаардлагатай гэж үзвэл хороогоос түр тайлан гаргахыг шаардаж болно. Түр тайлан гарсан тохиолдолд тухайн асуудлыг Парламент хэлэлцэх эсэх, эсхүл хугацааг сунган тогтоож болно (§56.3).¹⁴⁴

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>29 дүгээр зүйл.Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ын бүлэг</p> <p>29.7.Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн бол тухайн бүлгийн дарга нь, гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно.</p>	<p>29 дүгээр зүйл.Улсын Их Хурал дахь нам /эвсэл/-ын бүлэг</p> <p>29.7.Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн, эсхүл гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухай бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр хүргүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно.</p>
-	<p>29.15.Бүлгийн даргыг шинээр сонгосон бол энэ талаарх бүлгийн шийдвэрийг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснийг ажлын 5 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонгосноор шинээр сонгогдсон бүлгийн даргын эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Эстони Улсын “Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль”-ийн дагуу бүлэг байгуулах хүсэлтийг Рийгикогугийн Удирдах зөвлөлд анхны хуралдаанаас хойш тав хоногийн дотор гаргаж, бүх үүсгэн байгуулагч гишүүд гарын үсэг зурсан байх, мөн бүлгийн нэр, гишүүд, дарга, дэд даргын нэрийг тусгах ёстой.¹⁴⁵ Харин Германд Бундестагийн журмын дагуу бүлэг байгуулагдсан тухай, түүний нэр, гишүүд, удирдлагын мэдээллийг Бундестагийн Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэх шаардлагатай¹⁴⁶. Франц Улсад Үндэсний Ассамблейн дэгийн журамд зааснаар бүлэг байгуулахдаа улс төрийн тунхаглал, гишүүдийн нэрсийн жагсаалт, бүлгийн даргын нэрийг Ерөнхийлөгчид хүргүүлж, эдгээрийг “Албан ёсны сэтгүүл”-д нийтэлдэг. Италийн Төлөөлөгчдийн танхимын журамд гишүүд анхны хуралдаанаас хойш хоёр хоногийн дотор аль бүлэгт харьяалагдахаа мэдэгдэж, харин бүлэг байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор дүрмээ баталж Танхимын Ерөнхийлөгчид хүргүүлэх үүрэгтэй.¹⁴⁷

Парламентын бүлгийн дотоод зохион байгуулалт, гишүүнчлэлийн зарчимд нийтлэг хязгаарлалтууд үйлчилж байна. Тухайлбал, Эстони (§40), Франц, Итали зэрэг улсын зохицуулалтад гишүүн зөвхөн нэг бүлэгт харьяалагдах ёстой гэж заасан нь парламент дахь улс төрийн зохион байгуулалтын тогтвортой байдлыг хангах зорилготой. Мөн бүлэг өөрийн дотоод удирдлагыг сонгодог нийтлэг зарчим ажиглагдана. Эстони Улсын хуулийн дагуу бүлэг дарга, дэд даргаа сонгох бөгөөд тэдгээр нь Рийгикогугийн дарга, дэд даргын албан тушаалтай давхардахыг хориглосон байдаг.

¹⁴⁴ ПСХХ. (2026). “Парламентаас баталсан хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтын эрх зүйн зохицуулалт” (СТ-25/229). х.17-18.

¹⁴⁵ Эстони: (2003). “Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль”.

Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/521032019014/consolide>

¹⁴⁶ Герман: (2023). “Бундестагийн дэгийн журам”.

Хандах:

https://www.bundestag.de/resource/blob/189744/9c1b5b7dff2bfa0d0b5e8d4e7d1c9f3c/rules_of_procedure-data.pdf

¹⁴⁷ Итали: (2025). “Төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааны журам”. Хандах:

<https://www.webgaapbook.it/allegati/pdf/Regolamento%20-%20INGLESE%20SITO.pdf>

Итали Улсын Төлөөлөгчдийн танхимын журамд бүлэгт харьяалагдаагүй гишүүд “Холимог бүлэг (Mixed Group)” байгуулж, түүний дотор тодорхой нөхцөлд дэд бүлгүүд байгуулах боломжтой байна. Дөрөвдүгээрт, бүлгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, гишүүн элсүүлэх, гарах, хасахтай холбоотой гишүүнчлэлийн өөрчлөлтийг журам мөн тодорхой зохицуулсан байна. Тухайлбал, Эстони Улсад бүлэг шинэ гишүүн элсүүлэх, гишүүнийг гаргах, хасах асуудлыг өөрөө шийдвэрлэж, холбогдох шийдвэрийг бүлгийн дарга Рийгикогугийн Удирдах зөвлөлд хүргүүлдэг. Франц Улсад Үндэсний Ассамблейн дэгийн журмын дагуу бүлгийн бүрэлдэхүүний өөрчлөлтийг тухайн гишүүн (гарах), бүлгийн дарга (хасах), эсхүл аль аль нь (шинээр элсэх) гарын үсгээр баталгаажуулж, “Албан ёсны сэтгүүл”-д нийтэлдэг. Өмнөд Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хуульд гишүүний нам, бүлгийн харьяалалд гарсан аливаа өөрчлөлтийг Хуралдаан даргалагчид “сааталгүйгээр” мэдэгдэх зохицуулалттай байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>30 дугаар зүйл.Бүлгийн эрх, үүрэг 30.1.Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 30.1.2.нэгдсэн хуралдаанд бүлгийг төлөөлж асуулт асуух, хариулах, үг хэлэх гишүүнийг томилох; 30.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 30.1.2-т заасны дагуу томилогдсоноос бусад тухайн бүлгийн гишүүд нэгдсэн хуралдаанд асуулт асууж, үг хэлэхгүй.</p>	<p>30 дугаар зүйл.Бүлгийн эрх, үүрэг 30.1.Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p>
	<p>30.6.Бүлгийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 30.6.1.бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг 30.6.1.бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хуралдаан удирдах; 30.6.2.бүлгийг төлөөлж энэ хуулийн 30.1.5-д заасан завсарлага авах бөгөөд түүний эзгүйд бүлгийн аль нэг дэд дарга уг эрхийг хэрэгжүүлэх; 30.6.3.энэ хуулийн 30.1.9-д заасан ажлын хэсэг байгуулах; 30.6.4.энэ хуулийн 30.1.12-т заасан горимын санал гаргах; 30.6.5.Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах хүрээнд хэлэлцэж байгаа аливаа асуудлаар Улсын Их Хурал дахь улс төрийн зөвшилцлийг хангах арга хэмжээ авах; 30.6.6.Байнгын, дэд бүрэлдэхүүнд орохоор гишүүний гаргасан хүсэлтийг энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзан энэ хуулийн 30.1.6-д заасны дагуу шийдвэрлэх; 30.6.7.энэ хуулийн 30.1.7-д заасан тайланг жил бүр бүлгийн хуралдаанд танилцуулах; 30.6.8.энэ хуулийн 30.1.8-д заасны дагуу хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламент дахь нам, эвслийн бүлгийн дарга нар дараах эрх, үүргийг хэрэгжүүлж байна:

Франц Улсад бүлгийн дарга эсхүл түүний төлөөлөгч нэг төслийг хэлэлцэх үед нэг хуралдааны туршид хамгийн ихдээ хоёр удаа завсарлага авах эрхтэй байдаг (§58(5)).¹⁴⁸ Харин Македон улсад Ассамблейн дарга Парламентын бүлгийн зохицуулагчийн гаргасан хүсэлтээр чуулганы хуралдааныг түр хойшлуулж (завсарлага авч) болно. Парламентын бүлгийн зохицуулагч нь хуралдааны явцад зөвхөн нэг удаа нэг цагийн хугацаатай завсарлага авах тухай хүсэлт гаргах зохицуулалттай байна.¹⁴⁹

Харин улс орнуудын парламентад байнгын хороодын бүрэлдэхүүнийг томилох үйл явц нь намын бүлгүүдийн хувь тэнцүүлсэн төлөөллийг хангах нийтлэг зарчимд суурилдаг. Байнгын хорооны бүрэлдэхүүнийг парламентын намын бүлгүүдийн гишүүдийн тооны харьцааг үндэслэн бүрдүүлдэг бөгөөд намын бүлгүүд гишүүдээ санал болгох болон томилох эрхтэй байдаг. Тухайлбал, Герман Улсад намын бүлгүүд Байнгын хороодод орох өөрийн гишүүдийг болон тэдний орлогч нарыг томилно (§57).¹⁵⁰ Эстони (§26, §28)¹⁵¹ болон Өмнөд Африк (§155)¹⁵² улсуудад намын бүлгүүдэд хороонд ногдох суудлын тоог баталсан болон хороог байгуулснаас хойш ажлын таван өдрийн дотор намын бүлгүүд гишүүдээ томилон, энэ тухайгаа зохих ёсоор Парламентын даргад танилцуулна. Харин Өмнөд Солонгос Улсад (§48(1))¹⁵³ намын бүлгийг төлөөлж буй гишүүн (дарга) нь сонгуулийн дараах анхдугаар ээлжит бус чуулган эхэлснээс хойш 2 хоногийн дотор, эсхүл өмнөх гишүүдийн бүрэн эрх дуусахаас 3 хоногийн өмнө гишүүдээ хороонд томилуулах хүсэлтээ Үндэсний Ассамблейн даргад гаргадаг байна.

Дээр дурдсан улсуудын парламентын дэгийн тухай хуульд намын бүлгээс байнгын хороонд томилох, эсхүл санал болгох гишүүдэд тавигдах тусгай шаардлагыг нарийвчлан зохицуулаагүй байна. Гэхдээ Өмнөд Солонгос Улсын хуульд нэг онцлог зохицуулалт бий. Тодруулбал, Үндэсний Ассамблейн Ёс зүйн хяналтын зөвлөх хорооноос тухайн гишүүнийг ашиг сонирхлын зөрчлийн улмаас хараат бусаар ажиллах боломжгүй гэсэн санал дүгнэлт гаргасан тохиолдолд Ассамблейн дарга түүнийг хорооны гишүүнээр томилохоос татгалзах, мөн бүлгийн дарга нь тухайн гишүүнийг томилуулах хүсэлт гаргахгүй байх талаар хуульчилсан байна (§48(2)).

¹⁴⁸ Франц: (2025). “Францын Үндэсний Ассамблейн дэгийн тухай” хууль. Хандах: <https://www.assemblee-nationale.fr/connaissance/reglement.pdf>

¹⁴⁹ УИХТГ. Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл

¹⁵⁰ Герман: Бундестагийн хурадааны дэгийн журам. Хандах: <https://www.btg-bestellservice.de/pdf/80060000.pdf>

¹⁵¹ Эстони: (2003). “Рийгикогугийн үйл ажиллагааны журам болон дотоод журмын тухай хууль”. Хандах: <https://www.riigiteataja.ee/en/eli/521032019014/consolide>

¹⁵² Өмнөд Африк: Үндэсний Ассамблейн журам (2016). Хандах: https://www.parliament.gov.za/storage/app/media/Rules/NA/2016-09-28_NA_RULES.pdf

¹⁵³ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

ТАВДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРАЛ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
37 дугаар зүйл.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх 37.1.Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үйл ажиллагаа болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэх бөгөөд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:	37 дугаар зүйл.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх 37.1.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх журмыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын хяналт бол хууль тогтоох байгууллагын гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг институцийн болон эрх зүйн түвшинд хэрэгжүүлэх үндсэн механизм юм.

Парламентын хяналтын эрх зүйн орчин нь Үндсэн хуульд суурилсан бөгөөд тус бүрийн парламент дотоод зохицуулалт, тусгай хууль, хяналтын институцээр дамжуулан тогтолцоог бүрдүүлжээ. Хяналт нь зөвхөн Засгийн газрын тайланг сонсох төдийгүй хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлэх, аудит, гомдол шийдвэрлэх, хариуцлага тооцох хүртэл хүрээг хамардаг нь парламентын бодит хяналтын чадавх, тогтолцооны ач холбогдлыг илтгэж байна.

Их Британи, Герман, Өмнөд Солонгос, Эстони, Шинэ Зеланд, Япон улсуудын эрх зүйн орчныг шинжлэхэд, дараах нийтлэг ба ялгаатай онцлогууд ажиглагдаж байна.

Эдгээр улсуудын Үндсэн хуульд парламент гүйцэтгэх засаглалд хяналт тавих бүрэн эрхтэй гэж тодорхой заасан байна. Тухайлбал, Герман Улсын Үндсэн хуулийн 43 дугаар зүйлд Парламент Засгийн газрын гишүүдийг дуудан байцаах, мэдээлэл авах эрхтэйг заасан бол Өмнөд Солонгос Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлд Үндэсний Ассамблейн төрийн үйл ажиллагаанд шалгалт явуулах эрхийг хуульчилсан байдаг.

Хууль тогтоох байгууллага бүр дотоод журам, парламентын тухай тусгай хууль, хяналтын ажиллагааны тусгай хууль зэргээр хяналтын хэрэгслийн хэлбэр, хэрэгжүүлэх процедур, хариуцлагын механизмыг нарийвчлан зохицуулсан байдаг. Тухайлбал, Герман Улсад Парламентын хяналтын тухай тусгай хууль батлагдсан бол Япон Улсад Аудитын зөвлөлийн тухай хууль, Парламентын тухай хууль зэрэг нь парламентын хяналтын хэрэгжилтийг нарийн зохицуулдаг.

Их Британи, Япон болон Шинэ Зеланд зэрэг улсад хууль батлагдсаны дараах хяналт (post-legislative scrutiny)-ын тогтолцоо бүрдүүлсэн байна. Энэ нь тухайн хууль бодлогын зорилгоо биелүүлсэн эсэхийг үнэлж, хэрэгжилтэд суурилсан өөрчлөлт, шинэчлэлийг хийхэд чухал суурь болдог. Түүнчлэн судалгаанд хамрагдсан бүх оронд үндэсний аудитын байгууллагууд парламентын хараат байдалтайгаар ажилладаг. Эстони Улсад Ерөнхий аудиторыг Рийгикогуугаас томилж, тэрээр тайлангаа жил бүр Рийгикогут танилцуулдаг. Мөн тус улсын Хууль зүйн Канцлер нь хууль ёсны байдалд хяналт тавих институцийн хувьд парламентын хяналтын эрх зүйн бүтцэд хамаардаг онцлогтой.¹⁵⁴

¹⁵⁴ ПСХХ. (2025). “Парламентаас баталсан хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтын эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгаа. (СТ-25/229).

ЗУРГАДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>38 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлага хийх</p> <p>38.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх нээлттэй мэдээллийг Улсын Их Хурлын дарга, гишүүн, нам, эвслийн бүлгийг төлөөлөн дарга, дэд дарга, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны дарга, Тамгын газрын холбогдох албан тушаалтан Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг ашиглан хийнэ.</p> <p>38.2.Энэ хуулийн 38.1-д зааснаас бусад этгээд Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг нийтэд мэдээлэл хийхээр ашиглахыг хориглоно.</p> <p>38.3.Иргэд, дотоод, гадаадын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжлага хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.</p>	<p>38 дугаар зүйл.Улсын Их Хурлын нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлыг хангах, чуулганы үйл ажиллагааг мэдээлэх, сурвалжлах</p> <p>38.1.Улсын Их Хурал чуулганы хуралдаан, хэлэлцэх асуудлын тов, дараалал болон үйл ажиллагааныхаа талаарх мэдээ, мэдээллийг нээлттэй, ил тод мэдээлнэ.</p> <p>38.2.Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хэлэлцүүлгийн явц болон баталсан хууль тогтоомжийн зохицуулалт, ач холбогдлыг хууль санаачлагч гишүүн, ажлын хэсэг, Байнгын хорооны дарга тайлбарлан таниулж мэдээлэл хийнэ.</p> <p>38.3.Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрийнхээ талаарх мэдээллийг нэгтгэн сар бүр нээлттэй мэдээлнэ.</p> <p>38.4.Улсын Их Хурал ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2 дахь долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойш Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг олон нийтэд сурталчлан таниулж, мэдээлэх ажлыг зохион байгуулж болно.</p> <p>38.5.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байна. Улсын Их Хурал энэ хуулийн 38.1-д заасан мэдээ, мэдээллийг нийтэд дамжуулахдаа дохионы хэл, товч бичгэн тайлбар (титр) зэргийг оруулж тусгай хэрэгцээт иргэдэд мэдээллийг хүргэнэ.</p> <p>38.6.Энэ хуулийн 38.5-д заасны дагуу хүртээмжийг хангах асуудлыг Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа холбогдох журамд тусган хэрэгжүүлнэ.</p> <p>38.7.Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаарх нээлттэй мэдээллийг Улсын Их Хурлын дарга, гишүүн, нам, эвслийн бүлгийг төлөөлөн дарга, дэд дарга, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны дарга, Тамгын газрын холбогдох албан тушаалтан Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг ашиглан хийнэ.</p> <p>38.8.Энэ хуулийн 38.7-д зааснаас бусад этгээд Улсын Их Хурлын мэдээллийн индэр, хуралдааны танхимыг нийтэд мэдээлэл хийхээр ашиглахыг хориглоно.</p> <p>38.9.Иргэд, дотоод, гадаадын зочид төлөөлөгчид чуулганы ажиллагаатай танилцах, хэвлэл мэдээллийн байгууллага мэдээлэл, сурвалжилга хийх эрхтэй бөгөөд энэ талаар мөрдөх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Улс орнуудын парламентууд үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод, иргэдэд хүртээмжтэй байлгахын тулд телевиз, радиогийн шууд дамжуулалт, цахим

мэдээллийн систем, иргэдийн оролцоог хангах тусгай механизмуудыг хуульчлан зохицуулсан байдаг. Тухайлбал, Австрали¹⁵⁵, Бразил¹⁵⁶, Өмнөд Солонгос¹⁵⁷, Шинэ Зеланд¹⁵⁸, ОХУ зэрэг улсууд нэгдсэн чуулган, хороодын хуралдааны дуу, дүрсний бичлэгийг өргөн нэвтрүүлгийн суваг, цахим хуудсаар дамжуулан иргэдэд нээлттэй хүргэж байна.

Харин Финланд Улсад нэгдсэн чуулганы тэмдэглэл, гаргасан шийдвэр, парламентын баримт бичгүүд, Засгийн газрын санал зэргийг гарсан даруйд нь мэдээллийн цахим сүлжээнд байршуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангадаг.¹⁵⁹ Швейцар Улсад хороод хуралдааныхаа гол шийдвэрийг олон нийтэд мэдээлэх,¹⁶⁰ харин Македонд Ассамблей нь батлагдсан хууль, гишүүд болон үйл ажиллагааныхаа талаарх бүх мэдээллийг байршуулах албан ёсны цахим хуудастай байхаар¹⁶¹ парламентын дэгийн тухай хуульдаа тусгасан байна.

Мэдээллийн нийтэд хүртээмжтэй байдлыг хангах үүднээс Өмнөд Солонгост парламентын үйл ажиллагааг шууд дамжуулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг бүрэн хүргэх зорилгоор Солонгосын дохионы хэл, хаалттай тайлбар (титр), дэлгэц уншигч зэргийг оруулах нөхцөлийг хуульчилж өгсөн байна (§149(3)).¹⁶²

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
39 дүгээр зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авах, хэлэлцэх	39 дүгээр зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авах, хэлэлцэх
-	39.3.6.нийтийн өргөдлийн цахим системд байршуулж санал авч байгаа нийтийн өргөдөлтэй агуулга нь давхцсан; 39.3.7.энэ хуулийн 39.5-д заасан тоонд хүрч, Байнгын хороо хэлэлцэж эхэлсэн нийтийн өргөдөлтэй агуулга нь давхцсан; 39.3.8.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан төсвийн орлогын доод, зарлагын дээд хэмжээнд нөлөөлөхүйц нийтийн өргөдөл.
39.7.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.3-т заасан тоон гарын үсгээр баталгаажсан байна. <i>/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</i>	39.7.Нийтийн өргөдөлд иргэний санал авахдаа танилт, нэвтрэлтийн систем ашиглан баталгаажуулна.
-	39.8.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл улс орны нийгэм, эдийн засаг, эсхүл цаг үеийн шинжтэй хэлэлцэж байгаа хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, харилцаа холбооны хэрэгслээр иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж болно.

¹⁵⁵ Австрали: (2025). “Төлөөлөгчдийн танхимын дотоод болон хуралдааны журам”. Хандах: https://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders

¹⁵⁶ Бразил: (2006). “Бразил Улсын хууль тогтоох байгууллага: Төлөөлөгчдийн танхим”. Хандах: https://www2.camara.leg.br/english/CD_English.pdf

¹⁵⁷ Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

¹⁵⁸ Шинэ Зеланд: (2023). “Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай” хууль. Хандах: <https://www3.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders>

¹⁵⁹ Финланд: (1999 [2013]). “Парламентын дэгийн тухай хууль”. Хандах: https://www.parliament.fi/EN/naineduskuntatoimii/Documents/parliaments_rules_of_procedure.pdf.

¹⁶⁰ Швейцар: (2024). “Парламентын бүлгүүд (Parliamentary groups)”. Хандах: <https://www.parlament.ch/en/organe/groups>

¹⁶¹ УИХТГ. Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл

¹⁶² Өмнөд Солонгос: (2020) “Үндэсний Ассамблейн тухай хууль”. Хандах: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55306&lang=ENG

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Дэлхийн улс орнуудын эрх зүйн үндэс харилцан адилгүй боловч нийтлэг шинж чанар нь өргөдлийг парламентын институцийн түвшинд холбон бэхжүүлж, иргэдийн оролцоог хангах албан ёсны механизм болгон хөгжүүлжээ.

Австрали, Их Британи, Герман, Испани, Европын Холбооны эрх зүйн орчныг шинжлэхэд, дараах нийтлэг ба ялгаатай онцлогууд ажиглагдаж байна.

Өргөдлийн эрхийг Үндсэн хуулийн түвшинд Герман, Испани, Их Британи (1689 оны Bill of Rights), Европын Холбоо (гэрээнүүд) баталгаажуулсан бол Австрали Улсад тусгаагүй, зөвхөн парламентын дэг ба уламжлалаар хэрэгждэг. Судалгаанд хамрагдсан бүх улсад болон Европын Холбоонд Өргөдлийн байнгын хороог байгуулах, түүний эрх, үүрэг, үйл ажиллагааг парламентын дэгээр нарийвчлан зохицуулдаг байна. Зарим тохиолдолд тусгай хууль (Испани - Өргөдөл гаргах эрхийг зохицуулах хууль; Герман - Өргөдлийн байнгын хорооны хүсэлт, гомдлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим), эсхүл бодлогын баримтаар (Австрали, Их Британи) баталгаажуулсан байна.

Харин өргөдлийн байнгын хороодын эрх, үүргийн зохицуулалтыг харьцуулан судлахад, бүх байнгын хороодын нийтлэг шинж нь өргөдөл хүлээн авч хэлэлцэх, тайлагнах чиг үүрэг бол; ялгаатай тал нь - Их Британи, Герман, Испанид хяналт, мэдээлэл шаардах эрх нь өргөн хүрээтэй байхад Европын Парламент олон нийтийн оролцоо, ил тод байдал, баримт тогтоох шалгалт зэргийг илүү өргөн хүрээтэй эрх, үүрэг болгож төлөвшүүлэн хөгжүүлсэн байна.¹⁶³

Өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх үйл явц улс бүрд харилцан адилгүй зохицуулагддаг ч нийтлэг зарчмаараа тодорхой үе шаттайгаар хэрэгждэг. Австрали, Их Британи, Испанид урьдчилсан шалгалт хийж, өргөдлийг парламентын хуралдаанд танилцуулан холбогдох байгууллагад шилжүүлэх, эсхүл байнгын хорооны хэлэлцүүлэгт оруулах тогтолцоотой. Герман Улс олон нийтийн өргөдөлд тусгай шалгуур тавьж, шаардлагатай дэмжлэг авсан тохиолдолд нээлттэй сонсгол явуулах бөгөөд байнгын хорооны гаргасан шийдвэр, зөвлөмжийг Бундестагт танилцуулдаг. Европын Парламент өргөдлийг бүртгэж, шалгуур хангасан эсэхийг тогтоон, хорооны хуралдаанаар хэлэлцэж, Комисс болон бусад байгууллагаас мэдээлэл авч, жил бүр тайлагнахын зэрэгцээ баримт тогтоох шалгалт зохион байгуулах хүртэл өргөн хүрээтэй ажиллагаа явуулдаг байна.

Ийнхүү өргөдөл шийдвэрлэх үйл явцын нийтлэг зарчим нь: урьдчилсан шалгалт хийх, танилцуулах/нийтлэх, хэлэлцэх, холбогдох байгууллагад шилжүүлэх/тайлагнах, өргөдөл гаргагчид мэдээлэх гэсэн шатлалтай хэрэгждэг бөгөөд улс бүр энэ зарчмыг өөрийн хууль эрх зүйн онцлогт тохируулан тусгажээ. Түүнчлэн Македонд хуулийн төсөл нь олон нийтийн эрх ашгийг хамруулсан тохиолдолд Ассамблей олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдвэрлэж, хариуцах ажлын албыг томилдог. Уг ажлын алба нь хуулийн төслийг иргэд, олон нийтийн байгууллага, сонирхсон этгээдүүдэд нээлттэй нийтэлж, тэднээс гарсан санал, санаа бодлыг цуглуулж цэгцлэн, үр дүнгийнх нь талаар тайлан бэлтгэж Ассамблейд хүргүүлдэг.¹⁶⁴

¹⁶³ ПСХХ. СТ-25/239 Өргөдлийн байнгын хорооны эрх зүйн зохицуулалт ба үйл ажиллагааны харьцуулсан судалгаа

¹⁶⁴ УИХТГ. Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл

ДОЛДУГААР БҮЛЭГ: ГИШҮҮНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДАЛ, БҮРЭН ЭРХИЙН БАТАЛГАА, ТӨСӨВ, ХАВСРАН ГҮЙЦЭТГЭЖ БОЛОХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ ХОРИГЛОХ ЗҮЙЛ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>41 дүгээр зүйл.Гишүүний бүрэн эрхийн баталгаа</p> <p>41.9.Хэрэв гишүүн бүрэн эрх дуусгавар болсноос хойш ажил эрхлээгүй бол 12 сарын хугацаанд гишүүний үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж, бага цалинтай ажилд орсон бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж, гишүүнээр сонгогдохоосоо өмнө оршин сууж байсан газартаа шилжвэл өөрийнх нь болон гэр бүлийн гишүүний замын зардал, ачаа, тээшний хөлсийг авто тээврийн тарифаар тооцож олгоно.</p>	<p>41 дүгээр зүйл.Гишүүний бүрэн эрхийн баталгаа</p> <p>41.9.Гишүүний бүрэн эрх дуусгавар болсон бол Хөдөлмөрийн тухай хуулийн 82.1-д заасны дагуу тэтгэмж олгох бөгөөд тэтгэмж олгохтой холбогдсон журмыг энэ хуулийн 47.4-т заасан захирамжаар батална.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын гишүүдийн цалин, тэтгэмж, бусад хангамж болон бүрэн эрхийн дараах дэмжлэгийг зохицуулах эрх зүйн орчин нь парламентын институцийн төлөвшлийн түвшин, хууль тогтоох байгууллагын хараат бус байдлыг хэрхэн хангах бодлогоос хамаарч харилцан адилгүй зохицуулагдаж байна.

Герман, Дани, Өмнөд Солонгос, Дани улсуудын эрх зүйн орчныг шинжлэхэд, дараах нийтлэг ба ялгаатай онцлогууд ажиглагдаж байна.

Парламентын гишүүний бүрэн эрх дууссаны дараах тэтгэмж, тусламж нь улс төрийн албан тушаалаас хөдөлмөрийн зах зээл рүү шилжих үед үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулж, хууль тогтоох байгууллагын хараат бус байдлыг дэмжих зорилготой. Энэ төрлийн дэмжлэгийн хэлбэр, хэмжээ улс орнуудад маш их ялгаатай байдаг бөгөөд институцийн төлөвлөөс шууд хамаарч байна.

Герман Улсад Бундестагийн гишүүний бүрэн эрх нь дууссан тохиолдолд ажилласан жил тутам нэг сарын тэтгэмж авах бөгөөд нийт авах хугацааны дээд хязгаар 18 сар гэж тогтоосон. Энэхүү шилжилтийн тэтгэмж нь гишүүний төрийн албан өндөр албан тушаалаас бусад салбар руу шилжих шилжилтийг хөнгөвчлөх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилготой. Тэтгэмжийг сар бүрд хувааж, эсхүл нэг удаа авах боломжтой бөгөөд хувийн орлого, ажил эрхлэлтийг харгалзан зохистой хэмжээгээр тооцдог.

Дани Улсад Фолкетингийн гишүүд бүрэн эрх дууссаны дараа 12-24 сар хүртэлх хугацаанд шаталсан дэмжлэг авах боломжтой. Дэмжлэгийн хугацаа нь гишүүнээр ажилласан нийт хугацаанаас хамаарч нэмэгдэх бөгөөд гишүүн өөр орлоготой болох тохиолдолд нөхөн олговрын хэмжээг бууруулж тооцно. Энэ загвар нь Герман Улсын туршлагатай төстэй бөгөөд гишүүний ажлын онцлог, улс төрийн албан тушаалтны тогтворгүй байдал, зах зээлд дахин ажил эрхлэх хүртэлх шилжилтийн зардлыг бодитой нөхөх зорилготой аж.

Өмнөд Солонгос болон Болгарт парламентын гишүүдэд бүрэн эрхийн дараах тэтгэмж буюу шилжилтийн дэмжлэг олгодоггүй байна¹⁶⁵.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
<p>42 дугаар зүйл.Гишүүний төсөвт зардал, цалин, бусад хангамж</p> <p>42.5.Гишүүн батлагдсан төсөвт зардалдаа багтаан зөвлөх, туслах ажиллуулж болох бөгөөд тойргоос сонгогдсон гишүүн бие төлөөлөгч-туслахтай байж болно. Гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.</p>	<p>42 дугаар зүйл.Гишүүний төсөвт зардал, цалин, бусад хангамж</p> <p>42.5.Гишүүн батлагдсан төсөвт зардалдаа багтаан зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслах тус бүр нэгийг ажиллуулж болно. Гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг Улсын Их Хурал батална.</p>

¹⁶⁵ ПСХХ. СТ-25/239 Парламентын гишүүнд олгодог мөнгөн ба мөнгөн бус тэтгэмж, нөхөн олговрууд, тэдгээрийн эрх зүйн зохицуулалт харьцуулсан судалгаа

42.9.Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол Засгийн газрын гишүүний цалин хангамжийг авах бөгөөд Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаатай холбоотой төсөвт туссан бусад зардлыг захиран зарцуулах эрхтэй.	42.9.Гишүүн Засгийн газрын гишүүнээр томилогдвол Засгийн газрын, эсхүл Улсын Их Хурлын гишүүний цалингийн аль нэгийг өөрөө сонгох бөгөөд Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаатай холбоотой төсөвт туссан бусад зардлыг захиран зарцуулах эрхтэй.
42.11.Гишүүн нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй бол түүнд тасалсан өдрийн цалинг олгохгүй.	42.11.Гишүүн хэлэлцэх асуудлын тов, дараалалд орсон ажлын хэсэг, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, санал хураалтад биечлэн оролцоогүй бол түүнд тасалсан өдрийн цалинг олгохгүй.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын гишүүд төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль тогтоох үйл ажиллагаа, парламентын хяналт, байнгын хорооны ажил, сонгогчидтой харилцах төлөөллийн үйл ажиллагаа зэрэг олон төрлийн институцийн механизмыг ашигладаг.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын туршлагаас харахад парламентын гишүүдийн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой хариуцлагын механизм дараах үндсэн хэлбэрээр хэрэгжиж байна.

- парламентын дотоод сахилгын механизм хэрэгждэг. Жишээлбэл, Япон, Өмнөд Солонгос зэрэг улсад парламентын гишүүд хуралдаанд оролцоогүй, эсвэл парламентын дэг зөрчсөн тохиолдолд сануулга өгөх, хуралдаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх, онцгой тохиолдолд бүрэн эрхийг дуусгавар болгох хүртэл арга хэмжээ авах боломжтой байдаг.
- санхүүгийн хариуцлагын механизм ашигладаг. Германд парламентын гишүүн хуралдаанд оролцоогүй тохиолдолд цалин, нөхөн олговроос суутгал хийдэг. Италид мөн адил хуралдаанд оролцоогүй тохиолдолд мөнгөн торгууль ногдуулах практик хэрэглэгддэг.
- парламентын гишүүний хариуцлага нь ихэвчлэн улс төрийн хариуцлагын механизмаар, тухайлбал сонгуулийн өрсөлдөөн, олон нийтийн хяналт, намын дотоод зохион байгуулалтаар дамжин хэрэгждэг.¹⁶⁶

Энэ хүрээнд гадаадын зарим улсын парламентын гишүүнд хариуцлага тооцох хэлбэрүүдээс хуралдааны ирцтэй холбоотой бусад улс орны санхүүгийн шийтгэлүүдийг¹⁶⁷ авч үзэв.

Улс орнуудын хувьд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр парламентын чуулганы хуралдааныг тасалсан гишүүдийн цалин хөлснөөс тодорхой хувь хэмжээгээр суутгах нь тус зөрчилд ногдуулах шийтгэлийн хамгийн түгээмэл хэлбэр байна. (Коста Рика, Кипр, Франц, Габон, Герман, Гватемал, Унгар, Йордан, Люксембург, Парагвай, Польш, Өмнөд Солонгос, Испани, Уругвай гм.)

Санхүүгийн торгууль нь ихэвчлэн тасалсан цагтай уялдах буюу хувь тэнцүүлэн тооцогдоно. Тухайлбал,

Польшийн Сеймийн дэгийн 24 дүгээр зүйлд заасны дагуу Парламентын Маршал (Дарга) нь: 1) гишүүний хүндэтгэн үзэх шалтгаангүй **Парламентын чуулганы** хуралдааныг тасалсан өдөр тутамд, эсхүл тухайн өдрийн санал хураалтын 1/5-аас доошход оролцсон бол цалингийн 1/30-тэй тэнцэх, 2) тухайн сард **хорооны хуралдааны** 1/5-ээс дээшхийг хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй бол Хорооны хуралдааныг тасалсан өдөр тутмын цалингийн 1/30-тэй тэнцэх хэмжээг гишүүний цалин хөлснөөс суутгахаар заасан байна.

Канадын Парламентын тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар “Парламентын аль нэг танхимын гишүүн нэг сарын дотор, эсхүл нэг чуулганы хугацаанд 21-ээс дээш хоног тасалсан

¹⁶⁶ ПСХХ. СТ-26/214 Парламентын гишүүний төлөөлөх бүрэн эрх, түүний хэрэгжилтийн талаарх зарим улс орны харьцуулсан судалгаа

¹⁶⁷ ПСХХ. СТ-25/402 Парламент дахь намын бүлгийн гишүүний үйл ажиллагааг үнэлэх аргачлал

тохиолдолд тасалсан хоног бүрд гишүүний цалин хөлснөөс 120 долларыг суутгана” гэж заасан байна.

Казахстаны Парламентын дэгийн тухай хуулийн 110 дугаар зүйлд зааснаар гишүүн нэг чуулганы хугацаанд Парламентын Танхимуудын хамтарсан хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй тохиолдолд түүний хуралдаанд оролцоогүй өдрийн хөдөлмөрийн хөлсийг олгохгүй гэж заасан байна.

Зарим улсад гишүүнд ногдуулах санхүүгийн торгуулийн дээд хэмжээг тогтоож өгсөн байна. Тухайлбал, Бельгийн Төлөөлөгчдийн танхимын гишүүн хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүй удаа дараа тасалсан бол санхүүгийн торгууль ногдуулах бөгөөд торгуулийн хэмжээ цалингийн 60 хувиас хэтрэхгүй байна.

Ихэнх парламентад зөвхөн нэгдсэн чуулганы хуралдааны санал хураалтад оролцоогүй, хуралдааныг тасалсан гишүүдэд санхүүгийн торгууль ногдуулахаар заасан байна.

Францын Үндэсний Ассамблейн Дэгийн 42 дугаар зүйлд зааснаар гишүүд хуралдаанд заавал оролцоно. Хэрэв гишүүн нь сард 2-оос дээш удаа хуралдаанд хүндэтгэх шалтгаангүйгээр суугаагүй, тасалсан бол гишүүний тухайн сарын хөдөлмөрийн хөлсний 25 хувьтай тэнцэх хэмжээг суутгана гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
44 дүгээр зүйл.Гишүүнд хориглох үйл ажиллагаа	44 дүгээр зүйл.Гишүүнд хориглох үйл ажиллагаа
-	44.2.Гишүүн энэ хуулийн 41.2, 44.1.11-д заасан чуулганы хуралдаанд, эсхүл хуралдаанаас гадуур бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж, доромжилсон бол иргэний маргааны журмаар шүүхэд хандаж болно.

ТАЙЛБАР: Бундестагийн дэгд “улс төрийн шинж чанартай доромжлол” гэх ойлголт байх бөгөөд энэ нь гишүүний халдашгүй байдлыг цуцлах үндэслэл болохгүй. “Ялимгүй доромжлол”-ын төлөө хариуцлага хүлээхгүй харин доромжлол нь гүтгэлгийн шинжтэй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан. ОХУ-ын дэгээр гүтгэсэн үйлдэлдээ захиргааны журмаар хариуцлага хүлээхээр заасан. Харин манай улсын МУИХТХ-ийн 41.7-оор гишүүнд шүүхийн журмаар Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхгүй байхаар заасан. Монгол Улсын Их Хурлын тухай хуулиудыг түүхэн үечлэлээр авч үзвэл гишүүнд шүүхийн журмаар захиргааны хариуцлага хүлээлгэхгүй байх зохицуулалт 1991 оноос эхлэн хэрэгжиж байсан. Иймд манай улсын хувьд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 41.2, 44.1.11-д заасан асуудлыг Эрүүгийн хуульд (ҮХЦ-ийн дүгнэлт хүлээн авсантай холбогдуулан боловсруулсан төслийн зохицуулалт) заасан хариуцлага хүлээлгээд явах хууль зүйн боломж байна. Ёс зүйн дэд хорооны хувьд гүтгэсэн, эсхүл доромжилсон үйлдлийг тогтоох боломжгүй байна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Бундестагийн дэгд “улс төрийн шинж чанартай доромжлол” гэх ойлголт байх бөгөөд энэ нь гишүүний халдашгүй байдлыг цуцлах үндэслэл болохгүй. “Ялимгүй доромжлол”-ын төлөө хариуцлага хүлээхгүй харин доромжлол нь гүтгэлгийн шинжтэй бол эрүүгийн хариуцлага хүлээхээр заасан. ОХУ-ын дэгээр гүтгэсэн үйлдэлдээ захиргааны журмаар хариуцлага хүлээхээр заасан. Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн тухай хууль 146 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн гишүүн нь нэгдсэн хуралдаан эсхүл хорооны хуралдаан дээр бусдыг доромжлох, эсхүл гуравдагч этгээдийн хувийн нууцтай холбоотой асуудлаар үг хэлэхийг хориглосон байдаг. Үүнийг зөрчиж бусдыг доромжилсон, хувийн нууцыг дэлгэж үг хэлсэн гишүүнд сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болдог.

НАЙМДУГААР БҮЛЭГ: УЛСЫН ИХ ХУРАЛ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХ НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
46 дугаар зүйл.Тамгын газар, түүний эрхлэх ажил	46 дугаар зүйл.Тамгын газар, түүний эрхлэх ажил
46.4.Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж нь газар, хэлтэс, алба, хүрээлэн, парламентын номын сан, музей байна.	46.4.Тамгын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж нь газар, хэлтэс, алба, хүрээлэн, парламентын номын сан, музей байна.
46.5.Тамгын газар дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ: 46.5.5.хуульд заасан үндэслэлээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн бусад төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн зөвлөмж гаргах;	46.5.Тамгын газар дараах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ: 46.5.5. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд Байнгын хорооны хүсэлтээр хууль зүйн дүгнэлт гаргах;
46.5.6.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх;	46.5.6.дараах үнэлгээ, дүн шинжилгээ хийх: 46.5.6.а.өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэр хянах шатанд Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.2-т заасан хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланд үнэн бодит байдлын үнэлгээ хийх; 46.5.6.б.хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн шатанд төсөлтэй холбогдуулан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналд зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээг Байнгын хорооны хүсэлтээр хийх; 46.5.6.в.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13.2-т заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх; 46.5.6.г.хуульд заасан холбогдох байгууллагын тайлан, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
46.5.7.Улсын Их Хурлаар тухайн жилийн төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл хэлэлцэхэд дүн шинжилгээ хийж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;	
-	46.5.25. Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд зориулан энгийн, ойлгомжтой, богино хэмжээний дүрс, бичгэн болон зурган зэрэг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэх;
46.5.25.хууль тогтоомжоор даалгасан бусад үүрэг.	46.5.26.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Хууль тогтоох үйл ажиллагаанд парламентын ажлын албаны оролцооны хүрээг улс орнуудын жишээнд харьцуулан судлахад дараах нийтлэг хэв шинж ажиглагдлаа.

Дэлхийн улс орнуудын Парламентын хууль тогтоох эрх мэдлийн хэрэгжилт нь:¹⁶⁸

- Хуулийн төсөл санаачлах;
- Хуулийн төслийг хэлэлцэх;
- Хуулийг батлах гэсэн үндсэн хэсгүүдээр илэрхийлэгддэг, тодорхой дараалал бүхий процесс юм.

Хуулийн төсөл санаачлах процесст: Хуулийн төсөл санаачлах эрхийг дэлхийн улс орнуудад парламентын гишүүд, Ерөнхийлөгч, Засгийн газар хэрэгжүүлдэг. Харин Латин Америкийн зарим улсуудад эдгээрийн зэрэгцээ Дээд шүүх, Аргентин улсад хувь иргэн хуулийн төсөл санаачилж болдог байна. Хуулийн төсөл хэн санаачилснаас үл хамааран парламентын ажлын алба төслийг хүлээн авч хэлэлцүүлэгт бэлтгэх, зохих журмын дагуу хэлбэржүүлэх үүргийг гүйцэтгэдэг нийтлэг жишиг байна.

Хуулийн төсөл санаачлах, боловсруулах үе шатанд парламентын гишүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх нь ажлын албаны гол үүргийн нэг байдаг. Жишээлбэл, Шинэ Зеландын Клеркийн газрын Хууль тогтоомжийн төслийн хэлтэс нь парламентын гишүүд хуулийн төслөө боловсруулахад нь шаардлагатай хууль тогтоомж болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй. Гишүүд шаардлагатай тохиолдолд Хууль зүйн үйлчилгээний албанаас хууль зүйн дүгнэлт гаргуулж, зөвлөгөө тусламж авч болдог. Хуулийн төслийг санаачлах явцад судалгаа, шинжилгээ, мэдээллээр хангах нь ажлын албаны бас нэгэн үүрэг. Хуулийн төсөл санаачлагч тухайн асуудлын бодлогын хувилбарыг үндэслэлтэй, тодорхой болгох үүднээс шаардлагатай асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийлгэдэг.

Ийнхүү хууль тогтоомжид заасан шалгуур болон бүрдлийг хангасан төслийг парламентын ажлын алба хүлээн авсны дараа төслийг хэлэлцүүлэгт бэлтгэдэг.

Хуулийн төслийг хэлэлцэх процесст: Хуулийн төслийг хэлэлцэх үйл явц нь парламентын үндсэн үүрэг болохын хувьд энэ үе шатанд парламентын ажлын алба өндөр үүрэг хариуцлагатайгаар оролцдог. Үүнд:

- Хуралдааны бэлтгэл хангах;
- Хуралдаан, хэлэлцүүлгийг зохион байгуулах;
- Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын зөрүүг арилгахад чиглэсэн зөвшилцөх үйл ажиллагаанд эрх зүй, дүн шинжилгээ, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх гэсэн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Улс орнуудын туршлагаас харахад, парламентын ажлын алба нь тухайн хэлэлцэж байгаа асуудал улсын төсөвт хэрхэн нөлөөлөх, нийгэм-эдийн засгийн байдалд үзүүлэх үр дагаврын талаар тодорхой дүгнэлт гаргадаг. Мөн төслийг хэлэлцэх явцад судалгааны нэгжээс парламентын гишүүдийг судалгаа, мэдээлэл, баримтаар хангадаг.

Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгж нь хэлэлцүүлгийн явцад төслийг эрх зүй, хэл зүйн талаас нь хянах, бусад хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэх, уялдуулах, шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлт гаргах, эрх зүйн тайлбар өгөх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тухайлбал, Их Британи, Герман, Шинэ Зеланд, Итали, Испани зэрэг улсын парламентын ажлын алба нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, засгийн газрын бодлого, яамдын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4. Улс орнуудын парламентын ажлын албаны чиг үүрэг

Ажлын албаны бүтэц / нэр	Үндсэн чиг үүрэг, эрхлэх ажлын хүрээ	Чиг үүрэг
Австрали	Сенатын Ажлын алба,	Сенат, түүний хороод, Сенатын дарга, сенаторуудад хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөх болон туслах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

¹⁶⁸ Дэлхийн улс орнуудын Парламентын ажлын алба ном

	Төлөөлөгчдийн танхимын Ажлын алба,	Төлөөлөгчдийн танхим, хороод, зарим хамтарсан хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах болон танхимын гишүүдийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй.
	Парламентын үйлчилгээний Ажлын алба.	Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газартай зарим чиг үүрэг нь төстэй
Герман	Бундестагийн Ажлын алба,	Парламентын болон гишүүдийн үйлчилгээ, байнгын хороодод үйлчлэх, хууль, төсөв, нийгмийн бодлогын судалгаа шинжилгээ хийх, гадаад харилцааг зохицуулах, мэдээлэл баримт бичгийн систем бүрдүүлэх, иргэдийн өргөдөл гомдол шийдвэрлэх.
	Бундесратын Ажлын алба.	
Их Британи	Хоёр танхимын дундын ажлын алба,	Лордуудын танхим, Нийтийн танхимд хоёуланд нь үйлчилгээ үзүүлдэг Парламентын архив, Боловсролын алба, Парламентын Шинжлэх ухаан, технологийн газар зэрэг алба хамаардаг.
	Нийтийн танхимын ажлын алба,	Зөвхөн Нийтийн танхимд үйлчилгээ үзүүлдэг, тухайлбал, Нийтийн танхимын бүртгэл, лавлагааны алба, Мэдээллийн эрх чөлөөний алба, Хяналт шалгалтын нэгж зэрэг алба орно.
	Лордуудын танхимын ажлын алба.	Лордуудын танхимын хороод, Хүний нөөц, Мэдээллийн эрх чөлөөний алба зэрэг зөвхөн Лордуудын танхим болон түүний гишүүдэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг.
Өмнөд Солонгос	Үндэсний Ассамблейн Тамгын газар, Номын сан, Төсвийн алба, Судалгааны алба.	Хууль тогтоох, төсөв хянах, данс тооцоо хөтлөх, захиргааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах. Төрийн мөнгө, санхүүгийн удирдлага, төсвийн тооцоонд дүн шинжилгээ хийж, үнэлэх. Төрийн бодлогын асуудлаар судалгаа, хяналт шалгалт хийх.
Сингапур	Клеркийн газар буюу Тамгын газар.	Чуулганы хуралдааны бэлтгэл болон явцын ажлыг гүйцэтгэх, батлагдсан хууль тогтоомжийн хууль зүйн нэр томъёо болон бичвэрийн засвар хийх, хянан тохиолдуулах, хэвлэлд бэлтгэх. Хуралдааны тэмдэглэл хөтлөх, парламентын асуулгуудыг томъёолох, мэргэжлийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.
Шинэ Зеланд	Төлөөлөгчдийн танхимын Клеркийн газар, Парламентын үйлчилгээний алба.	Клеркийн газар: Хууль тогтоомж хэлэлцэн батлах, Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд процедурын болон хууль зүйн зөвлөгөө өгөх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, захиргааны үйлчилгээ үзүүлэх, Үйлчилгээний алба: Танхим, гишүүдэд захиргааны болон туслах үйлчилгээ үзүүлэх, санхүүжилтийн асуудлыг хариуцах

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
46.6.Тамгын газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.Энэ журам нь Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.2-т заасан журмаар зохицуулах харилцаанд хамаарахгүй.	46.6.Тамгын газрын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх, албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын Ажлын алба нь Парламентад бүхэлд нь болон Парламентын танхимууд, Байнгын болон бусад хороод /комисс/, Парламентын гишүүдэд хууль тогтоох болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх болон шинжлэх

ухааны судалгаа, техник - зохион байгуулалтын өргөн хүрээтэй үйлчилгээ, туслалцаа дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий төрийн албан хаагчдын байгууллага юм¹⁶⁹.

Дэлхий нийтийн чиг хандлагаас үзэхэд парламентын засаглал сонгодог утгаараа төлөвшсөн, өндөр хөгжилтэй зарим орнууд (тухайлбал Их Британи, АНУ, Австрали, Өмнөд Солонгос гэх мэт)-ын хувьд парламентын үндсэн чиг үүргийг хариуцлагатай, чанартай хэрэгжүүлж хүчирхэг, ардчилсан парламентын засаглалыг төлөвшүүлэхэд парламентын ажлын албаны мэргэшсэн байдал, үзүүлж буй ажил үйлчилгээ, үүнд чиглэсэн хүний нөөцийн бодлого, зохицуулалт, удирдлага, менежментийн арга барил чухал болох нь харагдаж байна¹⁷⁰.

Олон улсын туршлагаас харахад төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг ОХУ-д Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч зарлиг гарган тогтоосон байдаг. Энэ зарлигийн 2 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын Тамгын газрын төрийн албан хаагчдын цалин, сарын мөнгөн урамшууллыг тогтоосон байна.

Австрали улсын хувьд Парламентын ажлын алба (*department of parliamentary services*) нь австралийн төрийн албанаас тусдаа бие даасан статустай бөгөөд эдгээр албад тус тусын хуулиар зохицуулагдана.¹⁷¹ Парламентын ажлын албаны гэрээнд заасны дагуу ажилтнуудын үндсэн болон ажилласан хугацаанаас хамаарсан цалингийн нэмэгдлийг авахаар заасан байдаг. Харин ажилд шинээр орсон, эсхүл ажилтан албан тушаал дэвшсэн тохиолдолд тухайн албан тушаалын хамгийн доод ангиллаар цалинжина. **Тухайн хүний ажлын туршлага, мэдлэг, чадварыг харгалзан Нарийн бичгийн дарга цалинг хамгийн доод ангиллаас өндөр тогтоож болно.** Мөн Парламентын бусад хэлтэс, албадаас эсхүл, төрийн албаны байгууллагуудаас Парламентын ажлын албанд шилжин ирсэн ажилтны цалинг бууруулахгүй олгох зарчим баримталдаг.

Харин Өмнөд Солонгос улсын хувьд Үндэсний Ассамблейн Тамгын газрын төрийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу 1-9 дүгээр түвшний төрийн албан хаагчид болон гэрээт албан хаагчид байдаг. Тамгын газрын төрийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн цалин хөлсний журамд зааснаар үндсэн цалинг тогтоох бөгөөд төрийн албан хаагчийн нэмэгдэлтэй холбоотой харилцааг Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэлтэй холбоотой журмаар зохицуулдаг.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
48 дугаар зүйл.Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрх	48 дугаар зүйл.Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрх
48.1.14.энэ хуулийн 22.3.9-д заасан зөвлөмж гаргах журам, хууль тогтоомжийн төслийн эхийг барьж ажиллах зөвлөхөд тавих тусгай шаардлагыг батлах;	48.1.14.хууль зүйн дүгнэлт, төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх журам, хууль тогтоомжийн төслийн эхийг барьж ажиллах зөвлөхөд тавих тусгай шаардлагыг батлах;
48.2.Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг Байнгын хороо дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.	48.2.Тамгын газрын үйл ажиллагааны тайланг Ерөнхий нарийн бичгийн дарга Төрийн байгуулалтын байнгын хороонд жил бүр танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг Байнгын хороо дүнг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Парламентын ажлын алба нь парламентад бүхэлд нь болон түүний танхимууд, байнгын болон бусад хороод /комисс/, парламентын гишүүдэд хууль тогтоох болон бусад эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь зөвлөх болон судалгаа, шинжилгээ, техник-

¹⁶⁹ ПСХХ. СТ-12/211 Парламентын хууль тогтоох үйл ажиллагаанд ажлын албанаас үзүүлж буй мэргэшсэн үйлчилгээ

¹⁷⁰ ПСХХ. СТ-20/201 Гадаадын зарим орны парламентын ажлын албаны цалингийн систем, нийгмийн баталгаа, хүний нөөцийн бодлого, хөтөлбөрүүдийн талаарх харьцуулсан судалгаа

¹⁷¹ Австрали: (1999). "Парламентын ажлын албаны тухай" хууль. Хандах:

<https://www.legislation.gov.au/C2004A00536/latest/text>

зохион байгуулалтын чиглэлээр өргөн хүрээнд үйлчилгээ үзүүлэх, туслах үүрэг бүхий төрийн байгууллага юм.

Парламентын ажлын алба нь хууль тогтоох үйл ажиллагаанд туслах, захиргааны удирдлагаар дэмжих болон нарийн бичгийн дарга нарын газрын үйлчилгээг хэрэгжүүлэх ба түүнийг Ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл Клерк удирдан зохион байгуулж байна.

Грек, Их Британи, Кабо-Верде, Канад, ОХУ, Самоа, Серб, Унгар, Швейцар, Энэтхэг зэрэг улсын жишээнээс үзэхэд парламентын ажлын албаны дарга нь улс орон бүрд нэршил өөр боловч хэрэгжүүлж буй чиг үүрэг нь агуулгын хувьд нийтлэг дараах 4 үндсэн хэсэгт багтаж байна¹⁷²:

- Захиргаа, удирдлага: Парламентын Тамгын газар (ажлын алба)-ын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хүний нөөц, төсөв санхүү, ажлын байрны дотоод хяналт болон үйлчилгээг хангах.
- Хууль зүй, процедурын зөвлөх: Парламентын дарга (Спикер) болон гишүүдэд хууль тогтоох үйл явц, хуралдааны дэг, хууль эрх зүйн нарийн төвөгтэй асуудлаар мэргэжлийн, хараат бус зөвлөгөө өгөх, чиглүүлэх.
- Бичиг хэрэг, мэдээллийн удирдлага: Парламентын нэгдсэн болон байнгын хороодын хуралдааныг зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, хууль, шийдвэрийн төсөл боловсруулах, баримт бичгийг баталгаажуулах, албан ёсны архив бүрдүүлэх.
- Төлөөлөл болон хамтын ажиллагаа: Парламентын ажлын албыг төлөөлөн Засгийн газар, шүүх, бусад төрийн байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай албан ёсны харилцаа тогтоож, ажлын уялдаа холбоог хангах.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль	Төслийн заалт
	<p>48¹ дүгээр зүйл. Улсын Их Хурлын дэргэдэх хүрээлэн</p> <p>48¹.1. Улсын Их Хурлын үйл ажиллагааг дэмжих зорилгоор хууль тогтоох болон төрийн бодлогын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, холбогдох баримт мэдээлэл бэлтгэх, парламентад ёсны талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиг үүрэг бүхий хүрээлэн Улсын Их Хурлын дэргэд ажиллана.</p> <p>48¹.2. Хүрээлэнгийн дүрэм, бүтэц, орон тоог Улсын Их Хурлын дарга батлах бөгөөд хүрээлэнгийн албан хаагчийн албан тушаалын ангилал зэрэглэл, цалингийн хэмжээг энэ хуулийн 46.7, 46.8-д заасны дагуу тогтооно.</p>

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА: Судалгаа, шинжилгээний ажлын хүрээнд парламентын судалгаа гэсэн бие даасан ангилал буй болсноос хойш багагүй хугацаа өнгөрсөн бөгөөд парламентын судалгааны албад нь хууль тогтоогчдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар шуурхай ханган, оновчтой шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг болохыг тэдгээрийн үйл ажиллагааны олон жилийн түүхэн туршлага харуулдаг. Парламентын судалгааны албад нь үйл ажиллагаандаа бие даасан, хараат бус, тэнцвэртэй, улс төрийн үзэл бодлоос ангид, шуурхай, парламентын гишүүдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх гэсэн үндсэн зарчмуудыг баримтлан ажилладаг ба шуурхай гүйцэтгэл, цаг үеэ олсон байх, бичмэл материал ойлгомжтой, товчхон байх шаардлагыг хангасан байдаг шинж чанараараа академик болон их, дээд сургууль, төрийн болон бусад хэвшлийн судалгааны байгууллагаас ялгарах онцлогтой.

Улс орнуудын парламентын дэргэдэх ажлын албаны бүтэц, зохион байгуулалтаас үзэхэд судалгааны нэгж нь парламентын ажлын албаны үндсэн бүтцэд, эсхүл

¹⁷² ПСХХ. СТ-20/414 Парламентын ажлын албаны даргын чиг үүрэг мэдээлэл, лавлагаа

парламентынхаа харьяанд харьцангуй бие даасан (ажлын албатайгаа ижил статустай) хэлбэрээр ажилладаг байна.¹⁷³

Хүснэгт 5. Улс орнуудын парламентын судалгааны нэгжийн зохион байгуулалтын хэлбэр

Хэлбэр	Улс орнууд
Парламентын Судалгааны нэгж парламентын Ажлын албатай ижил статустай байх хэлбэр	АНУ, Австрали, Өмнөд Солонгос, Вьетнам, Канад, Саудын Араб, Япон
Парламентын Судалгааны нэгж парламентын Ажлын албаны дотоод бүтцэд байх хэлбэр	Австри, Аргентин, Армян, Босни-Херцеговин, Бразил, Габон, Герман, Гүрж, Жибути, Исланд, Их Британи, Кабо-Верде, Камбож, Литва, Марокко, Мексик, Молдова, Монтенегро, Намиби, Норвег, ОХУ, Румын, Серби, Сингапур, Словени, Турк, Украин, Финланд, БНХАУ, Чех, Чили, Швед, Шинэ Зеланд, Эстони, Энэтхэг

Тухайлбал, Өмнөд Солонгос улсын Үндэсний Ассамблейн судалгааны албаны үйл ажиллагааг Үндэсний Ассамблейн судалгааны албаны тухай тусгай хуулиар¹⁷⁴ зохицуулдаг. Тус хуулийн 2 дугаар зүйлд судалгааны албыг Ассамблейн даргын харьяанд байгуулахаар заажээ. Түүнчлэн судалгааны албаны бүтэц, орон тоо, чиг үүрэг болон шаардлагатай бусад асуудлыг Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвшөөрөлтэйгөөр Даргын баталсан дүрмээр тогтоохоор хуульчилсан байна (§6.5, §10).

-----oOo-----

¹⁷³ ПСХХ. СТ-18/225 Гадаадын зарим орны парламентын судалгааны албаны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт харьцуулсан судалгаа

¹⁷⁴ Өмнөд Солонгос: (2021). “Үндэсний Ассамблейн судалгааны албаны тухай” хууль. Хандах: <https://www.law.go.kr/LSW/lsiInfoP.do?lsiSeq=228669#0000>